

FATF



ШИЛДЭГ ДАДАЛ ТУРШЛАГА

АШГИЙН ТӨЛӨӨ БУС  
БАЙГУУЛЛАГУУДЫГ  
ЗҮЙ БУСААР  
АШИГЛАХТАЙ  
ТЭМЦЭХ НЬ  
(8-Р ЗӨВЛӨМЖ)





## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ - FATF) нь дэлхийн санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс хамгаалах бодлогыг боловсруулж, сурталчилдаг хараат бус бие даасан Засгийн газар хоорондын байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах (AML) болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг стандарт (CFT) гэж хүлээн зөвшөөрдөг.

ФАТФ-ын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах вэб хуудсаар зочилно уу

[www.fatf-gafi.org](http://www.fatf-gafi.org)

© 2015 ФАТФ/ОУСХАХАБ. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Энэхүү нийтлэлийг урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хуулбарлаж, орчуулж болохгүй.

Уг нийтлэлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь ашиглах зөвшөөрөл авахын тулд

2 rue André Pascal 75775 Парис Cedex 16, Франц дахь ФАТФ-ын Ажлын албанд  
(Факс: +33 1 44 30 61 37 эсхүл э-шуудан: [contact@fatf-gafi.org](mailto:contact@fatf-gafi.org)).

хандах шаардлагатай.

Нүүр хуудасны зургийг ашиглах боломж олгосон © Thinkstock-д талархал илэрхийлье



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
АШГИЙН ТӨЛӨӨ БУС БАЙГУУЛЛАГУУДЫГ ЗҮЙ БУСААР АШИГЛАХТАЙ ТЭМЦЭХ ШИЛДЭГ ДАДАЛ ТУРШЛАГА (8-Р ЗӨВЛӨМЖ) .....	3
I. ОРШИЛ БА ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	4
II. ЗОРИЛГО БА НӨХЦӨЛ БАЙДАЛ .....	6
III. УЛС ОРНУУДАД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ ЧИГЛЭЛ БА ШИЛДЭГ ДАДАЛ ТУРШЛАГЫН ЖИШЭЭ.....	10
A. Эрсдэлийн тухай мэдэгдэхүүн.....	10
B. Эрсдэлийг бууруулах нь.....	14
IV. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЗҮЙ БУС ҮЙЛДЛИЙН ЭСРЭГ АББ-ЫН ЗҮГЭЭС АВАХ АРГА ХЭМЖЭЭ .....	22
A. Эрсдэлийн шинжилгээ ба Эрсдэлд суурилсан арга .....	22
B. Эрсдэлийг бууруулах нь .....	22
C. Өөрийгөө зохицуулах нь.....	23
V. АТББ-ИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ .....	28
ХАВСРАЛТ 1: УЛС ОРНУУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШЭЭ	
САЛБАРЫГ ӨРГӨНӨӨР ХАМРУУЛАХ НЬ .....	33
ХЯНАЛТ ШАЛГАЛТ БУЮУ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ .....	38
ҮР ДҮНТЭЙ ШАЛГАЛТ БА МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ.....	43
ХАВСРАЛТ 2: АББ-ЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШЭЭ .....	44
БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БУЮУ НЭГДМЭЛ БАЙДАЛ.....	45
ТҮНШИЙН ХАРИЛЦАА.....	50
САНХҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БА ИЛ ТОД БАЙДАЛ .....	52
ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ.....	56
ХАВСРАЛТ 3 ТӨЛӨӨЛЛИЙН БОЛОН ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ .....	59
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ БА НОМ ЗҮЙ .....	68

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>МУЭ (AML)</b>	Мөнгө угаахын эсрэг
<b>КОА (CRA)</b>	Канадын орлогын агентлаг
<b>ТСЭ (CFT)</b>	Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг
<b>СББМҮҮ (DNFBP)</b>	Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
<b>СМА (FIU)</b>	Санхүүгийн мэдээллийн алба
<b>МУ (ML)</b>	Мөнгө угаах
<b>ТББ (NGO)</b>	Төрийн бус байгууллага
<b>АББ (NPO)</b>	Ашгийн бус байгууллага
<b>ЭСА (RBA)</b>	Эрсдэлд-суурилсан арга
<b>ТС (TF)</b>	Терроризмыг санхүүжүүлэх
<b>НҮБ-ын АЗТ (UNSCR)</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол

## АШГИЙН ТӨЛӨӨ БУС БАЙГУУЛЛАГУУДЫГ ЗҮЙ БУСААР АШИГЛАХТАЙ ТЭМЦЭХ ШИЛДЭГ ДАДАЛ ТУРШЛАГА (8-Р ЗӨВЛӨМЖ)

Энэхүү удирдамж чиглэлийг дараах баримт бичгийн хамт уншиж танилцах нь зүйтэй. Үүнд:

- ФАТФ-ын *Зөвлөмжүүд*, нэн ялангуяа, 8-р зөвлөмж, түүний тайлбар, 1-р зөвлөмж болон түүний тайлбар,
- Ашгийн төлөө бус байгууллагуудыг терроризмын зорилгоор зүй бусаар ашиглахтай холбоотой эрсдэлийн тухай ФАТФ-ын ангиллын тайлан.

ФАТФ-ын бусад холбогдох баримт бичиг:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үндэсний удирдамж чиглэл буюу зааварчилгаа
- *Террорист санхүүжилтийн* ангиллын тайлан,
- Банкны салбарт зориулсан Эрсдэлд-суурилсан аргын талаарх удирдамж,
- Мөнгө угаах/Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг ба санхүүгийн хүртээмжийн тухай шинэчилсэн удирдамж чиглэл.

## I. ОРШИЛ БА ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын(ФАТФ) “Ашгийн төлөө бус байгууллагуудыг зүй бусаар ашиглахтай тэмцэх шилдэг дадал туршлага” баримт бичгийг 2001 оны 9-р сарын 11-ний террорист халдлагын дараахан буюу 2002 онд ФАТФ терроризмыг санхүүжүүлэх (ТС-ТФ)–д өртөж болзошгүй эмзэг байдал болон аюул заналыг арилгах стандарт нэвтрүүлэх үед анхлан боловсруулсан. Тэр цагаас хойш аюул заналын орчин хувьсан өөрчлөгдөж, 8-р зөвлөмжийг хэрэгжүүлсэн Засгийн газрууд туршлагажиж, ашгийн төлөө бус салбар болон өөрийгөө зохицуулах механизм ч үргэлжлэн хөгжсөөр ирлээ. Шилдэг дадал туршлагыг агуулсан баримт бичгийг *ФАТФ-ын шинэчилсэн зөвлөмжийг* үүнд тусгах, АББ-ын хууль ёсны үйл ажиллагааг хамгаалах шаардлагын үүднээс 2013 онд ашгийн төлөө бус салбарын зүгээс өгсөн тодорхой саналыг үндэслэн хязгаарлагдмал хүрээнд шинэчилсэн. ФАТФ нь Ашгийн төлөө бус байгууллагуудыг терроризмын зорилгоор зүй бусаар ашиглах эрсдэлийн тухай ангиллын тайланг (Ангиллын тайлан) 2014 оны 6-р сард хэвлэн нийтлүүлсэн бөгөөд шилдэг дадал туршлагыг агуулсан энэ удаагийн баримт бичгийг энэхүү тайлангийн санал дүгнэлт, Засгийн газрууд болон хувийн хэвшлийн шилдэг дадал туршлагыг тусгах замаар үргэлжлүүлэн шинэчлээд байгаа юм.

2. ФАТФ нь дэлхийн өнцөг булан бүрт буяны буюу сайн санааны үйлчилгээ үзүүлэхэд АББ-ын хамтын нийгэмлэгийн оруулдаг хувь нэмрийн ач холбогдлыг, мөн ихэвчлэн алслагдсан бүс нутаг дахь тусламж хэрэгтэй байгаа хүмүүст тусламж үзүүлэхэд бэрхшээлтэй байдгийг ухамсарлахын сацуу, АББ-ын хамтын нийгэмлэгийн ийм хэрэгцээг хангахад чиглэсэн хүчин чармайлтыг ойлгон сайшааж ирсэн билээ. Энэхүү шилдэг дадал туршлагыг агуулсан баримт бичгийн нэг гол зорилго нь АББ-ын гаргаж ирсэн хүчин чармайлтад тус дөхөм үзүүлэх, Засгийн газрууд болон ашгийн төлөө бус салбарын үйл ажиллагаагаа явуулах нэмэлт арга зам санал болгосон жишээгээр хангаж өгөх замаар дэлхий даяарх АББ-ын салбар терроризмын зорилгоор зүй бусаар ашиглагдахаас, АББ-ын салбар дахь шударга буюу нэгдмэл байдлыг хамгаалах явдал юм. Эдгээр шилдэг дадал туршлага нь ФАТФ-ын стандартын<sup>1</sup> албан журмын бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд гагцхүү санаа авахуйц жишээг агуулсан болно.

3. ФАТФ нь санхүүгийн систем дэх шударга байдлыг хангахад чухал түнш болох ашгийн төлөө бус салбар зэрэг хувийн хэвшилтэй нухацтай бөгөөд бодитой яриа хэлэлцээ өрнүүлэхэд үргэлжид бэлэн байдаг.

4. ФАТФ нь, өөрийн үйл ажиллагааны хүрээнд ил тод байдлыг хангадаг, терроризмыг санхүүжүүлэх, террорист байгууллагуудад дэмжлэг үзүүлэхийг хүсэгч этгээдүүд энэ салбарыг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлж ажилладаг АББ-ын хамтын нийгэмлэгийн зорилго болон хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрч ирсэн. Олон орны ашгийн төлөө бус салбар дотоод хяналт болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ зэрэг үйл ажиллагаагаа хариуцлагатай, ил тод байлгахад туслах стандарт болон санаачилга бүхий төлөөллийн болон өөрийгөө зохицуулах байгууллагуудаас бүрддэг. Төлөөллийн болон өөрийгөө зохицуулах байгууллагуудын түүвэрлэн авсан жишээг **3-р хавсралтанд** тусгасантай танилцаарай.

5. АББ-ууд террорист этгээд болон террорист байгууллагуудад ашиглагддаг тухай асуудал

<sup>1</sup> ФАТФ-ын стандарт нь ФАТФ-ын зөвлөмжүүд болон тэдгээрийн тайлбар бичгээс бүрддэг.



хөндөгдөн, үүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнөөс хойш 10 гаруй жил өнгөрсөн хэдий ч, тэдгээрийн зарим нь эдүгээ ч янз бүрийн байдлаар террорист этгээдүүдэд ашиглагдсан хэвээр байна. Чухамдаа, террористууд өөрсдийн үйл ажиллагаа, ялангуяа зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт гол төлөв хууран мэхлэх замаар үйл ажиллагаагаа өнгөлөн далдалдаг. Террористуудын ашгийн төлөө бус салбарыг зүй бусаар ашиглах сайтар төлөвлөсөн хууран мэхлэлт ч төрийн бус салбарын тоглогчдод байгаа нөөцөд нэвтрэхэд хүндрэлтэй байдаг тул төрийн хяналт, түүний чадварыг ашгийн төлөө бус салбар дахь хамгийн боловсронгуй террорист заналхийллийг хүртэл олж илрүүлэх үйл ажиллагааны зайлшгүй шаардлагатай бүрэлдэхүүн хэсэг болгодог.

## II. ЗОРИЛГО БА НӨХЦӨЛ БАЙДАЛ

6. Энэхүү шилдэг практик дадлыг агуулсан баримт бичгийн зорилго нь дараах зорилгыг хэрэгжүүлэхэд туслах шилдэг дадал туршлагын багцыг тодорхойлоход оршсон болно. Үүнд:

- а) 1-р зөвлөмжийн дагуу, эрсдэлд-суурилсан арга болон улс орнуудын эвлэлдэн нэгдэх, хуран чуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх буюу итгэл үнэмшилтэй байх болон олон улсын хүмүүнлэгийн хуулийг<sup>2</sup> эрхэмлэн дээдлэх чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй нь уялдсан АББ-ын тухай 8-р зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нь эхний ээлжинд улс орнуудад туслалцаа үзүүлэх<sup>3</sup>;
- б) ФАТФ-ын ашгийн төлөө бус байгууллагын тодорхойлолтын хамрах хүрээнд хамаарах АББ-уудад 8-р зөвлөмжийн зорилгыг ханган биелүүлэх, тулгарч болзошгүй ТС-ийн аюул заналыг бууруулахад туслах;
- в) Санхүүгийн байгууллагуудад АББ-уудад санхүүгийн үйлчилгээ үзүүлэхдээ эрсдэлд-суурилсан аргыг зохих ёсоор хэрэглэхэд нь туслалцаа үзүүлж, АББ-уудыг санхүүжүүлж буй хандивлагчдад удирдамж чиглэл өгөх.

7. 8-р зөвлөмж, түүний тайлбар бичгийн шаардлагыг хангах, энэхүү баримт бичигт тусгагдсан шилдэг практик туршлагын жишээг авч үзэхдээ дараахь нөхцөл байдлыг анхаарч үзэх явдал чухал. Үүнд:

- а) 8-р зөвлөмж нь ашгийн төлөө бус салбарт бүхэлд нь хамааралгүй. 8-р зөвлөмжид дурдсан арга хэмжээ, түүний дотор хяналт, зохицуулалтын механизмыг хэрэгжүүлэхдээ улс орнууд ашгийн төлөө бус салбарын олон талт байдал, дотоодын ашгийн төлөө бус салбарт тулгарч буй терроризмын эрсдэлийн талаархи харилцан ойлголцолд үндэслэн зорилтот буюу товлосон аргыг ашиглах нь зүйтэй. Тухайн улс

<sup>2</sup> Улс орон эсхүл улс орнуудын талаархи бүх эшлэлүүд харьяа газар нутаг эсхүл харьяаллын нутаг дэвсгэрт мөн адил хамаарна.

<sup>3</sup> Хүн бүрийн эрхийг дээдлэн хүндлэх, хууль ёсыг терроризмын эсрэг тэмцэх гол үндэс суурь болгох нөхцлөөр хангах арга хэмжээ гэсэн 4-р бүлэг бүхий 2006 оны 6-р сард батлагдсан Нэгдсэн үндэстний байгууллагын Даян дэлхийн терроризмын эсрэг стратегийг мөн харна уу?

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2129 тоот тогтоолын удиртгал хэсэгт (2013) Зөвлөл нь "Гишүүн улс орнууд террористууд төрийн бус, ашгийн төлөө бус, буяны байгууллагуудыг зүй бусаар ашиглах, тэдэнд ашиглагдахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд иргэний нийгэм дэх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, шашин шүтэх, итгэл үнэмшлийн эрх чөлөөг бүрнээ хүндлэн дээдлэхийн ач холбогдлыг эргэн санахын сацуу төрийн бус, ашгийн төлөө бус болон буяны байгууллагууд террористууд тэдний нэр хүндийг урвуулан ашиглах оролдлого хийхээс зохих ёсоор урьдчилан сэргийлэх, эсэргүүцэх, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын холбогдох зөвлөмж болон удирдамж чиглэлийн баримт бичгийг ухамсарлах ёстойг сануулах" нь зүйтэй гэж үзсэн болно.

орны онцлогоос хамаарч, АББ-ын эрх зүйн төрөл хэлбэр өөр өөр байдаг тул, ФАТФ АББ-ын ажил хэргийн шинжтэй тодорхойлолтыг томъёолон гаргасан. Уг тодорхойлолт нь ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг гэсэн энгийн баримтаас илүүтэйгээр террорист зорилгоор зүй бусаар ашиглуулах эрсдэлтэй байгууллагын үйл ажиллагаа болон шинж чанарт үндэслэгдсэн. Иймд, 8-р зөвлөмж ФАТФ-ын өгсөн ашгийн төлөө бус байгууллагын тодорхойлолтод хамаарах АББ-дад л хамаатай.

#### **Ашгийн төлөө бус байгууллагын тухай ФАТФ-ын тодорхойлолт**

Буяны, шашны, соёл, боловсрол, нийгэм, ах дүүгийн холбооны, эсхүл бусад төрлийн "сайн үйлс" хийх зорилгоор хөрөнгө босгох, зарцуулах үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд, эсхүл тохиролцол, эсхүл байгууллага.

Энэхүү тайланд, өөрөөр заагаагүй бол АББ гэдэг нэр томъёо нь зөвхөн ФАТФ-ын тодорхойлолтод хамаарах АББ-дад хамаарна. Энэхүү нэр томъёо нь ашгийн төлөө бус байгууллагуудад бүхэлд нь хамааралгүй.

8-р зөвлөмж нь ФАТФ-ын АББ-ын тодорхойлолтын хүрээнд хамаарах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах хамгийн өндөр эрсдэлтэй АББ-дад гагцхүү зориулагдсан болно. Зарим улс орны хувьд, энэ нь тухайн салбарын санхүүгийн эх үүсвэрийн нэлээд хувийг хянадаг бөгөөд салбар дахь олон улсын үйл ажиллагаанд үлэмж хувийг эзэлдэг АББ-ууд гэж ойлгож болох юм. Өөр бусад улс орны тухайд, уг салбар дахь ТС-ийн эрсдэлийн тухай ойлголттой хамтатган авч үзсэн дотоодын ашгийн төлөө бус салбарт хийсэн тойм судалгаа өөр өөр шинж чанар бүхий АББ-дад террорист үйлдэлд ашиглагдах эрсдэл илүү өндөр болохыг харуулж өгч болох юм. Зарим улс орнуудад, тухайн салбар дахь терроризмыг санхүүжүүлэх эрсдэл тухайн улс орны нөхцөл байдлаас хамаарч бага байх ч боломжтой.<sup>4</sup>

- b) Бүх АББ өндөр эрсдэлтэй байдаггүй бөгөөд зарим нь багахан эрсдэлтэй, эсхүл огт эрсдэлгүй байх ч боломжтой. Магадгүй, одоогийн байдлаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тухайн улсын хувьд тодорхойлогдсон ашгийн төлөө бус салбарт тулгарч буй ТС-ийн эрсдэлийг шийдвэрлэхэд хангалттай байж болох хэдий ч, цаг хугацаа өнгөрөх хэрээр тодорхой мөчлөгийн дагуу хийгдсэн үнэлгээ шинэ, эсхүл хувьсан өөрчлөгдсөн ТС-ийн эрсдэлийг олж илрүүлж болно. Энэ нь 1-р зөвлөмжид заасны дагуу эрсдэлд-суурилсан аргыг улс орны болон санхүүгийн байгууллагуудын түвшинд ашиглах урьдач нөхцөл болж өгч болох юм. Тухайлбал, улс орнууд энэ салбарыг хэрхэн хянадаг, шалгадаг, эсхүл санхүүгийн байгууллагууд ашгийн төлөө бус салбарын үйлчлүүлэгчидтэйгээ хэрхэн бизнесийн харилцаа тогтоон ажилладаг гэдэг талаас нь ч авч үзсэн бүх АББ-дад "бүгдэд таарч тохирох цорын ганц жор" хэмээх арга хэрэглэх нь тохиромжгүй гэсэн үг юм. Үүнийг АББ-дад санхүүжилт олгодог хандивлагчид ч мөн адил харгалзан үзэх явдал чухал.
- c) Дотоодын ашгийн төлөө бус салбарт оршин буй нь тогтоогдсон эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахдаа улс орнууд тайлбар бичгийн 3-р зүйлд тусгагдсан 8-р

<sup>4</sup> Ангиллын тайлангийн санад дүгнэлтийн 16 дахь догол төрийг харна уу? (ФАТФ, 2014а).

зөвлөмжийн зорилгыг дараахь байдлаар авч үзэх нь чухал. Үүнд:

*8-р зөвлөмжийн зорилго нь террорист байгууллагууд АББ-уудыг ашиглан: (i) хууль ёсны хуулийн этгээдийн хэв маяг үзүүлэх; (ii) хууль ёсны этгээдийг терроризмыг санхүүжүүлэхэд, үүний дотор, хөрөнгө царцаахаас зайлсхийх зорилгоор ашиглах; эсхүл (iii) хууль ёсны зорилгоор ашиглах санхүүжилтийг нууцаар нуун далдалж терроризмын зорилгоор ашиглахаар зориулалтыг нь өөрчлөх ээргээр зүй бусаар ашиглахгүй байх нөхцлийг бүрдүүлэхэд оршино. Энэхүү тайлбар бичигт дурдагдсан зорилгыг ханган биелүүлэхэд ашиглах арга нь дараах ерөнхий зарчмуудад үндэслэгдсэн. Үүнд:*

- a) Террористууд болон террорист байгууллагууд ашгийн төлөө бус салбарыг өмнө нь болон эдүгээ ч зүй бусаар ашигласаар байгаа тохиолдолд, улс орнууд (i) салбарыг ийм зүй бус үйлдлээс хамгаалах, (ii) террористууд, эсхүл террорист байгууллагуудад ашиглагдаж буй, эсхүл тэдгээрийг идэвхтэй дэмжиж буй АББ-ын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай.*
- b) Улс орнуудын ашгийн төлөө бус салбарыг терроризмын зорилгоор зүй бусаар ашиглахаас хамгаалахад чиглэсэн арга хэмжээ хууль ёсны буяны үйл ажиллагааг тасалдуулах, эсхүл зогсоох ёсгүй. Үүний оронд, ийм арга хэмжээ нь ил тод байдлыг хөхиүлэн дэмжиж, хандивлагчид болон олон нийтийн дунд буяны сан, үйлчилгээ нь тухайлсан хууль ёсны үр шим хүртээгдэд хүрдэг гэдэгт итгэх итгэлийг нэмэгдүүлэх ёстой. Бүхий л АББ-ын удирдлага, үйл ажиллагаанд ил тод болон шударга буюу нэгдмэл байдлыг өндөр түвшинд хангаж, олон нийтийн итгэлийг олж авахад дэмжлэг үзүүлдэг тогтолцоо нь терроризмыг санхүүжүүлэх зорилгоор энэхүү салбарыг зүй бусаар ашиглахгүй байх нөхцлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.*
- c) Террористууд болон террорист байгууллагуудад ашиглагдаж байгаа, эсхүл идэвхтэй дэмжиж байгаа АББ-уудыг олж тогтоох, үр дүнтэй хариу арга хэмжээ авах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь терроризмыг санхүүжүүлэх болон терроризмыг дэмжих бусад хэлбэрээс зохих ёсоор урьдчилан сэргийлэх, яллахад чиглэгдэх ёстой. Терроризмыг санхүүжүүлэх, эсхүл терроризмыг бусад хэлбэрээр дэмжиж байж болзошгүй хэмээн сэжиглэгдэж байгаа эсвэл үүнд холбогдсон АББ-ыг олж илрүүлсэн тохиолдолд, улс орнуудын өмнө тавигдах нэн тэргүүний зорилт нь терроризмыг санхүүжүүлж, дэмжиж байгаа эсэхийг мөрдөн шалгах, таслан зогсоох явдал байх ёстой. Ийм зорилгоор авсан арга хэмжээ нь буяны буюу сайн санааны үйл ажиллагааны гэмгүй, хууль ёсны үр шим хүртээгдэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс боломжийн хэрээр зайлсхийсэн байвал зохилтой. Гэхдээ, энэхүү ашиг сонирхол нь*

*терроризмын санхүүжилт, эс бөгөөс АББ-ын терроризмд үзүүлсэн дэмжлэгийг таслан зогсоох ашиг сонирхол биелэлээ олоход чиглэсэн нэн даруй, үр дүнтэй арга хэмжээ авах хэрэгцээнээс чөлөөлөгдөх шалтгаан болох ёсгүй.*

- d) Төрийн, хувийн хэвшлийн болон ашгийн төлөө бус салбарын хамтын ажиллагаа, харилцаа холбоог хөгжүүлэх нь тухайн салбарын хүрээнд террористуудын довтолгоотой тэмцэх мэдлэгийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд, улс орнууд ашгийн төлөө бус салбарт шинжилгээ судалгаа хийх, мэдээлэл солилцох ажлыг хөхүүлэн дэмжиж, энэ талаар сурталчилж байх ёстой.*
- e) Ашгийн төлөө бус салбар дахь терроризмын аюул заналд цохилт өгөхөд ашиглах зорилтот буюу товлосон арга нь тухайн улс орны уг салбарын олон янз байдал, террористуудын зүй бус үйлдэлд өртүүлж болзошгүй салбарын эмзэг хэсэг, хууль ёсны буюны үйл ажиллагааг үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага болон тухай тухайн улс орны терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд зориулах нөөц болон эрх мэдлийн хязгаарлагдмал байдал зэргээс хамаарсан байх нөхцлийг бүрдүүлэх явдал нэн чухал.*
- f) Терроризмыг санхүүжүүлэх аюул заналын мөн чанар өөрчлөгдөн буйтай холбогдуулан, ашгийн төлөө бус салбаар дамжуулан терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг авах үндэсний түвшний хариу арга хэмжээг боловсруулахдаа, түүнийг цаг хугацаа өнгөрөх хэрээр улам бүр боловсронгуй болгохоор тооцож уян хатан хандах явдал чухал.*

d) ФАТФ-ын 8-р зөвлөмж буюу шилдэг дадал туршлагын тухай энэхүү баримт бичиг нь ФАТФ-ын шилдэг дадал туршлагыг агуулсан бүхий л бусад баримт бичгүүдийн нэгэн адил ФАТФ-ын стандартад нийцэлтэй эсэхэд үнэлгээ өгсөн байх албагүй бөгөөд улс орнууд болон ашгийн төлөө бус салбар үүнийг ашгийн төлөө бус салбарыг терроризмын зорилгоор ашиглахаас хэрхэн сэргийлж, эрсдэлийг бууруулах боломжтойг тодорхойлохдоо анхааран авч үзэх нь зүйтэй. Энэхүү баримт бичигт тусгагдсан шилдэг дадал туршлагын тодорхой жишээг бүх АББ-дад тавигдах шаардлагыг шалгах хяналтын жагсаалт болгон ашиглах ёсгүй бөгөөд эдгээрийг баримт бичигт гагцхүү жишээ болгон оруулсан болно. Шилдэг дадал туршлагыг иж бүрэн байдлаар авч үзэх зорилт тавиагүй. Харин, нөхцөл байдлаас хамаарч, 8-р зөвлөмжийн зорилгыг ханган биелүүлэхэд чиглэсэн зүй зохистой алхам болгон авч хэрэгжүүлж болох арга хэмжээний төрөл хэлбэрийг үлгэрчилж харуулсан. Хэдийгээр, энд тусгагдсан шилдэг дадал туршлагууд нь хэрэг болохуйц үзүүлэлтүүд боловч бүхий л нөхцөл байдалд ач холбогдолтой бус байж болно.

e) 8-р зөвлөмжийн тайлбар бичигт дурдсанчлан, террористууд болон террорист байгууллагууд энэхүү салбарт үйл ажиллагаа явуулж буй зарим АББ-ыг ашиглан хөрөнгө босгож, шилжүүлж, логистикийн дэмжлэг үзүүлж, террорист бүлэглэлд элсүүлэхийг

сурталчилж, эсхүл террорист байгууллага болон үйл ажиллагааг дэмжиж байж болно. Ийм зүй бус ашиглалт нь террорист үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлээд зогсохгүй, хандивлагчдын зүгээс АББ-дад итгэх итгэлийг бууруулж, АББ-ын нэгдмэл байдалд аюул учруулдаг. Иймд, ашгийн төлөө бус салбарыг террорист зорилгоор ашиглахаас сэргийлэн хамгаалах явдал даян дэлхийн терроризмтой тэмцэх хүчин чармайлтын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ашгийн төлөө бус салбар болон хандивлагчдын шударга буюу нэгдмэл байдлыг сахин хадгалах чиглэлд хийх зайлшгүй алхам юм.

### III. УЛС ОРНУУДАД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ ЧИГЛЭЛ БА ШИЛДЭГ ДАДАЛ ТУРШЛАГЫН ЖИШЭЭ

Улс орнуудад зориулсан шилдэг дадал туршлагын тодорхой жишээг **1-р хавсралтад** тусгав.


8. 8-р зөвлөмжийг бусад зөвлөмжөөс салангид байдлаар хэрэгжүүлэх боломжгүй. Уг зөвлөмжийн хэрэгжилт нь эрсдэлд-суурилсан аргын талаарх 1-р зөвлөмжид тусгасан иж бүрэн шаардлагад нийцсэн байх ёстой.

#### A. ЭРСДЭЛИЙН ТУХАЙ МЭДЭГДЭХҮҮН

9. 1-р зөвлөмжид заасны дагуу, улс орнууд өөрийн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, танин мэдэх, улмаар эрсдэлийг судалж шинжлэх, эрсдэлийг үр дүнтэйгээр бууруулах нөөц хуваарилах үйл ажиллагааг зохицуулах эрх бүхий байгууллага эсхүл механизмыг тодорхойлох зэрэг арга хэмжээ авах шаардлагатай. Улс орнууд хийсэн үнэлгээндээ үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь олж тогтоосон эрсдэлтэй тохирч байх ядвлыг баталгаажуулахын тулд эрсдэлд-суурилсан аргыг (RBA) хэрэглэх шаардлагатай. Эрсдэлд-суурилсан арга нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) тогтолцооны хүрээнд нөөцийг үр дүнтэй хуваарилах, *ФАТФ-ын зөвлөмжийн* дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд чухал үндэс суурь болж өгөх ёстой. Улс орнууд эрсдэлийн түвшин бага гэж тодорхойлсон тохиолдолд, ФАТФ-ийн зарим зөвлөмжийг нөхцөл байдалдаа тохируулах байдлаар хялбаршуулсан арга хэмжээ авах шийдвэр гаргаж болох юм.

10. Эрсдэлийг эмзэг байдлын сул талыг ашиглах аюул заналын хир чадал гэж тодорхойлж болно. Аюул занал болон эмзэг байдал хоёр хоёул оршин буй нөхцөлд эрсдэл оршин байна гэж үзнэ.

Зураг 1. Аюул занал+Эмзэг байдал=Эрсдэл





11. Дотоодын ашгийн төлөө бус салбарт тойм судалгаа буюу үнэлгээ дүгнэлт хийх асуудал 8-р зөвлөмжийн бүрэлдэхүүн хэсэг байсаар ирсэн. Гэхдээ, эрсдэлд-суурилсан аргад онцгойлон анхаарал хандуулсан ФАТФ-ын шинэчилсэн зөвлөмжийг батлан гаргаснаас хойш терроризмыг санхүүжүүлэхийн эрсдэлийг ухамсарлан ойлгох, 8-р зөвлөмжийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд эрсдэлд-суурилсан аргыг зохистой байдлаар ашиглах явдал илүүтэй чухал болоод байна. 8-р зөвлөмж нь улс орнуудаас өөр өөрсдийн ашгийн төлөө бус салбарыг бүхэлд нь хамарсан үнэлгээ дүгнэлт хийх, эсхүл салбарын үйл ажиллагаа, хэмжээ болон бусад холбогдох онцлогийн талаарх мэдээллийг цаг тухай бүр авдаг чадавхитай байх, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болзошгүй ашгийн төлөө бус салбарын тодорхой хэсэгтэй холбоотой хууль тогтоомж хангалттай эсэхийг үнэлж дүгнэхийг шаарддаг. Энэхүү тойм судалгааг хийхдээ улс орнууд, үйл ажиллагаа болон шинж чанараараа терроризмыг санхүүжүүлэх зорилгоор зүй бусаар ашиглагдах эрсдэлтэй АББ-ын онцлог болон төрлийг тодорхойлохын тулд боломжтой бүхий л мэдээллийн эх сурвалжийг ашиглах хэрэгтэй.<sup>5</sup> Өөрөөр хэлбэл, салбарыг бүхэлд нь судалсаны үндсэн дээр ФАТФ-ын АББ-ын тодорхойлолтын хүрээнд хамаарах байгууллагын дэд бүлгийг тодорхойлох, үүний дараа эдгээр АББ-уудаас аль нь терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах хамгийн өндөр эрсдэлтэй болохыг олж тогтооно. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд ашиглагдаж болзошгүй эмзэг байдал, террористуудын зүй бус үйл ажиллагааны чиг хандлага болон эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаархи шинэ мэдээллийг судалж үзэн, ашгийн төлөө бус салбарт үе үе дахин тойм судалгаа хийж байх хэрэгтэй.

12. АББ-ууд нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хамтран ажиллагч байгууллагуудын нэгэн адил мөнгө угаах, залилан мэхлэх, авилга, татвараас зайлсхийхтэй холбоотой бусад олон эрсдэлтэй тулгарч болзошгүйг анхаарах нь зүйтэй бөгөөд 8-р зөвлөмж нь гагцхүү АББ-ын террористуудад ашиглуулахтай холбоотой эмзэг байдлын асуудлыг шийдвэрлэхийг зорьдог юм. Түүнээс гадна, хууль бус санхүүжилтийн аюул занал, түүний дотор мөнгө угаах аюулаас хамгаалахад чиглэсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

13. Дотоодын ашгийн төлөө бус салбар болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголт нь хамтын үнэлгээний 4 дөх шатанд гаргасан 8-р зөвлөмжийг дагаж мөрдөхөд маш чухал. Эрсдэлд-суурилсан арга нь улс орнууд терроризмын санхүүжилтийн эрсдэлийг хэрхэн бууруулах, 8-р зөвлөмжид дурдсан цогц арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, хяналтын механизмд ашгийн төлөө бус салбарын аль бүрэлдэхүүн хэсэг хамрагдах ёстойг тодорхойлох үндэс суурь болж өгнө.

14. Амьдрал дээр, ашгийн төлөө бус салбарыг бүхэлд нь үнэлж дүгнэх явдал дор дурдсан боломж нөхцлийг бүрдүүлдэг тул энэ нь 8-р зөвлөмжийг зүй зохистой хэрэгжүүлэхэд чухал бөгөөд зайлшгүй шаардлагатай эхлэлийг цэг болж өгнө. Үүнд:

- a) Чухам аль ашгийн төлөө бус байгууллагууд ФАТФ-ын АББ-ын тодорхойлолтын хүрээнд хамаарах болон аль АББ-уудыг тухайн улсын ТС-ийг бууруулах арга хэмжээнд хамааруулахыг тодорхойлох;
- b) Дотоодын ашгийн төлөө бус салбар, түүний хэмжээ, төрөл хэлбэр, байршил болон АББ-уудын үйл ажиллагааны талаар илүү сайн ойлголттой болох;
- c) Терроризмын санхүүжилтийн эрсдэл тулгарч буй тодорхой ашгийн төлөө бус салбарын талаар таньж мэдэх, 8-р зөвлөмжийн дагуу эдгээр эрсдэлийг бууруулахад дөхөм үзүүлэх хууль, тогтоомж болон авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;

<sup>5</sup> 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 4 дүгээр зүйл (ФАТФ, 2012)



- d) Зохистой гэж үзвэл, дотоодын үнэлгээ дүгнэлтийн үр дүнг үндэсний хэмжээний эрсдэлийн хүрээнд авч үзэх;<sup>6</sup>
- e) Хууль, дүрэм журам, бусад арга хэмжээ нь Зөвлөмж 1-д<sup>7</sup> заасны дагуу тодорхойлсон эрсдэлтэй таарч тохирч буй эсэх, эрсдэлийг бууруулах нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эсэх, эсхүл одоо хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалттай эсэхийг магадлах.

15. Тухайн улсын ашгийн төлөө бус салбарын тойм судалгааны бүрэлдэхүүнд АББ-уудын хэмжээ, төрөл хэлбэр, хамрах хүрээ, тэдгээрийн үйл ажиллагаа, хандивлагчдын суурь, хил дамнасан үйл ажиллагаа болон санхүүжилт, санхүүгийн шилжүүлэг хөдөлгөөн, төлбөрийн арга хэрэгсэл, үйл ажиллагааны төрөл хэлбэр болон байршил, үзүүлдэг үйлчилгээ болон эдгээр бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой эрсдэлийн түвшин зэргийг хамруулж болно.

### Хайрцаг 1. Салбарын тойм судалгааны жишээ

Канад Улсад бүртгэлтэй буяны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг Канадын Орлогын Агентлаг (CRA) нь үйл ажиллагаа, шинж чанараараа аль байгууллагуудыг террористуудад дэмжлэг үзүүлэх хэлбэрээр ашиглуулах эрсдэл өндөртэй байгааг олж тогтоох зорилгоор Канад дахь ашгийн төлөө бус салбарыг бүхэлд нь хамарсан тойм судалгааг хийсэн.

Тодруулбал, Канад дараах зүйлсийг баталгаажуулахыг зорьсон. Үүнд:

- ФАТФ-ын АББ-ын тодорхойлолтыг хэтэрхий өргөн хүрээнд авч үзэж тайлбарлаагүй;
- Хамгийн өндөр эрсдэлтэй байгууллагуудад төвлөрч чадаж байна;
- Эрсдэл учраагүй байгууллагуудад ТС-ийн асуудлаар тайлагнах өндөр шаардлага тавиагүй.<sup>1</sup>

КОА нь төрийн, эрдэм шинжилгээний болон ашгийн төлөө бус байгууллагуудын хэвлүүлсэн ашгийн төлөө бус салбартай холбоотой нийтлэл болон судалгааг хянаж үзсэн бөгөөд үүнд Канадын Статистикийн хорооны ашгийн төлөө бус байгууллагуудын талаарх тайлан, энэ салбарын үйл ажиллагаанд нөлөөлдөг дүрэм, журмын талаар хийсэн зөвлөлдөх уулзалт, буяны үйлс болон сайн дурын үйл ажиллагааны чиг хандлагын талаарх судалгаа зэргийг багтаасан байна. Үүний сацуу, КОА нь ашгийн төлөө бус байгууллагуудад мөрдөгддөг хуулиуд болон тайлагнах шаардлагын талаар авч үзжээ.

Эрсдэл чухам хаана байгааг тодорхойлохын тулд, ашгийн төлөө бус байгууллагуудыг тэдгээрт нийтлэг байдаг шинж чанар болох зорилго, үйл ажиллагаа, хэмжээ болон үйл ажиллагаа явуулдаг газар нутаг буюу байршлаар нь ангилсан. КОА нь эдгээр шинж чанаруудыг ФАТФ-ын ашгийн төлөө бус байгууллагын тодорхойлолтын бүрэлдэхүүн хэсгүүдтэй харьцуулж үзсэн. Мөн, байгууллагуудыг илүүтэй эрсдэлд оруулж буй онцлог шинж чанарыг тодорхойлохын тулд Ашгийн төлөө бус байгууллагуудыг<sup>2</sup> терроризмын зорилгоор зүй бусаар ашиглахтай холбоотой эрсдэл гэсэн ФАТФ-ын ангиллын тайлангийн санал дүгнэлтийг харгалзаж үзсэн байна.

<sup>6</sup> Үндэсний хэмжээний эрсдэлийн үнэлгээ хийх асуудлаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл, ФАТФ-ын [Үндэсний хэмжээний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ](#) гэсэн ФАТФ-ын удирдамжийг үзнэ үү? (ФАТФ, 2013)

<sup>7</sup> 1-р зөвлөмжийн тайлбар бичгийн 1 зүгээр зүйл (ФАТФ, 2012).

Канад Улсын тухайд, терроризмын зорилгоор ашиглагдах хамгийн өндөр эрсдэлтэй байгууллагууд нь үйл ажиллагааныхаа онцлог, шинж чанараас хамааран буяны байгууллагууд байдаг гэдгийг КОА тогтоосон. Энэ нь Канадын нөхцөлд буяны байгууллагууд нь ФАТФ-ын тодорхойлолтын хүрээнд багтдаг байгууллагууд гэсэн үг юм. Хамгийн өндөр эрсдэлтэй байгууллагууд буяны байгууллагууд байдаг, гэхдээ бүх буяны байгууллагууд эрсдэлд ордоггүй. Салбарт хийсэн тойм судалгаанаас олж авсан ойлголт нь Канад улс үндэсний эрсдэлийн үнэлгээний эхлэл цэг болгон буяны ажилд анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгосон байна.

1. 23 болон 24-р зүйлийг харна уу?
2. ФАТФ (2014a).

16. ФАТФ нь ашгийн төлөө бус байгууллагуудад тулгарч ирсэн терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй холбоотой асуудлаар өөрийн судалгааг хийсэн.<sup>8</sup> 2014 оны 6-р сард ФАТФ дэлхийн 14 улс орноос ирүүлсэн 102 тохиолдлын судалгаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр [Ашгийн төлөө бус байгууллагуудын террорист үйлдэлд өртөх эрсдэл](#)<sup>9</sup>-ийн тухай ангиллын тайланг хэвлэн нийтлүүлсэн. Ангиллын тайланд террорист байгууллагууд АББ-ыг зүй бусаар ашигладаг асуудлыг албан ёсоор гаргаж тавьсанаас хойш арав гаруй жил өнгөрсөн хэдий ч, аюул занал хэвээр байна гэж үзсэн. Террорист байгууллагууд ашгийн төлөө бус салбарыг зүй бусаар ашиглах нь дэлхийн хэмжээнд уг салбарын хувьд бага магадлалтай эрсдэл хэдий ч, уг салбарыг зүй бусаар ашиглахтай холбоотой нөлөөлөл нь мөнгөний үнэ цэнийг явцуу байдлаар авч үздэг хүрээнээс хальсан асуудал гэж үзнэ. Хандивлагчид АББ-дад олгосон санхүүгийн болон материаллаг нөөцийг сайн үйлст зарцуулна гэдэгт итгэдэг; энэхүү итгэлцэл нь ашгийн төлөө бус салбарын оршин тогтнох үндэс суурь нь юм. Зөвхөн хохирол учруулах зорилготой этгээдүүдэд эдгээр итгэж олгосон хөрөнгийн зориулалтыг өөрчилж үр шим хүртэх боломж олгох нь олон нийтийн ашгийн төлөө бус салбарт итгэх итгэлийг бууруулж, улмаар АББ-уудын үйл ажиллагаанд үлэмж хэмжээгээр нөлөөлөх болно. Уг тайланд АББ-ын үйл ажиллагааны төрөл болон террорист үйлдэлд өртөх эрсдэл хоорондоо харилцан хамааралтай гэж үзсэн болно. Тайлан дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд:

- a) "үйлчилгээний үйл ажиллагаа" эрхэлдэг АББ-ууд терроризмыг санхүүжүүлэхэд хамгийн их ашиглагдах эрсдэлтэй буюу өөрөөр хэлбэл, орон сууц, нийгмийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд байна. Энэ нь ашгийн төлөө бус байгууллагын тухай ФАТФ-ын тодорхойлолттой нийцэж байна. Чухамдаа, дүн шинжилгээ хийж, кейс судалгаа ирүүлсэн АББ-ын аль нь ч "илэрхийлэх үйл ажиллагаа" буюу спорт, амралт, урлаг, соёл, ашиг сонирхлыг илэрхийлэх, сурталчлах зэрэг улс төрийн намууд, судалгааны төвүүд болон нөлөөллийн бүлгүүдэд хамаатай хөтөлбөрүүд хэрэгжүүлдэггүй байв.
- a) Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг АББ-уудад тулгарч ирсэн эрсдэл нь нэг хэвийн биш байна. "Терроризмын идэвхтэй аюул заналхийлэлд ойрхон" үйлчилгээ эрхэлдэг АББ-ууд зүй бус үйлдэлд өртөх эрсдэл өндөр байна. Энэ нь i) терроризмын аюул занал нүүрлэсэн зөрчил мөргөлдөөнтэй бүс нутагт; эсхүл ii) дотооддоо зөрчил мөргөлдөөнгүй улс оронд, гэхдээ террорист хөдөлгөөнд дэмжлэг, нөмөр нөөлөг болгохоор тухайн улсын хүн амыг зорилго болгосон газар үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд

<sup>8</sup> Ангиллын тайланд эрсдэлийг эмзэг байдлыг (энэ тохиолдолд, АББ-ын) ашиглах аюул заналын (энэ тохиолдолд терроризмыг дэмждэг хувь хүмүүс эсвэл бүлгүүд) үр дүнд учирч болзошгүй хор уршиг гэж тодорхойлсон.

<sup>9</sup> ФАТФ (2014a)

гэж ойлгож болно. Эдгээр хоёр тохиолдолд, эрсдэлийн гол хувьсагч нь газар зүйн асуудал биш хэдий ч, идэвхтэй байгаа террорист аюул заналд дөхүү байх явдал гэж ойлгогдоно. Нэгэн чухал зүйл гэвэл, энэ асуудал бүх тохиолдолд зөрчил мөргөлдөөнтэй газар нутаг, эсхүл тааруухан засаглалтэй холбоотой байдаггүй. Террорист хөдөлгөөнүүд үйл ажиллагаа явуулдаггүй, эсхүл явуулах боломжгүй зөрчил мөргөлдөөнтэй, эсхүл тааруухан засаглалтай бүс нутагт АББ-ууд терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй учрахгүй байж болох ч, авилга, гэмт хэрэгтэй холбоотой эрсдэлтэй тулгарч болно. Эсрэгээрээ, террорист хөдөлгөөнүүд харьцангуй тогтвортой орчин дох хүн амаас дэмжлэг авахаар тэднийг зорилгоо болгож ч болно. Гэхдээ л, аль АББ-ууд террорист байгууллагуудад ашиглуулах илүү өндөр эрсдэлтэй болохыг тодорхойлоход анхаарах гол зүйл бол, АББ-уудыг ашиглах чадвартай, тийм зорилго агуулсан террорист этгээдэд ашиглуулж болзошгүй нөөц, үйл ажиллагааны үнэ цэнэ, терроризмын аюул заналхийлэлд ойр буюу дөт байх явдал гэж үзэж байна.<sup>10</sup> Ерөнхийдөө, АББ-дад тулгардаг эрсдэлийг дараах таван ангилалд хуваан үзлээ. Үүнд:

- i. Санхүүжилтийн зориулалтыг өөрчлөх нь зүй бус үйлдэлд ашигладаг ноцтой арга бөгөөд нэг бол АББ-ын дотоод дахь тоглогчид буюу этгээд, эсхүл гадны тоглогчид (гадаадын түншүүд, эсхүл гуравдагч талын хөрөнгө босгогч этгээд зэрэг) террорист байгууллагуудыг АББ-ын үйл ажиллагаа, эсхүл санхүүгийн үйл явцаар дамжуулан хэзээ нэгэн цагт дэмжих зорилгоор санхүүжилтийн зориулалтыг өөрчлөх ажлыг хариуцдаг;
- ii. АББ-ууд, эсхүл тэдгээрийн захиргааны албан тушаалтнууд мэдсээр байж, эсхүл мэдэлгүйгээр террорист байгууллагатай холбоо сүлбээгээ хадгалан үлддэг ба ингэснээр террорист байгууллагад ерөнхий ложистикийн дэмжлэг үзүүлэх зэрэг олон зорилгоор АББ-ыг ашиглуулахад хүргэдэг;
- iii. Террорист байгууллагуудад элсүүлэх хүчин чармалтад дэмжлэг үзүүлж ашиглуулдаг;
- iv. Санхүүгийн эх үүсвэрийн урсгал нь хууль ёсны хэдий ч, АББ-ын хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнг урвуулан ашигладаг;
- v. Хандивлагчдаас дэмжлэг авахын тулд тэднийг хууран мэхлэх зорилгоор, террористууд хуурамч АББ үүсгэн байгуулах, эсхүл “сайн үйлс” бүтээх дүр эсгэх замаар хуурамч төлөөлөл бий болгох зүй бус үйлдэл. Сайтар төлөвлөсөн хууран мэхлэлт ч төрийн бүс салбарын тоглогчдод байгаа нөөцөд нэвтрэхэд хүндрэлтэй байдаг тул төрийн хяналт, түүний чадварыг ашгийн төлөө бус салбар дахь хамгийн боловсронгуй террорист заналхийллийг хүртэл олж илрүүлэх үйл ажиллагааны зайлшгүй шаардлагатай бүрэлдэхүүн хэсэг болгодог.<sup>11</sup>

17. Ангиллын тайланд мөн дараах ашиг тустай үзүүлэлтүүдийн тайлбарыг тусгаж өгсөн. Үүнд:

- a) *эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд: зүй бус үйлдлийн мөн чанар болон эрсдэлийг үнэлж дүгнэхийн тулд нэмэлт хяналт шалгалт хийхийг шаарддаг, гэхдээ терроризмыг цорын ганц боломжит тайлбар болгох шаардлагагүй үзүүлэлтүүд;*
- b) *террорист урвуулан ашиглалтын буюу үйлдлийн үзүүлэлтүүд: үзүүлэлтүүдийн арай жижиг бүлэг.*

<sup>10</sup> ФАТФ-ын Ашгийн төлөө бус байгууллагуудын террорист үйлдэлд өртөх эрсдэлийн тухай тайлангийн 6-р хуудас (ФАТФ, 2014a).

<sup>11</sup> ФАТФ-ын Ашгийн төлөө бус байгууллагуудын террорист үйлдэлд өртөх эрсдэлийн тухай тайлангийн 5-р хуудас (ФАТФ, 2014a).

## В. ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ

18. Ашгийн төлөө бус байгууллагуудад тулгардаг терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад ашиглах “бүгдэд таарч тохирох цорын ганц арга” гэж байдаггүй. Эсрэгээрээ, 8-р зөвлөмжид тусгаснаар ашгийн төлөө бус байгууллагуудыг террорист зорилгоор зүй бусаар ашигласныг олж тогтоох, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд ашиглаж болох олон янзын арга байна гэж үзсэн. 8-р зөвлөмжийн тайлбар бичигт ашгийн төлөө бус салбар дахь террорист зүй бус үйлдлийг шийдвэртэйгээр олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга нь уян хатан, олон талт дөрвөн хэсгээс бүрдсэн аргыг өөртөө агуулна хэмээн заасан байдаг.

19. Ашгийн төлөө бус салбарт террорист үйлдэл илэрсэн тохиолдолд, тухайн тохиолдлын хэр ноцтой болохоос хамаарч эрх зүйн зохицуулалтын, захиргааны, эсхүл зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ, эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах зэрэг олон янзын арга хэмжээ авч болно. Гэсэн хэдий ч улс орнууд ТС-ийн эрсдэл болон тэдэнд тулгарч буй тодорхой аюул заналхийлэлд тохирсон хариу арга хэмжээ авах чиглэл баримтлан ажиллах ёстой. Бусад төрлийн эрсдэл болон хууль бус үйл ажиллагааг<sup>12</sup> бууруулахад чиглэсэн зэрэг өнөөг хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын болон, эсхүл бусад арга хэмжээ нь ашгийн төлөө бус салбарт тулгарч буй ТС-ийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэхэд хангалттай байж болох хэдий ч, эдгээр нь эрсдэлийг бууруулахад зохистой бус тохиолдолд, эсхүл салбарт учрах ТС-ийн эрсдэл хувьсан өөрчлөгдсөөр байгаа тул нэмэлт, эсхүл өөр арга хэмжээ авах шаардлага гарч ирэх болно.

20. 8-р зөвлөмжид заасны дагуу ашгийн төлөө бус салбарыг зүй бусаар ашиглагдахаас хамгаалах үр дүнтэй арга нь тунгий нь тааруулсан, эрсдэлд-суурилсан аргыг ашигласан, дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг бүгдийг нь өөртөө агуулсан байна. Үүнд:

### Хайрцаг 2. Ашгийн төлөө бус салбарыг хамгаалах үр дүнтэй арга зам

Ашгийн төлөө бус салбарыг хамгаалах үр дүнтэй арга зам нь дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг:

- 1) Салбарын хэмжээнд хийх байнгын сурталчилгаа;
- 2) Тунгий нь тааруулсан, эрсдэлд-суурилсан хяналт шалгалт, эсхүл хяналт-шинжилгээ;
- 3) Мөрдөн шалгах болон мэдээлэл олж авах үр дүнтэй үйл ажиллагаа;
- 4) Олон улсын хамтын ажиллагааны үр дүнтэй механизм<sup>1</sup>

1. 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 5 дугаар зүйл буюу 5 дахь догол мөр (ФАТФ, 2012).

21. Энэ нь бүхий л ашгийн төлөө бус байгууллагуудад нэг ижил арга хэмжээ авах ёстой гэсэн үг биш юм. Энэ нь улс орнуудаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ нь олж тогтоосон эрсдэлтэй тохирч байхыг шаарддаг 1-р зөвлөмжтэй нийцнэ. Энэ нь өндөр эрсдэлтэй тохиолдолд хүч нэмэгдүүлсэн арга хэмжээ авч, улмаар эрсдэл бага

<sup>12</sup> Мөнгө угаах, хууран мэхлэх, авилга болон татвараас зайлсхийх зэрэг. 12-р зүйл буюу догол мөрийг харна уу?

тохиолдолд илүү энгийн, хялбаршуулсан арга хэмжээ авч болно гэсэн үг юм.

22. 8-р зөвлөмжид ашгийн төлөө бус салбар дахь эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд анхаарвал зохих өөр нэгэн чухал зүйл байгаа талаар дурдсан. Ашгийн төлөө бус байгууллагуудыг террорист үйлдлээс хамгаалах нь амин чухал хэдий ч, хамгаалахад чиглэсэн арга хэмжээ нь хууль ёсны буяны үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, урам зоригийг нь мохоохгүй байх нь чухал бөгөөд тэдний хууль ёсны үйл ажиллагаагаа эрхлэхэд нь шаардлагатай санхүүгийн зэрэг нөөцийн хүртээмжид хэтрүүлсэн, эсхүл зориудын бус хязгаарлалт хийхгүй байх ёстой. Үүний оронд ийм арга хэмжээ нь ил тод байдлыг дэмжиж, хандивлагчид, олон нийтэд буяны сан, үйлчилгээ хүссэн хууль ёсны үр шим хүртэгчиддээ хүрч байна гэсэн итгэл үнэмшлийг нэмэгдүүлбэл зохилтой.<sup>13</sup> Түүнчлэн, зарчмын хувьд, ФАТФ-ын зөвлөмжийг дагаж мөрдөхдөө үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, итгэл үнэмшилтай байх, тайван замаар хуран чуулах, эвлэлдэн нэгдэх хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмыг бүх нийтээр хүндэтгэх, дагаж мөрдөхийг уриалсан НҮБ-ын Дүрэм болон олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу улс орны хүлээх үүрэгтэй зөрчилдөх ёсгүй.<sup>14</sup>

23. Амьдрал дээр, улс орнууд ашгийн төлөө бус салбарт тойм судалгаа буюу үнэлгээ дүгнэлт хийх замаар олж тогтоосон эрсдэл болон уг салбар дахь ТС-ийн эрсдэлийн талаарх ойлголттой дүйцэхүйц эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ТС-ийн эрсдэлгүй буюу эсхүл туйлын бага эрсдэлтэй АББ-дад хүндрэл учруулахуйцаар нөлөөлөх тохиромжтой бус терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээ авахаас зайлсхийх, эрсдэлд-суурилсан аргыг зүй зохистойгоор ашиглах явдал чухал. Энэ нь дараах шалтгааны улмаас онц ач холбогдолтой. Үүнд:

- a) Бүхий л АББ-ууд терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй тулгардаггүй, эсхүл бага тулгардаг;
- b) Энэхүү салбар маш олон, янз янзын хуулийн этгээдээс бүрддэг тул улс орнууд өөрийн хязгаарлагдмал нөөцийг өндөр эрсдэлтэйд тооцогдсон АББ-уудад төвлөрүүлж зарцуулах хэрэгтэй;
- c) “Бүгдэд таарч тохирох цорын ганц жор” арга нь АББ-уудыг терроризмын зорилгоор зүй бусаар ашиглахтай тэмцэх үр дүнтэй арга зам биш бөгөөд хууль ёсны буяны үйл ажиллагааг тасалдуулах, эс бөгөөс идэвхгүй болгох магадлал өндөр байдаг.

24. АББ-уудыг бүртгэх бүртгэлийн нарийвчилсан горим журам, тайлагналын нэмэлт шаардлага, нийцлийг хангасан терроризмын эсрэг арга хэмжээг хариуцсан ажилтныг томилох шаардлага, байгууллагын хөндлөнгийн хяналт зэрэгт ТС-ийн эрсдэл багатай буюу эрсдэлгүй АББ-уудыг хамруулах нь терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зорилгыг ханган биелүүлэхэд тохиромжгүй байж болох юм. Эдгээр дурдсан болон бусад терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь ТС эрсдэлийн түвшинд тохируйц байвал зохилтой.

## **А САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ХИЙХ ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

25. 8-р зөвлөмжийн тайлбар бичигт зааснаар улс орнууд терроризмыг санхүүжүүлэх асуудлаар ашгийн төлөө бус салбарт хүрч ажиллах буюу энэ талаар сурталчлан таниулахыг шаарддаг<sup>15</sup>. Ашгийн төлөө бус салбартай байнгын яриа хэлцэл өрнүүлэх нь уг салбартай хамтын ажиллагааны харилцаа холбоог бий болгоход тус дөхөм үзүүлдэг. Бодит амьдрал дээр, олон нийтэд хүрч ажиллах янз бүрийн арга хэлбэрүүд байдаг хэдий ч, уг үйл ажиллагаа нь ФАТФ-ийн тодорхойлолтын хүрээнд

<sup>13</sup> 8-р зөвлөмжийн Тайлбар бичгийн 3 дугаар зүйл буюу догол мөр (ФАТФ, 2012).

<sup>14</sup> Мөн, жишээлбэл, Хүний эрхийн түгээмэл тунхаглал (18, 19, 20-р зүйл) болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (18, 19, 21, 22-р зүйл).

<sup>15</sup> 8-р зөвлөмжийн Тайлбар бичгийн 5(a) (ФАТФ, 2012).

хамрагдах, зүй бусаар ашиглуулж болзошгүй өндөр эрсдэлтэй байгууллагуудын дэд бүлэгт төвлөрч болно. Гэхдээ л, уг салбар маш олон, янз бүрийн хуулийн этгээдүүдээс бүрддэг тохиолдолд, энэ нь хүч сорьсон ажил байж болох талтай. Ашгийн төлөө бус байгууллагуудын эвлэлдэн нэгдсэн холбоод, эвсэл, шүхэр байгууллага, өөрийгөө зохицуулдаг байгууллагууд болон хандивлагч байгууллагуудыг уг үйл ажиллагаанд татан оролцуулах нь үй түмэн АББ-уудад үр дүнтэйгээр хүрч ажиллахад дөхөмтэй арга зам байж болох юм.

26. Өөр нэг анхаарвал зохих асуудал бол, Засгийн газрын аль байгууллага буюу хэсэг нь ийм оролцооны асуудлыг хариуцан ажиллах ёстойг тодорхойлох явдал юм. Төрийн болон төрийн бус байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд болон АББ-ын үйл ажиллагаанд хяналт тавьдаг зохицуулагч байгууллагуудыг оролцуулаад бүхий л оролцогч талууд дотоодын ашгийн төлөө бус салбарт тулгарч буй терроризмын тодорхой эрсдэлийн талаархи мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд оролцож, эрсдэлийг бууруулах шилдэг дадал туршлагын жишээгээр хангаж өгөх боломжтой. Бүяны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг цорын ганц зохицуулагчтай улс орнуудын хувьд уг байгууллага таниулан сурталчлах асуудлыг хариуцуулах нь логик сайтай сонголт байж болох юм. Гэсэн хэдий ч, олон улс орнуудад АББ-ууд болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцах эрх мэдэл нь Засгийн газрын хэд хэдэн яамд, газрын эрхлэх ажлын хүрээнд хамаардаг тохиолдол бий. Зарим улс оронд, маш олон тооны АББ-ууд татварын онцгой хөнгөлөлт эдлэхийн тулд, татварын албатай тогтмол харилцах шаардлага гардаг тул, татварын алба оролцоог хангах асуудал хариуцаж болох оновчтой шийдэл болж өгдөг.

27. Хамгийн сайнаар бодоход, хүрч ажиллах буюу сурталчлан таниулах үйл ажиллагаа нь Засгийн газар болон АББ-уудын хооронд хоёр талт, тасралтгүй үргэлжлэх яриа хэлцлийг хамарсан байх ёстой. Үүнд АББ-уудад зориулсан зааварчилгаа, тэдгээрийн санал хүсэлтийг авах зорилготой зөвлөлдөх үйл ажиллагааг мөн хамруулж болно. Уг салбарт хүрч ажиллах үйл ажиллагааг тухайн улсын салбарын тойм судалгааг хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, удирдамж чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх, ФАТФ-ын хамтарсан үнэлгээ хийх болон шаардлага гарсан тухай бүр хамтатган хийх боломжтой. Энэхүү арга нь дор дурдсан зарим давуу талтай. Үүнд:

- a) Улс орнууд өөрсдийн хэрэгцээ шаардлага, эмзэг байдал, эрсдэл, тулгамдсан асуудлын талаар өөрийн орны АББ-уудаас хэрэгцээтэй мэдээллээ авах боломжтой. Уг мэдээллийг АББ-дад зориулсан илүү үр дүнтэй бодлого, удирдамж чиглэл болон эрсдэлийг бууруулах арга хэмжээг боловсруулахад ашиглана.
- b) АББ-уудын анхаарал татсан асуудал, ажил хэрэг нь улс орнууд террорист үйлдлийн тохиолдол гарахаас өмнө өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, тасалдуулахад тус дөхөм үзүүлж, иймэрхүү үйлдлийг эрт илрүүлэх боломж бүрдүүлнэ.
- c) АББ-ууд терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон түүнийг хэрхэн бууруулах талаар сайтар ойлголттой болсон байх тул, эрсдэлийг бууруулах арга хэмжээг илүү үр дүнтэйгээр хэрэгжүүлэх боломжтой.
- d) Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх болон түүнтэй холбоотой асуудлаар АББ-уудад илүү үр дүнтэй аргаар сурталчлан таниулсанаар, тэдгээрийг ашгийн төлөө бус салбарыг террорист зорилгоор ашиглагдахаас хамгаалах илүү бүтээлч, тасралтгүй үргэлжлэх яриа хэлцэлд татан оролцуулах талаар суралцах боломж бүрдэнэ.



## **В. АББ-ДАД ТАВИХ ХЯНАЛТ БУЮУ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ**

28. 8-р зөвлөмжийн тайлбар бичигт заасанчлан, улс орнууд өөрсдийн "Ашгийн төлөө бус салбартаа" буюу ФАТФ-ын тодорхойлолтын хүрээнд хамааралтай дэд бүлэгт орсон, улмаар ТС-д ашиглагдаж болох эрсдэл өндөртэй АББ-уудад хяналт тавих буюу хяналт-шинжилгээ хийх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн алхам хийхийг шаарддаг.

29. 8-р зөвлөмжид зааснаар, бүхий л АББ-дад нэг ижил арга хэмжээ авах шаардлагагүй гэж үздэг. Үнэндээ, "бүгдэд таарч тохирох цорын ганц жор" гэдэг арга нь 1-р зөвлөмж болон эрсдэлд-суурилсан аргыг зүй зохистой байдлаар авч хэрэгжүүлэх шаардлагад нийцэлтэй бус юм. Улс орнууд дотоодын ашгийн төлөө бус салбартаа үнэлгээ дүгнэлт өгөх, тухайн салбарт тулгарч буй ТС-ийн эрсдэлийн талаар таньж мэдэх үндсэн дээр тодорхойлсон эрсдлүүдэд таарч тохирсон арга хэмжээг хэрэгжүүлж, ТС-ийн эрсдэл өндөр байгаа тохиолдолд хүч нэмэгдүүлсэн арга хэмжээ авах шаардлагатай. Түүнчлэн одоо мөрдөгдөж буй зохицуулалтын болон бусад арга хэмжээ нь ашгийн төлөө бус салбарт эдүгээ тулгарч буй ТС-ийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэхэд хангалттай байж болох хэдий ч, салбарт учрах ТС-ийн эрсдэлийг үе үе үнэлэн дүгнэж байх шаардлагатай.

30. Практикт хэрэгжүүлэх талаасаа, улс орнууд ФАТФ-ын тодорхойлолтод хамаарах, ТС-ийн эрсдэл өндөртэй АББ-уудад чиглэсэн 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 5 (b) (i) - 5 (b) (vii) дэд хэсэгт заасан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой гэсэн үг юм. Зарим улс орнуудын тухайд, үүнийг 1) уг салбарт эргэлддэг санхүүгийн нөөцийн ихээхэн хэсгийг хянадаг АББ-ууд, 2) салбарынхаа олон улсын хэмжээний үйл ажиллагааны томоохон хувийг эзэлдэг АББ-уудад арга хэмжээ чиглэгдвэл зохилтой гэж ойлгоно. Гэхдээ, өөр бусад улс орнуудын хувьд салбарын тойм судалгаа болон уг салбарт тулгарч буй ТС-ийн эрсдэлийн талаархи ойлголт нь өөр өөр шинж чанартай АББ-ууд илүү өндөр эрсдэлтэй болохыг харуулж байж болох юм. Жишээбэл, ангиллын тайлангийн үр дүнгээс харвал, дотооддоо болон олон улсын түвшинд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, эсхүл террорист аюул заналхийлэлд ойр дөт АББ-ууд хамгийн өндөр эрсдэлтэйд тооцогдож байна.

31. ТС-ийн эрсдэл өндөртэйд тооцогдох АББ-уудын тухайд авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнд хамрагдах байгууллагуудад дараах шаардлага тавигддаг. Үүнд:

- a) Тусгай зөвшөөрөлтэй, эсхүл бүртгэгдсэн байх. Гэхдээ, улс орнууд террористуудыг санхүүжүүлэхийн эсрэг зорилго тавьж буй тул тусгай зөвшөөрөл, эсхүл бүртгүүлсэн байх шаардлагыг заавал тавих албагүй. Жишээлбэл, зарим улс орнуудад АББ-ууд татварын хөнгөлөлт зэрэг татварын таатай нөхцөл эдлэхийн тулд татварын албанд бүртгүүлж, улмаар хяналтад нь хамрагдчихсан байдаг<sup>16</sup>;
- b) Тэдгээрийн үйл ажиллагаа, хэн эзэмшдэг болох, үйл ажиллагаанд нь хэн хяналт тавьж, удирдамж чиглэл өгдөг болох тухай мэдээлэлтэй;
- c) Жилийн санхүүгийн тайлан гаргадаг;
- d) Санхүүжилтийг АББ-ын тодорхойлсон үйл ажиллагаанд бүрэн хэмжээгээр зориулан зарцуулж буйг баталгаажуулах хяналт тавьдаг;
- e) "үр шимийг хүртэгсэд болон АББ-тай хамтран зүтгэгчдээ мэддэг байх" гэсэн зарчим баримталдаг;
- f) Бүртгэл хөтөлдөг;

<sup>16</sup> 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 23-р зүүлт тайлбар (ФАТФ, 2012).

g) Холбогдох эрх бүхий байгууллагын зүгээс хийх хяналт-шинжилгээнд хамрагддаг, үүний дотор тавигдсан шаардлагыг зөрчсөн тохиолдолд, түүнд нь тохирсон үр дүнтэй, анхаарал татахуйц шийтгэл<sup>17</sup> оногдуулдаг.

32. Хяналт, эсхүл хяналт-шинжилгээний шаардлагын эдгээр бүрэлдэхүүн хэсгийг зүй зохистойгоор хэрэглэх нь дараах зарим чухал ашиг тустай. Үүнд:

- a) Тодорхойлогдсон эрсдэлд тохирсон арга хэмжээ авах нь ("бүгдэд таарч тохирох цорын ганц арга"-ыг ашиглахаас илүүтэйгээр) эрсдэлтэй гэдэг нь тогтоогдоогүй АББ-уудад тохиромжтой бус дарамт учруулж болзошгүй хэт зохицуулалт хийх, эсхүл хууль ёсны буюны буюу сайн санааны үйлсийн үйл ажиллагааг санамсаргүй байдлаар тасалдуулж эсвэл идэвхгүй болгохоос зайлсхийх боломж олгодог.
- b) ТС-д өртөх буюу зүй бусаар ашиглагдах эрсдэлтэй АББ-ууд цаг хугацааны явцад өөрчлөгдөж болзошгүй байдаг тул энэ нь төрийн зохицуулалт хийх, мөрдөн шалгах, олон нийтэд сурталчлан таниулах хариу арга хэмжээг өөрчлөх үндэслэл болж өгдөг.
- c) Улс орнууд АББ-уудын хэрэгжүүлж ирсэн ил тод байдлыг хангах, сайн засаглал ба, эсхүл өөрийгөө зохицуулах санаачлагыг ашиглан терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад хөшүүрэг болгох боломжтой.
- d) Улс орнууд 5 (b) (i)-5 (b) (vii) хүртэлх дэд хэсэгт заасан янз бүрийн АББ-уудад хамааралтай бүх арга хэмжээг хэрэгжүүлэхийн оронд тодорхойлогдсон эрсдлүүдэд таарч тохирох (өөрөөр хэлбэл тохиромжтой) арга хэмжээ авах замаар хяналт тавихад зориулахаар төлөвлөсөн хязгаарлагдмал нөөцийн хуваарилалтаа сайжруулах боломжтой.
- e) Улс орнууд дотоодын хууль эрх зүйн орчин, мөрдөн шалгах үйл ажиллагаанд мэргэшсэн байдал, дотоодын террорист санхүүжилтийн эрсдэлд хийсэн үнэлгээ болон бусад олон хүчин зүйлүүдэд үндэслэгдсэн АББ-уудын хяналт болон хяналт-шинжилгээний өөр өөр арга хэрэглэдэг. ТС-ийн эрсдэлд өртөж болзошгүй ашгийн төлөө бус салбарын холбогдох хэсгийг зохих ёсоор хянаж, ийм эрсдэлийг бууруулах зохистой хяналт бий болгосон нөхцөлд, салбарт үр дүнтэй хяналт тавих, ил тод байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх цорын ганц зөв арга зам гэж үгүй. Төрийн эрх бүхий байгууллагууд ТС-ийн аюул заналхийллийг илрүүлмэгц зохих арга хэмжээг авах чадвартай байх ёстой.

### **С МӨРДӨН ШАЛГАХ, МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ҮР ДҮНТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

33. Мэдээлэл цуглуулах тухайд, улс орнууд бүх шатны зохих байгууллагуудын (хууль сахиулах, тагнуул, зохицуулах үүрэгтэй байгууллагууд, магадлан итгэмжлэлийн байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллагыг багтаасан эрх бүхий байгууллагуудыг хэлнэ) буюу АББ-уудын тухай холбогдох мэдээлэл бүхий байгууллагууд хооронд үр дүнтэй бөгөөд аль болох дээд шатанд хамтын ажиллагаа өрнүүлэх, үялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох нөхцөл бүрдүүлэх шаардлагатай<sup>18</sup>. Практикт хэрэгжүүлэх талаасаа, үүнд аль болох боломжийн хэрээр АББ-ын холбоод, эвсэл, шүхэр байгууллага эсхүл АББ-ын өөрийгөө зохицуулах байгууллага зэрэг төрийн бус байгууллагуудыг багтааж болно. Ийм байгууллагууд тус улсад үйл ажиллагаа явуулж буй АББ-ууд ба тэдгээрт тулгардаг

<sup>17</sup> Зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ нь үр дүнтэй, гаргасан зөрчилд нь таарч тохирсон, санааг нь эргүүлэхийг ороодсон байх ба бусад салбарт зөрчил гаргахад оногдуулдаг шийтгэлтэй нийцтэй буюу ядаж давсан бус байх.

<sup>18</sup> 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 5(c)(i) (ФАТФ, 2012).



терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх тодорхой мэдээлэлтэй байж болно.

34. Улс орнууд террорист байгууллагуудад мөлжигдөж байгаа эсхүл тэднийг идэвхтэй дэмжиж байгаа гэж сэжиглэгдэж буй АББ-дыг мөрдөн шалгах мэргэшлийн боломж болон чадвартай байх ёстой. Улс орнууд мөрдөн шалгах үйл ажиллагааны явцад тухайн АББ-ын захиргаа болон удирдлагын талаархи мэдээлэлд (санхүүгийн болон хөтөлбөрийн мэдээллийг багтаасан) бүрэн нэвтрэх боломж, нөхцлөөр хангаж өгөх ёстой<sup>19</sup>. Практикт хэрэгжүүлэх талаасаа, энэ нь улс орнууд тохоон томилогдсон хууль сахиулах байгууллагууд терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мөрдөн шалгах үйл ажиллагааг үндэсний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг бодлогын хүрээнд хариуцаж, үүнийг хийх хангалттай эрх мэдэлтэй байх явдлыг 29, 30, 31-р зөвлөмжийн дагуу баталгаажуулах ёстой гэсэн үг юм. Нэмж дурдахад, улс орнууд ФАТФ-ын тодорхойлолтод багтаж байгаа болон АББ-уудын дэд хэсгийн нэг хэсэг болох ТС-д ашиглагдах өндөр эрсдэлтэй гэж тооцогдох бүх АББ-уудыг наад зах нь зарим санхүүгийн болон хөтөлбөрийн мэдээллээр хангахыг шаардаж, ийм мэдээллийг олж авах боломжтой байх ёстой бөгөөд улмаар болзошгүй террорист үйлдлийг мөрдөн шалгах ёстой. Ийм шаардлагыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжоор дамжуулан тавьж болох ба, магадгүй бусад төрлийн хууль тогтоомжид энэ асуудал аль хэдийн тусгагдсан байж ч болох талтай. Жишээлбэл, АББ-ууд нь татварын таатай нөхцөл эдлэх боломжтой байхын тулд санхүүгийн болон хөтөлбөрийнхөө зарим мэдээллийн бүртгэл хөтлөхийг хууль, журмын дагуу шаарддаг байж болно.

35. Улс орнууд тодорхой АББ террористуудад зүй бусаар ашиглуулж байж болзошгүй гэсэн сэжиг илэрсэн тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах арга хэмжээ авахын тулд эдгээр мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагуудтай цаг тухайд нь хуваалцах зохистой механизм бий болгох ёстой<sup>20</sup>. Энэ нь ФАТФ-ын зөвлөмжүүд улс орнууд 20-р зөвлөмжийн дагуу тавигддаг сэжигтэй гүйлгээг тайлагнах үүргийг АББ-уудад ногдуулахыг шаарддаг гэсэн үг биш юм. АББ-ууд санхүүгийн бус бизнес болон мэргэжлүүдэд (DNFBPs) тавьдаг ФАТФ-ын шаардлагад хамаардаг санхүүгийн бус бизнес болон мэргэжлүүд гэж тооцогддоггүй.

36. Улс орнуудын АББ-уудыг террорист зорилгоор зүй бусаар ашигласныг олж тогтоох, түүний эсрэг арга хэмжээ авах чадварыг дээшлүүлсэн зарим дадал туршлагад дараахь зүйлс орно. Үүнд:

- a) Байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа буюу “бүхэлдээ нэг Засгийн газар” арга;
- b) Үйлдлийг олж илрүүлэхэд тус дөхөм үзүүлэх янз бүрийн эх сурвалжаас олж авсан олон төрлийн мэдээллийг (үүнд АББ-уудын үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой мэдээлэл, нээлттэй эх сурвалж, санхүүгийн мэдээллийн нэгж болон бусад санхүүгийн мэдээлэл, үндэсний аюулгүй байдлын тухай мэдээлэл, хууль сахиулах байгууллагын мэдээлэл, гадаадын эрх бүхий байгууллагын мэдээллийг харгалзаж үзнэ) анхааралдаа авах;
- c) ТС-д ашиглагдаж байж болзошгүй АББ-уудын тухай, эсхүл үүнтэй холбоотой асуудлын талаарх мэдээллийг олон нийт болон АББ өөрөө төр, засгийн эрх бүхий байгууллагуудад мэдээлдэг байх итгэлцлийн орчныг бүрдүүлэх.

37. АББ-уудын өөрийн эрх мэдлийн хүрээнд зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагуудад гаргаж өгдөг ашгийн төлөө бус салбарын хяналтын тухай мэдээлэл нь ашгийн төлөө бус салбарын ил

<sup>19</sup> 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 5(c)(ii) болон 5(c)(iii) (ФАТФ, 2012).

<sup>20</sup> 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 5(c)(iv) (ФАТФ, 2012).

тод байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой. Гэсэн хэдий ч, асуудалд холбогдсон байгууллагууд терроризмыг санхүүжүүлэх зорилгоор хандивлагчид болон бусад АББ-уудыг төөрөгдүүлэх үйлдэлд итгэсэн тохиолдолд, үндэсний аюулгүй байдал, эсхүл тагнуулын шугамаар олж авсан мэдээллийг ашиглан уг хууран мэхлэх үйлдлийг тасалдуулах явдал салбарыг тодорхой террористуудыг санхүүжүүлэх аюул заналаас хамгаалахад чухал үүрэгтэй. Үндэсний аюулгүй байдлын тухай мэдээ мэдээллийг олон янзын эх сурвалж, өргөн хүрээг хамарсан тайлангуудаас олж авдаг. ФАТФ-ын ангиллын тайланд дурдсанчлан, үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээ мэдээлэл нь АББ-уудын үйл ажиллагаагаа явуулж буй эрсдэлтэй орчин нөхцлийн талаарх мэдээллээр хангаж өгдөг. Энэ нь, ТС болон террорист үйлдэлд үзүүлж буй бусад дэмжлэгтэй холбогдсон хувь хүмүүс болон байгууллагуудын тухай мэдээллийг өөртөө агуулдаг.

38. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны шугамаар болон тагнуулын байгууллагаас авсан мэдээлэл нь ашгийн төлөө бус салбар дахь террорист үйлдлийг олж илрүүлэхэд тус дөхөм үзүүлж болно. Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны талаархи мэдээлэл нь эрх бүхий байгууллагуудад АББ-уудын үйл ажиллагаа явуулж буй ТС-ийн эрсдэлтэй орчин болон үйлдлийн орчин тойрны нөхцөл байдлын талаар илүү сайн таньж мэдэхэд тус дөхөм үзүүлнэ. Энэ нь, хууль бус үйл ажиллагааг дэмждэг болон АББ-уудтай холбоо сүлбээтэй хувь хүмүүс болон байгууллагуудын талаарх, мөн тэдгээрийн ТС-тэй холбогддог хэлхээ холбооны талаар гүн гүнзгий ойлголт өгөх боломжтой байдаг.

39. ФАТФ-ын ангиллын тайланд тусгасан кейс судалгаануудаас харахад, ашгийн төлөө бус салбар дахь зүй бус үйлдэл буюу томоохон эрсдэлийг олж илрүүлсний дараа, тухай тухайн тохиолдлын хэр ноцтой болохоос хамаарч олон янзын арга хэрэгсэл ашиглах замаар уг үйлдлийг таслан зогсоох, эсхүл эрсдэлийг бууруулж чадсан байна. Үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй тохиолдолд, ТС-ийн үйлдлийг таслан зогсоохын тулд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байв.

40. АББ-уудыг террорист үйлдлээс хамгаалахад захиргааны арга хэмжээ авах болон зорилтот санхүүгийн шийтгэл оногдуулах арга ашиглаж болдог бөгөөд үүний дотор АББ-уудыг зүй ашиглах үйлдэлд холбогдсон хувь хүмүүс, эсхүл террорист байгууллагууд, эсхүл террорист үйл ажиллагааг дэмжсэн бүхий л АББ-уудад шийтгэл ногдуулдаг. ФАТФ-ын 6-р зөвлөмж нь ТС-ээс сэргийлэхийн тулд зорилтот шийтгэл оногдуулахыг дэмждэг бөгөөд энэ нь мөн олон улсын түвшинд Нэгдсэн үндэстний байгууллагын аюулгүйн зөвлөлийн тогтоолуудад, нэн ялангуяа, 1267/1989, 1988, 1373 болон үүнээс хойшхи тогтоолуудад биелэлээ олж тусгагдсан.

41. Терроризмыг санхүүжүүлж байж болзошгүй хэмээн олж тогтоосон тодорхой байгууллагуудад ашгийн төлөө бус салбарын томоохон үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байхаар тооцон өөр бусад арга хэмжээ авч болно. Ийм төрлийн жишээг **1-р хавсралтад** тусгасан болно.

42. Зүй бус үйлдэл болон эрсдэлийг олж илрүүлэхэд чиглэсэн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа нь нэг байгууллагаас явуулж буй мөрдөн шалгах ажиллагаа нөгөө байгууллагын явуулж буй үйл ажиллагаатай зөрчилдөхгүй байх, эсхүл эрсдэлд оруулахгүй байх нөхцлийг бүрдүүлж өгдөг.

#### **D. АСУУДАЛД ОРСОН БАЙЖ БОЛЗОШГҮЙ АББ-ЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ОЛОН УЛСЫН ТҮВШНИЙ ШААРДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ХИЙХЭД ТУСТАЙ ЧАДАВХИ**

43. Улс орнууд террористуудыг санхүүжүүлсэн, эсхүл бусад хэлбэрээр террористуудад дэмжлэг үзүүлсэн байж болзошгүй гэж сэжиглэгдэж буй зарим АББ-уудын талаар мэдээлэл авахыг хүссэн олон улсын хүсэлт шаардлагад хариу өгөх асуудлаар харилцах байгууллага болон горим журмыг тодорхойлсон байх ёстой<sup>21</sup>.

44. Олон улсын хамтын ажиллагаа нь АББ-уудыг терроризмын зорилгоор зүй бусаар ашиглагдахаас хамгаалахад чухал ач холбогдолтой ба тэдний үйл ажиллагаа ихэвчлэн дэлхийн шинжтэй бөгөөд хэд хэдэн улс орныг хамрах хүрээнд явагддаг. Энэхүү дэлхий нийтийн оролцоо нь терроризмын үйл ажиллагаанд хамгийн их өртөж болзошгүй бүс нутагт эсвэл түүний ойролцоох бүс нутаг дахь үндэсний болон олон улсын үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээний хамрах хүрээг тодорхойлж өгдөг.

45. Олон тооны АББ-уудын үйл ажиллагаа үндэстэн дамнасан шинжтэй байдаг тул гадаад түншүүдийн мэдээлэл ТС-ийн аюул заналыг олж илрүүлэх, арга хэмжээ авахад тустай байж болно. Ийм мэдээллийг АББ-уудын гадаад түншүүд болон гадаадын түнш байгууллагын улс орны (Засгийн газрын) эрх бүхий байгууллагаас авч болно.

<sup>21</sup> 8-р зөвлөмжийн тайлбар бичгийн 5(d) (ФАТФ, 2012).

## IV. ТС-Д ЗҮЙ БУСААР АШИГЛАГДАХААС ХАМГААЛАХЫН ТУЛД АББ-УУДЫН АВЧ БОЛОХ АРГА ХЭМЖЭЭ

АББ-уудыг, түүний дотор ялангуяа өндөр эрсдэлтэй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг АББ-уудыг ТС үйлдлээс хамгаалах шилдэг дадал туршлагын тодорхой жишээг 2-р

46. ФАТФ нь, өнөөг хүртэлх хугацаанд ашгийн төлөө бус салбар өөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, салбарыг зүй бусаар, түүний дотор ТС-ээс сэргийлэн хамгаалах зорилго агуулсан хүчин чармайлтыг ойлгон хүлээн зөвшөөрч ирсэн. Олон улс орны ашгийн төлөө бус салбар нь байгууллагуудын үйл ажиллагаанд хариуцлага, ил тод байдлыг хангах нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн стандарт болон санаачлагуудыг боловсруулдаг төлөөллийн болон өөрийгөө зохицуулах байгууллагуудтай байдаг. Ил тод байдал, сайн засаглалыг хэвшүүлэх зорилготой өөрийгөө зохицуулах санаачилгыг гагцхүү энэ зорилгоор тусгайлан боловсруулаагүй байдаг хэдий ч ТС-ийн эрсдэлийг бууруулахад эерэг нөлөөлөл үзүүлдэг.

### A. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ БА ЭРСДЭЛД-СУУРИЛСАН АРГА

47. Ихэнх АББ-ууд сайн үйлсийн төлөөх хандивлагчид, түнш байгууллагууд болон үйл ажиллагааных нь үр шимийг нь хүртэгсэдтэйгээ сайн харилцаатай байдаг. Гэсэн хэдий ч, эрсдэл бодитойгоор оршин байдаг бөгөөд АББ-ууд терроризмыг санхүүжүүлэх зорилгоор зүй бусаар ашиглагдаж болзошгүй байдаг.

48. Тодорхой нөхцөл дөх эрсдэлийн мөн чанар, АББ-ын эрхэлдэг үйл ажиллагаа, үйл ажиллагаа нь хэрхэн, хаана явагдаж байгаа зэрэг нь АББ-ууд тулгарч буй ТС эрсдэлийг ойлгож, эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохистой арга хэмжээ авах явдал чухал болох шалтгаан нь юм. 2-р хавсралтын хэд хэдэн жишээнд дурдсанчлан, олон тооны АББ-ууд шинэ орчинд, эсхүл шинэ түншүүдтэй ажиллахын өмнө өөрт учирч болзошгүй эрсдэлд судалгаа хийсэн байдаг. АББ-ын эрсдэлд хийх ийм дотоодын үнэлгээ нь АББ-уудад тулгардаг террорист үйлдэл зэрэг олон янзын эрсдэлийг бууруулахад тус дөхөм үзүүлдэг.

### B. ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ

49. АББ-ууд терроризмын зорилгоор зүй бусаар ашиглагдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх хамгийн сайн арга бол сайн засаглал, санхүүгийн хүчтэй удирдлага, түүний дотор дотоодын болон санхүүгийн эрүүл хяналт, эрсдэлийн удирдлагын горим журамтай байх явдал юм. Үүний сацуу, АББ-уудад санхүүжилт өгдөг болон санхүүжилт авдаг хувь хүн болон байгууллагуудад зөв зохистойгоор хянан шалгалт хийх явдал мөн чухал. Зүй зохистой хянан шалгалт нь байгууллага нэг бүрийн нөхцөл байдал болон үйл ажиллагаагаа явуулдаг орчноос хамаардаг.

50. Хянан шалгах гэдэг нь АББ-уудад өгсөн санхүүжилтийн гарал үүсэл буюу эх сурвалжийг үл суурьтайгаар баталгаажуулах тулд АББ-уудын зүгээс хийж хэрэгжүүлэх шаардлагатай бодит алхам

бөгөөд АББ өөртэйгөө ажиллаж буй хувь хүн болон байгууллагыг таньж мэдсэн гэдэгтээ итгэлтэй байх, үүнтэй холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж удирдах зохицуулах чадвартай байхыг хэлдэг.

51. ТС-ийн өндөр эрсдэлтэй байж болзошгүй АББ-ын эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь АББ-ын эрхэлдэг ажлын янз бүрийн аспектиуд, эдгээртэй холбоотой эрсдэл, эдүгээ хийсэн хянан шалгалт болон эрсдэлийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, АББ-ын хамтран ажилладаг түншүүд террорист аюул заналтай ойр дөт ажилладаг эсэх зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна.

### Хайрцаг 3. АББ-ын хийсэн эрсдэлийн шинжилгээний жишээ

Хямралын үед яаралтай тусламж үзүүлдэг, мөн удаан хугацааны сэргээн босгох чиглэлээр тусламж үзүүлдэг олон улсын хүмүүнлэгийн тусламжийн байгууллага нь үйл ажиллагаа явуулж байгаа эсхүл ажиллахаар төлөвлөж буй газарзүйн бүс нутаг нэг бүрийн нөхцөл байдал болон эрсдэлд үнэлгээ хийдэг. Энэхүү шинжилгээний хүрээнд, уг шинжилгээг хийж буй байгууллага нь аюулгүй байдлын нөхцөл байдал болон тухайн нутаг дэвсгэр дэх улс төрийн эрх мэдэлтнүүд болон албан бус эрх мэдлийн бүтцэд дүн шинжилгээ хийдэг. Үүний дараа хөтөлбөрийн ажилтнууд эсхүл нөөцөд учирч болзошгүй эрсдэлийг, үүний дотор нөөцийн зориулалтыг өөрчлөх эрсдэлийг тодорхойлдог. Төр, засгийн албан ёсны бүтэц, зохион байгуулалтгүй газар нутагт үйл ажиллагаа явуулах байгууллага нь тухайн орон нутгийн засаг захиргаанд орон нутгийн үе удам буюу омгийн бүтцийн гүйцэтгэдэг үүрэг, тэдний аливаа хэт даврагч этгээдүүдээс ялгаатай эсэх, үр шимийг хүртэгсдийг сонгох, тусламжийг хуваарилах болон хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудад хэт даврагч этгээдүүд болон хориотой талууд хөндлөнгөөс оролцохгүй байх баталгааг гаргаж өгч чадаж байгаа эсэх зэрэгт үнэлгээ хийнэ. Тусламжийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэр дэх омог, эсхүл төр, засгийн байгууллага ийм төрлийн баталгаа өгч чадахгүй, эсхүл аюулгүй байдлын орчин, тусламжийн чиглэлийг өөрчлөх эрсдэлийг зохицуулах боломжгүй газарт ажилладаггүй. Аюулгүй байдлын нөхцөл байдал болон орон нутгийн динамик байдал зэрэг нь тусламжийн байгууллага дэлхийн зарим нэгэн хэсэгт нэвтрэх боломжгүй болгодог.

## С. ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

52. Даян дэлхийн улам бүр өсөн нэмэгдсээр буй нарийн төвөгтэй байдал нь олон улсын хууль ёсны бүхий л тоглогчдод үйл ажиллагааныхаа нэгдмэл байдал, хариуцлагыг баталгаажуулах шинэ шаардлага бий болгоод байна. Ашгийн төлөө бус салбар нь эдгээр хэрэгцээ шаардлагыг нааштайгаар хүлээн авч, байгууллага нэг бүр үйл ажиллагаагаа хариуцлагатай, ил тод байлгахад нь туслах зорилгоор хэд хэдэн стандарт, санаачлагыг боловсруулж гаргаад байна (**3-р хавсралтыг** үзнэ үү?).

53. Олон орны ашгийн төлөө бус салбар төлөөллийн болон өөрийгөө зохицуулах байгууллагуудтай бөгөөд эдгээр нь террорист үйлдэл зэрэг олон төрлийн зүй бус үйлдэлд ашиглуулахаас салбараа хамгаалахад тодорхой үүрэг гүйцэтгэж чадах чухал нөөц юм. Ийм төрлийн шүхэр байгууллагууд АББ-уудын хууль ёсны байдал болон нэр хүндийг хамгаалахад шууд сонирхолтой байдаг бөгөөд эдгээр байгууллагуудын олон тооны чиг үүргийн хүрээнд шилдэг дадал туршлагыг судалж, сурталчлах ажлыг эртнээс хийж ирсэн. Янз бүрийн эрх мэдэл бүхий ашгийн төлөө бус салбар нь цаашилбал, өөрсдийн өөрийгөө зохицуулах арга хэмжээний туршлагыг түгээн дэлгэрүүлэх, ийм арга хэмжээг салбартаа авч хэрэгжүүлэхэд шаардагдах чадавхийг бий болгох (мөн өөр өөр эрх мэдлийн хүрээнд), сургалт зохион байгуулах, эдгээр арга хэмжээний үр ашиг, хамаарлыг хянах, үнэлэх чиглэлээр ажиллах боломжтой байдаг. АББ салбар дахь өөрийгөө зохицуулах механизмууд янз бүрийн эрх мэдлийн хүрээнд тасралтгүй хувьсан өөрчлөгдсөөр байгаа тул ийм

механизмгүй АББ-ууд үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах болон санхүүжилтийн байдлаа сайжруулах, терроризм, бусад төрлийн зүй бус үйлдлээс сэргийлэх зорилгоор дотоод хяналт, горим журам, хянан шалгалтын болон бусад арга хэмжээг бэхжүүлэхийн тулд өөрийн эсхүл нэмэлт өөрийгөө зохицуулах механизмыг хөгжүүлэх талаар авч үзэж болно.

54. АББ-ын үр дүнтэйгээр өөрийгөө зохицуулах үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг ашгийн төлөө бус салбарт илүүтэй ил тод байдал бий болгох, сайн засаглалыг төлөвшүүлэх арга хэмжээн дээр нэмээд террорист бүлэглэлүүдэд зүй бусаар ашиглуулах эрсдэлийг бууруулах арга хэмжээний томоохон бүрэлдэхүүн хэсэг болгохыг хөхиүлэн дэмжих нь зүйтэй.

#### Хайрцаг 4. АББ-ын өөрийгөө зохицуулах үйл ажиллагааны жишээ

Дараахь жишээ нь АББ-уудад хариуцлага, ил тод байдлыг хангахад туслах төлөөллийн болон өөрийгөө зохицуулах байгууллагуудын санаачлагын жишээ юм. Үүнд:

- Тухайн улсын АББ-уудад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, хандивлагчдад хариуцлагатай шийдвэр гаргахад нь туслах зорилготой хараат бус хяналтын байгууллага ил тод байдлын стандарт ба шилдэг дадал туршлагын талаар тайлан боловсруулсан. Энэхүү тайланд дотоодын хууль тогтоомж, ашгийн төлөө бус салбарын онцлог шинж чанар, ашгийн төлөө бус салбарын төлөөлөгчдийн дунд явуулсан санал асуулгын хариуг авч үзсэн. Ашгийн төлөө бус салбарын нийцэлд үнэлгээ хийхэд ашигладаг дараах стандартууд нь блок хэлбэрээр бүтэцлэгдсэн бөгөөд эдгээрийн ихэнх нь ашгийн төлөө бус салбарыг террорист зорилготой зүй бус үйлдэлд ашиглахтай тэмцэхтэй холбоотой асуудалд анхаарал хандуулсан:
  - Удирдах зөвлөл ажиллуулах болон түүний үйл ажиллагааны зохицуулалт;
  - Байгууллагын эрхэм зорилгыг тодорхой болгох, нийтэд мэдэгдэх;
  - Үйл ажиллагааны төлөвлөлт ба хяналт-шинжилгээ;
  - Гаргаж өгөх мэдээллийн үнэн зөв байдал болон энэ талаарх харилцаа холбоо;
  - Санхүүжилтийн ил тод байдал;
  - Санхүүжилтийн олон талт байдал;
  - Санмүүжилтийн зарцуулалтад тавих хяналт;
  - Ажлаа жилээр тайлагнах ба хуулийн шаардлагад нийцтэй байдал;
  - Сайн дурын үйл ажиллагааг сурталчлан таниулах.
- Шүхэр байгууллага нь удирдах зөвлөл, санхүүгийн хариуцлага ба ил тод байдал, санхүүжилт босгох, ажиллагсдын менежмент, сайн дурынхны оролцоотой холбоотой стандартыг баримталдаг бодлого болон горим журам хэрэгжүүлдэг АББ-уудад магадлан итгэмжлэл олгох хөтөлбөр хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргах, өөрт ногдсон үүргээ ягштал биелүүлэх үйл явц нь АББ-уудыг өөрсдийн үйл ажиллагааны тогтолцоо болон бодлогоо тогтмол хянан сайжруулахад дэмжлэг үзүүлдэг<sup>1</sup>.
- Олон улсын шүхэр байгууллага, гишүүн байгууллагуудын удирдах зөвлөл, олон нийтийн ашиг тусын төлөөх зорилго, санхүү, хөрөнгө босгох үйл ажиллагаа, ил тод байдалтай холбоотой стандарт тогтоох замаар ашгийн төлөө бус салбарыг хууран мэхлэгдэх зэрэг зүй бусаар ашиглагдахаас хамгаалах арга хэмжээ авсан. Үүнийг стандартын шаардлагыг хангасан гишүүн АББ-уудад итгэмжлэл олгох, ил тод байдал хангалтгүй гэж үзсэн гишүүдийг хар жагсаалтад оруулах бие даасан хяналтын үйл явцаар дамжуулан хэрэгжүүлдэг.

- Олон улсын хэд хэдэн тэргүүлэгч АББ-ууд улс төр, санхүүгийн хараат бус байдал, хариуцлагатай суртал ухуулга, оролцоотой, үр дүнтэй хөтөлбөр, тайлагналын ил тод байдал, мэдээллийн үнэн зөв байдал, сайн засаглал, мэргэжлийн үүднээс, ёс суртахуунтайгаар хөрөнгө босгох зэрэг асуудлыг өөртөө агуулсан дүрэм боловсруулж мөрдүүлэх үүрэг хүлээдэг. Гишүүн АББ-ууд өөрсдийн хөтөлбөртөө уг дүрмийн заалтуудыг мөрдөх, хараат бус санхүүгийн аудит хийлгэх болон жил бүр нийцлийн тайлан гаргах ба өөрийн хийсэн үнэлгээг олон нийтэд зориулж хэвлэн нийтэлдэг хараат бус хороогоор тайлангаа хянуулах үүрэг хүлээдэг<sup>2</sup>.

**Тэмдэглэл:**

1. Канадыг төсөөлөөд үз дээ, “Стандарт тогтоох хөтөлбөр” ([www.imaginecanada.ca/our-programs/standards-program](http://www.imaginecanada.ca/our-programs/standards-program)).
2. ОУТББ-ын хариуцлагын тухай дүрэм (2014) ([www.ingoaccountabilitycharter.org/home/what-is-the-charter/](http://www.ingoaccountabilitycharter.org/home/what-is-the-charter/)).

## D. АББ-УУДЫН САЙН ЗАСАГЛАЛ ХЭРХЭН 8-Р ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУС ДӨХӨМ ҮЗҮҮЛЭХ ВЭ?

55. Олон тооны АББ-ууд сайн засаглалыг төлөвшүүлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн олон төрлийн арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь террорист үйлдлийн эрсдэлийг бууруулахад тус дөхөм үзүүлдэг. Ангиллын тайлангийн тусламжтайгаар судалсан кейс судалгаанууд нь байгууллагуудын зохистой бус дотоод засаглал ба, эсхүл зохистой бус гадаад хяналтаас үүдэн ашгийн төлөө бус салбар террорист зорилгоор зүй бусаар ашиглагдаж байсныг жишээгээр харуулж өгсөн.

56. ФАТФ-ын тодорхойлолтын хүрээнд хамаардаг, ТС-д зүй бусаар ашиглагдах өндөр эрсдэлтэйд тооцогдсон АББ-уудын хувьд террорист үйлдэлд өртөхөөс өөрсдийгөө хамгаалах үр дүнтэй арга бол дотоодын сайн засаглалын практик дадлыг бий болгон хэвшүүлэх явдал юм. Жишээлбэл, хэдийгээр терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг тусгайлан авч үзээгүй боловч Трансперенси Интернэшнл байгууллага нь хүмүүнлэгийн үйл ажиллагаан дахь авилгаас урьдчилан сэргийлэх талаар шилдэг дадал туршлагын гарын авлага боловсруулан гаргасан. Гарын авлагад дурдсан олон сайн жишээ, туршлагууд нь байгууллагуудыг террорист үйлдэлд ашиглагдахаас хамгаалахад тустай байж болох юм<sup>22</sup>.

<sup>22</sup> Транспэрэнси Интернэшнл (2015).



57. Сайн засаглалыг дөрөв хуваан ангилж болно.

#### Хайрцаг 5. АББ-уудын сайн засаглал

АББ-уудын эрүүл дотоод засаглалын практик дадлыг дараах дөрвөн ангилалд хуваан авч үзэж болно. Үүнд:

- 1) Байгууллагын шударга буюу нэгдмэл байдал;
- 2) Түншийн харилцаа;
- 3) Санхүүгийн хариуцлага ба ил тод байдал;
- 4) Хөтөлбөрийн төлөвлөлт ба хяналт-шинжилгээ.

58. АББ-уудын сайн засаглалын тогтолцооны зарим шинж чанарыг дор тайлбарлав. Эхэндээ гол төлөв бусад зорилгоор, эсхүл бусад хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлдэг байсан сайн засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн эдгээр хяналтын арга хэмжээний нэлээд нь ТС-д зүй бусаар ашиглагдахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

#### 1) *Байгууллагын шударга буюу нэгдмэл байдал*

59. АББ-үүд нь өөрийн зорилго, зохион байгуулалтын бүтэц, тайлагнах горим зэргийг тусгасан дүрэм болон тухайн орон нутгийн хууль тогтоомжид нийцсэн удирдамж зэрэг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог засаглах буюу удирдан чиглүүлэх зорилготой баримт бичгийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулна. Түүний Удирдах зөвлөлийн гишүүд нь байгууллагын ашиг сонирхлыг ухамсарлан ойлгож, түүний төлөө ажиллана.

#### 2) *Түншийн харилцаа*

60. Түншүүдийн олгосон санхүүжилт зүй бусаар ашиглагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд АББ-үүд харилцаа холбоо үүсгэх буюу гэрээ хэлцэл байгуулахаас өмнө хандив өгсөн, үүнийгээ цааш санхүүжилт болгон олгосон болон хамтран ажилладаг хувь хүмүүс болон байгууллагуудад зохистой хянан шалгалт хийнэ. АББ-үүд түншлэгчдийн нэр хүндийг сонгосон шалгуур үзүүлэлтүүд, дотоодын болон НҮБ-ын хориг арга хэмжээний жагсаалт зэрэг олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглан баталгаажуулна. Бичгээр үйлдсэн гэрээг мөн хоёр талын хүлээлт болон хариуцлагыг тоймлон зураглахад ашиглах ба үүнд хөрөнгө санхүүжилт, байнга тайлагнах, аудит хийлгэх болон, газар дээр нь очиж ажил байдалтай танилцахад шаардагдах шаардлагыг нарийвчлан тусгана.

#### 3) *Санхүүгийн хариуцлага болон ил тод байдал*

61. АББ-үүд нь санхүүгийн хүчтэй хяналт, горим журам тогтоосноор нөөцийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлнэ. Жишээлбэл, байгууллагын Удирдах зөвлөл жилийн төсвийг баталж, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих зохицуулалттай байна. АББ-үүд үйл ажиллагааныхаа түршид олсон орлого, зарлага, санхүүгийн гүйлгээний бүртгэлийг хангалттай түвшинд, бүрэн хөтлөх бөгөөд үүнд хөрөнгийг эцсийн байдлаар хэрхэн ашигласан тухай асуудал мөн орно. АББ-үүд нь санхүүжилт босгох үедээ хөтөлбөрийн зорилтыг тодорхой илэрхийлэх ба санхүүжилтийг



зориулалтын дагуу зарцуулах нөхцлийг бүрдүүлнэ. Хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааныхаа талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоно. АББ-ууд нь орлогынхоо эх үүсвэрийн талаар мэдээлж, хандив авах, эсхүл татгалзах эсэхийг тодорхойлох шалгуурыг тогтооно.

#### 4) *Хөтөлбөрийн төлөвлөлт ба хяналт-шинжилгээ*

62. АББ-ууд нь хөрөнгө санхүү болон үйлчилгээг зориулалтын дагуу зарцуулж, эсхүл үзүүлж байгаа эсэхийг баталгаажуулах дотоод хяналт болон хяналт-шинжилгээний системийг бий болгоно. Жишээлбэл, АББ-ууд өөрийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээг ойлгомжтойгоор тодорхойлж, үр шим хүртэгч бүлгүүдийг олж тогтоон, төсөл хэрэгжүүлэхээс өмнө терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлон, уг эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна. Тэд төсөл нэг бүрийн төсвийг нарийвчлан боловсруулж, холбогдох худалдан авалт, зардлын талаар тогтмол тайлан гаргана. АББ-ууд санхүүжилт, үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн ашиглалтанд хяналт мөшгөлт хийж, санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахын тулд, боломжтой бол гүйлгээг банкны системээр дамжуулан хийж байх горим журам тогтооно. Төслийн үр шимийг хүртэгсэд байгаа эсэхийг баталгаажуулах, санхүүжилт хүлээн авах нөхцлийг хангах замаар төслийн гүйцэтгэлд тогтмол хяналт тавина. АББ-ууд шилжүүлсэн санхүүжилт болон үзүүлсэн үйлчилгээг тооцоолох буюу тайлагнах зохистой арга хэмжээ авна.

63. Дээр дурдсан олон арга хэмжээ нь голчлон ашгийн төлөө бус салбарт залилан мэхлэх, татвараас зайлсхийх, бусдын эд хөрөнгийг шамшигдуулах, мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой байж болох ч эдгээр нь ашгийн төлөө бус салбарын үйл ажиллагаа болон санхүүгийн урсгалд ил тод байдал болон шударга байдлыг дээшлүүлэх замаар террорист үйлдлийн хор хөнөөлийг багасгахад түслэх болно. Хэдий АББ-уудыг терроризмын зорилгоор ашиглахтай тэмцэхэд шүүд чиглээгүй байсан ч гэсэн, ашгийн төлөө бус салбарын ил тод байдал болон шударга байдлыг дээшлүүлэх Засгийн газрын санаачилгын тухайд ч мөн адил зарчим үйлчилнэ.

## V. АББ-УУДЫН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

64. Зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах явдал ач холбогдолтой хэдий ч, энэ нь АББ-уудад сөргөөр, сайтар дэнслээгүй байдлаас үүдэлтэй нөлөө үзүүлэх учиргүй гэж ФАТФ үздэг. АББ-ууд хүмүүнлэгийн болон буяны маш чухал үйлчилгээ үзүүлэхийн тулд банк, санхүүгийн үйлчилгээ авдаг. Гэсэн хэдий ч, сүүлийн жилүүдэд санхүүгийн байгууллагууд хууль ёсны АББ-уудын санхүүгийн үйлчилгээнд хамрагдах эрхийг цуцлах, хязгаарлах, эсвэл АББ-уудын гүйлгээг хийхдээ илүү цаг хугацаа зарцуулах болсон талаар зарим тайлангуудад дурдах болов. Эрсдэлийн түвшин болон эрсдэлийг бууруулах арга хэмжээг харгалзан үзэхгүйгээр тухайлсан үйлчлүүлэгчид, эсхүл тодорхой нэгэн үйлчлүүлэгчдийн анги давхаргын үйлчлүүлэх эрхийг цуцлах нь эрсдэлд-суурилсан аргыг зүй зохистойгоор хэрэгжүүлж чадахгүй байгаагийн илрэл бөгөөд энэ нь ФАТФ-ын стандартад нийцэхгүй үйлдэл юм. Ийм практик үйл ажиллагаа нь санхүүгийн урсгалыг далд хэлбэрт хөтлөн оруулж болзошгүй тул санхүүгийн ил тод байдлыг бууруулж, ТС үйлдлийг олж илрүүлэн, арга хэмжээ авах чадварыг бууруулдаг. АББ-уудын банкны дансыг цуцалж, хааснаар хөгжиж буй орнууд болон хүмүүнлэгийн хэрэгцээ нэн шаардлагатай, буяны буюу сайн санааны үйлс тухайлсан бүс нутагт болон даян дэлхийд терроризмтой тэмцэхэд эерэг нөлөө үзүүлдэг хямралын бүсэд тусламж хүргэхэд саад тотгор учруулдаг. Санхүүгийн байгууллагууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах боломжгүй тохиолдолд хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа холбоогоо цуцлах, эсхүл харилцаа холбоо тогтоохгүй байх асуудлыг тохиолдол нэг бүрээр авч үзэх нь зүйтэй байдаг<sup>23</sup>.

65. Баримт бичгийн энэ хэсэгт дараах зүйлсийг тодруулах зорилго тавьсан болно. Үүнд:

- a) Улс орнууд болон санхүүгийн байгууллагуудын зүй зохистойгоор ашигласан эрсдэлд-суурилсан арга хэрхэн хууль ёсны АББ-уудад санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байлгаж боломжтой болох;
- b) АББ-ууд санхүүгийн үйлчилгээний хүртээмжтэй байхын тулд ямар алхам хийж болох.

66. Санхүүжилтийн хэлцэлд ордог АББ-ууд өөрийн нэр дээр бүртгэлтэй банкны данстай, түүнд хөрөнгөө хадгалдаг, зохицуулалттай сувгаар санхүүгийн, түүний дотор нэн ялангуяа, олон улсын шилжүүлэг, гүйлгээг хийдэг байх ёстой. Боломжтой нөхцөлд, АББ-ууд санхүүгийн гүйлгээ хийхдээ хяналт зохицуулалттай систем ашиглах ёстой. Энэ нь, ашгийн төлөө бус байгууллагуудын данс бүртгэлийг зохицуулалттай банкны системд оруулж, уг системийн хүрээнд хяналт тавих, зохицуулалт хийх боломжтой болгодог.

67. Бэлэн мөнгийг төлбөр гүйцэтгэх цорын ганц арга хэрэгсэл болгон ашигладаг тохиолдол, жишээ нь санхүүгийн үйлчилгээ авах боломжгүй, ялангуяа алслагдсан бүс нутагт АББ-ууд тусламж үзүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцөлтэй тулгарч болно. Бэлэн мөнгө нь байгалаасаа террорист үйлдэлд өртөх илүү өндөр эрсдэлтэй тул бэлэн мөнгө ашиглахдаа санхүүжилтийн ил тод байдал болон хариуцлагыг дээшлүүлэхийн тулд олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн дагуу, түүний дотор бэлэн мөнгөний мэдүүлэг бүрдүүлэх болон, эсхүл бэлэн мөнгөний зарцуулалтын мэдээллийг ил болгох шаардлагад нийцүүлэх замаар зүй зохистой байдлаар ашиглах шаардлагатай.

68. Санхүүгийн байгууллагууд бүх АББ-уудыг өндөр эрсдэлтэй гэж үзэж болохгүй. Дийлэнх АББ-уудын хувьд (энэхүү нэр томъёог энд, ФАТФ-ын тодорхойлсон АББ-уудын дэд бүлгээс давсан өргөн

<sup>23</sup> 10-р зөвлөмж (ФАТФ, 2012).

утгаар нь ашигласан) террористуудыг санхүүжүүлэхэд ашиглагдах эрсдэл хэрвээ байгаа бол, маш бага гэж үздэг. Жишээлбэл, санхүүгийн байгууллагууд АББ-уудыг (энэ нэр томъёог ФАТФ-ын тодорхойлсоноор авч хэрэглэв) бэлэн мөнгө ашигладаг орчинд, эсхүл хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээ ихтэй улс оронд үйл ажиллагаа явуулдаг гэдгээр шалтаглан өндөр эрсдэлтэй гэж тооцож болохгүй гэж үздэг.

69. Хэн нэгэн үйлчлүүлэгч (үүнд АББ багтана) эрсдэлтэй байж болзошгүй гэж үзвэл, санхүүгийн байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг (үйлчлүүлэгчид, улс орнууд эсвэл газарзүйн бүс нутаг; бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ болон хүргэх сүвгийн тухайд) тодорхойлох, АББ-уудын зүгээс эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлдэг арга хэмжээнд үнэлгээ хийх хэрэгтэй. Санхүүгийн байгууллагууд олж тогтоосон эрсдэлийг үр дүнтэйгээр удирдан залах боломж бүрдүүлэх бодлого, хяналтын механизм, горим журамтай байх ёстой. Практикт хэрэгжүүлэх талаасаа, тодорхой АББ-д тулгарсан байж болзошгүй эрсдэлийг үнэлэхдээ санхүүгийн байгууллагууд дараах зүйлсийг анхааралдаа авсан байх ёстой<sup>24</sup>. Үүнд:

- a) Эрсдэлийг бууруулах зорилгоор АББ-ын авч хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээ;
- b) АББ-д хамаарах, үүний дотор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тусгайлан зориулагдаагүй хэдий ч, сайн засаглалыг төлөвшүүлэх, зүй зохистой хянан шалгалтын арга хэмжээ авах, татварын болон бусад зорилгоор тэдгээрт үйл ажиллагаагаа тайлагнах шаардлага тавих зэргээр терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад тус дөхөм үзүүлдэг зохицуулалтын шинжтэй шаардлага.

70. Практикт хэрэгжүүлэх талаасаа, эрсдэлийн үнэлгээ хийсний дараа тухайн АББ-тай холбоотой тодорхой эрсдэл олж тогтоосон тохиолдолд, санхүүгийн байгууллага юуны өмнө АББ-ын хууль ёсны сайн санааны үйлсийг үргэжлүүлэх боломж олгохуйц зохистой хамгаалалт хийж, арга хэмжээ авах замаар эрсдэлийг хангалттай хэмжээгээр бууруулах боломжтой эсэхэд үнэлгээ хийх ёстой. Ийм арга хэмжээнд зарим төрлийн гүйлгээг оролцуулахгүйгээр тодорхой хэмжээний гүйлгээ хийж болох горим ашиглах, гүйлгээг дамжуулах батлагдсан чиглэл буюу маршрутыг зөвшөөрөлцсөн байх зэрэг багтана.

71. Улс орнууд санхүүгийн салбар болон хяналтын байгууллагуудтай хамтран эрсдэлд-суурилсан аргыг зүй зохистойгоор ашиглахад юу шаардагдах асуудлаар харилцан ойлголцол бий болгох, хүртээмжтэй санхүүгийн зорилгыг ханган биелүүлэх боломж бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах явдал сайн дадал туршлагад тооцогддог. Ингэхдээ, улс орнууд ФАТФ-ын *Эрсдэлд-суурилсан аргыг банкны салбарт ашиглах зааварчилгаа* болон *Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ба санхүүгийн хүртээмжийн тухай шинэчилсэн зааварчилгааг* тус тус анхааралдаа авсан байх шаардлагатай. Түүнчлэн, санхүүгийн салбар нь эрсдэлийн талаар болон эрсдэлийг бууруулах бүхий л талуудын санал нэгдсэн эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах чиглэлээр хамтран ажиллахад тус дөхөм үзүүлэх зорилгоор энэ асуудлаар санал бодлоо солилцох үйл ажиллагаанд ашгийн төлөө бус салбар, эсхүл тодорхой АББ-уудыг илүүтэй татан оролцуулах талаар анхаарч үзэх нь зүйтэй.

<sup>24</sup> 1-р зөвлөмжийн тайлбар бичгийн 8 болон 9 –р зүйл буюу дөх догол мөр (ФАТФ, 2012).

### Хайрцаг 6. Санхүүгийн болон ашгийн төлөө бус салбар хоорондын хамтын ажиллагаа

Сири болон түүний эргэн тойронд тусламж шаардлагатай байгаа иргэдэд илгээж буй тусламжийг Их Британи, Европын холбоо болон АНУ-ын хориг арга хэмжээнд нийцтэй байдлаар, зориулалтын дагуу ашиглах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор АББ-уудад зориулсан дараах зааварчилгааг Их Британийн Банкируудын Холбоо, Их Британийн Гамшгийн Онцгой Байдлын Хороо, АББ-уудын шүхэр байгууллага хамтран боловсруулсан. Үүнд:

- Хориг арга хэмжээ авсан улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөтөлбөрүүдийн талаарх нэг хуудас товч заавар буюу мэдээллийг банкуудад өгөх. Энэ нь, зорилго болгож буй үр шимийг хүртэгсэд, тэдгээрийг хэрхэн сонгож авсан, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, хэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх (жишээлбэл, байгууллага өөрөө, эсхүл тухайн улс дахь түнш байгууллага), тухайн улсад зориулан хийх худалдан авалтын горим журам зэрэг мэдээллийг багтаасан байх ёстой.
- Орон нутгийн түншүүдэд хэрхэн хянан шалгалт хийсэн болох, үүний дотор, харилцан холбоогоо зарлахаас өмнө хийсэн сонголт буюу шигшилтийн давтамж, шигшилт хийхэд ашигласан хоригийн жагсаалт болон хангасан байвал зохих шалгуур үзүүлэлтүүдийн талаар тайлбарласан байх.
- Хориг арга хэмжээний тухай хууль тогтоомжид нөлөө үзүүлэх тул нөлөөлөлд өртөхөөр байгаа төлбөр гүйцэтгэх валютыг анхааралдаа авах
- Банкуудад гүйлгээ тус бүрийн зорилгын талаар дэлгэрэнгүй тайлбар өгөх ба, үүнд тухайн гүйлгээний талаар мэддэг, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл өгч тусалцаа үзүүлэх тухайн байгууллагын холбогдох хүний харилцах утасны дугаарыг дурдсан байх.
- Мөн төлбөрийн хэмжээ, валют, тухайн дансыг нээсэн банкны нэр, дансны нэр, орон нутаг дахь түншийн нэр, тухайн орон нутгийн засаг захиргаа, эсхүл хориг арга хэмжээ авсан талтай холбоотой холбоосуудын тодорхойлолт, мөн гүйлгээ хийхийг зөвшөөрсөн тусгай, эсхүл ерөнхий зөвшөөрлийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөх.
- Шаардлагатай тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэх ерөнхий эсхүл тусгай зөвшөөрөл олгодог, төлбөрийн зааварчилгаанд дурдсан тусгай зөвшөөрлийн талаар лавлагаа буюу тодорхойлолт гаргаж өгөх зохицуулагч байгууллагуудтай хамтарч ажиллах. Энэ нь, банкинд тухайн төлбөр тооцооны хууль ёсных болох эсэхийг баталгаажуулах, хийж гүйцэтгэх төлбөрийг хойшлуулж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэхэд тус дөхөм үзүүлнэ.
- Төлбөрийн хууль ёсных мөн эсэхийг тодорхойлох хариуцлага хүлээх. Банкууд нь холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх боломжтой бөгөөд байгууллага нь төлбөр хийхээс өмнө өөрийн хуулийн багтай энэ талаар зөвлөлдөх.

72. Хандивлагчдын хувьд, АББ-ууд хэрхэн ажилладаг, хэрхэн удирддаг, хөтөлбөрийнх нь мөн чанар, хаана үйл ажиллагаагаа явуулдаг болохыг олж мэдэхийн тулд олон нийтэд нээлттэй материалыг судлах үл суурьтай алхам хийх нь зүйтэй. Энэ нь, террористуудыг санхүүжүүлэх эрсдэлтэй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг АББ-уудын тухайд ялангуяа гарцаагүй хийх ёстой алхам юм.

73. Практик талаасаа, дараах зүйлс АББ-уудын санхүүгийн байгууллагууд болон хандивлагчдад хандах боломжид эерэгээр нөлөөлж болох талтай. Үүнд:

- a) Санхүүгийн байгууллагуудтай ажил төрлийн үр дүнтэй харилцаа холбоо тогтоох;
- b) Санхүүгийн байгууллагатай идэвхтэй яриа хэлцэл өрнүүлэх, үүний дотор, санхүүгийн байгууллагыг холбогдох баримт бичгээр хангах;
- c) АББ-ын өртөж болзошгүй аливаа терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаар ухамсарлан ойлгодог гэдгээ илтгэн харуулах;
- d) АББ нь зохицуулалтын үүргээ биелүүлэх хүрээнд, эсхүл, хандивлагчдын тавьсан шаардлагыг биелүүлэх, эсхүл өөрсдийн санаачлагаар ТС эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн болохоо илтгэн харуулах;
- e) Болзошгүй хүндрэл гарсан тохиолдолд, АББ-ын үйл ажиллагаанд оролцсон хувь хүнтэй холбоотой санаа зовнивол зохих асуудал байгаа эсэхийг санхүүгийн байгууллагаар баталгаажуулах, эсхүл энэ нь тодорхой нэгэн улс орон, эсхүл бүс нутгаас хийгдэх гүйлгээнээс хамааралтай эсэхийг тодруулах, мөн АББ-ын зүгээс нэмэлт арга хэмжээ авах боломжтой эсэхийг, эсхүл эрсдэлийг бууруулахад чиглэсэн хангалттай арга хэмжээ авсан талаараа санхүүгийн байгууллагатай ярилцах;
- f) Шаардлагатай гэж үзвэл, эрсдэлийн нөхцөл байдал болон оршин буй эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар тодруулахад туслах зорилгоор энэхүү харилцан ярианд тэдний шүхэр байгууллагууд, өөрийгөө зохицуулах байгууллагууд ба эс бөгөөс хандивлагчдыг татан оролцуулах.

## 1-Р ХАВСРАЛТ

### УЛС ОРНУУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШЭЭ

1. Эдгээр нь улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний жишээ бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамаарч ТС-ийн эрсдэлийг бууруулахад тус дөхөм үзүүлэх боломжтой. Бодит амьдрал дээр, тухайлсан тохиолдлын нөхцөл байдал болон өвөрмөц онцлог нь тухайн арга хэмжээ тодорхой эрсдэлийг хэсэгчлэн, эсхүл бүрэн хэмжээгээр бууруулах сайн жишээ болж чадах эсэхийг тодорхойлно. Ийм тодорхойлолтод хамаарах нөхцөл байдлын төрлүүд болон тухайлсан нутаг орны өвөрмөц онцлог гэдэгт ТС-ийн эрсдэлийн түвшин болон төрөл, буяны буюу сайн санааны үйлсийн санхүүжилтэд зориулж буй хөрөнгийн хэмжээ, төрөл, эсхүл хуваарилсан хөрөнгө, газарзүйн нөхцөл байдал болон Засгийн газрын эдүгээ авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бусад анхаарвал зохих зүйлс хамаарна.
2. Эдгээр жишээг бүхий л нөхцөл байдалд ашиглаж болох арга хэмжээний хяналтын жагсаалт, буюу “алтан стандарт” гэж үзэн ашиглаж болохгүй. “Бүгдэд таарч тохирох нэг л жор” арга нь 8-р зөвлөмжид дурдсанчлан, эрсдэлд-суурилсан аргыг зүй зохистойгоор хэрэгжүүлэх шаардлагад нийцэхгүй.
3. Жишээг дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсэгт хуваан авч үзлээ. Үүнд:

#### Хайрцаг 7. Ашгийн төлөө бус салбарыг хамгаалах үр дүнтэй арга зам

Ашгийн төлөө бус салбарыг хамгаалах үр дүнтэй арга зам нь тухайн нөхцөл байдал, ТС-ийн эрсдэл, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дотоодын эрх зүйн хүрээ болон тухайн нутаг орны хувьд анхаарвал зохих бусад зүйлсээс хамаарсан дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг ямар нэг хэмжээгээр өөртөө багтаана. Үүнд:

- 1) Салбарыг хамарсан сурталчилгаа;
- 2) Түнгий нь тааруулсан, эрсдэлд-суурилсан хяналт шалгалт, эсхүл хяналт-шинжилгээ;
- 3) Мөрдөн шалгах болон мэдээлэл олж авах үр дүнтэй үйл ажиллагаа;
- 4) Олон улсын хамтын ажиллагааны үр дүнтэй механизм.

## САЛБАРЫГ ХАМАРСАН СУРТАЛЧИЛГАА

### Хайрцаг 8. Испани

Испани Улсын Эдийн засаг ба Өрсөлдөх чадварын яамны харьяа Tesoro Publico (Төрийн сан) нь “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь: Ашгийн төлөө бус салбар” нэртэй шилдэг дадал түршлага ба зөвлөмж боловсруулах ажлыг удирдсан<sup>1</sup>. Засгийн газрын вэб хуудсанд тавигдсан уг баримт бичгийг АББ-уудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг эрх бүхий байгууллагууд, уг салбарыг төлөөлдөг төлөөллийн байгууллагууд болон АББ-уудтай зөвлөлдөх үндсэн дээр боловсруулжээ. Уг баримт бичиг нь АББ-уудыг террорист бүлэглэл, байгууллагуудтай холбогдсон этгээд, аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүжилт, нөөц шилжүүлэх суваг болгон ашиглуулахгүй байх үүргээ биелүүлэхэд нь албан тушаалтнуудад туслах зорилго агуулсан. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай эсэх нь АББ-уудад тулгарч болох эрсдлээс хамаарна хэмээн үзсэн бөгөөд чухам аль төслүүд илүү өндөр эрсдэлтэй болохыг тодорхойлохын тулд АББ-ууд өөрийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг судалж шинжлэх, түүнд үнэлгээ хийх шаардлагатай болох талаар уг баримт бичигт онцолсон байна. Энэхүү баримт бичигт шударга байдал болон нэр хүндээ хамгаалах зорилгоор үйл ажиллагааны дараах гурван хэсэгт тавих хяналтаа АББ-ууд хэрхэн чангатгах талаар авч үзсэн. Үүнд:

- *Удирдах зөвлөл/удирдах албан тушаалтнуудын үйл ажиллагаа.* Удирдах албан тушаалтнууд болон голлох үүрэгтэй ажилтнуудын удирдах ёс зүй болоод мэргэжлийн хувьд эрхэлсэн ажилдаа тохирч буй эсэхийг баталгаажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болох талаар уг баримт бичигт онцлон тэмдэглээд, АББ-уудын зүгээс удирдах зөвлөл болон удирдах албан тушаалтнуудад олгосон эрх мэдлийн асуудлаар дэг журам тогтоож, тогтоол батлахтай холбоотой хүлээх үүрэг хариуцлага болон горим журмыг ойлгомжтой байдлаар тодорхойлохыг зөвлөсөн. Удирдах албан тушаалтнууд АББ-уудын ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаа явуулж, удирдах зөвлөл нь хариуцлагатай, ил тод байх явдлыг хангах нөхцөл бүрдүүлсэнээр терроризм болон террористуудыг санхүүжүүлэх зэрэг олон зорилгоор АББ-ыг зүй бусаар ашиглаж болзошгүй хүмүүсийн халдлагаас урьдчилан сэргийлэх боломжтой.
- *Үйл ажиллагааны төлөвлөлт ба техникийн хяналт-шинжилгээ.* АББ-ууд нь терроризмыг санхүүжүүлэх зэрэг гэмт хэргийн зорилгоор мөнгө завшихаас урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөлт болон хяналт-шинжилгээг ашиглаж болно. Энэхүү баримт бичигт АББ-ууд өөрсдийн зорилго болон үйл ажиллагааных нь үр шимийг хүртэгсдийг ойлгомжтой байдлаар тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхээр төлөвлөөгүй аливаа үйл ажиллагаа явуулахгүй байхыг зөвлөмж болгосон. Эрсдэл чухам хаана оршин буйг олж мэдэх, үйл ажиллагаагаа явуулах тодорхой зааварчилгаа боловсруулж гаргах, эдгээр үйл ажиллагааг тогтмол хянах нь АББ-уудад нөөцийг зориулалтын дагуу ашиглахад тус дөхөм үзүүлнэ.
- *Санхүүгийн ил тод байдал.* АББ-ууд санхүүгийн ил тод байдал болон хариуцлагыг баталгаажуулах ёстой. Хөрөнгийн эх үүсвэр болон түүний ашиглалтыг эргэн шалгах, хяналт-шинжилгээ хийх санхүүгийн хүчтэй хяналт нь АББ-уудад нөөцийг террорист үйл ажиллагаанд зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад тус дөхөм үзүүлнэ.

1. Энэхүү баримт бичиг нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлын аль алинд хамаарах боловч энэхүү тайланд терроризмыг санхүүжүүлэхтэй хийх тэмцлийн зорилгоор иш татсан болно



### Хайрцаг 9. Франц

Францын Сангийн яам терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөж болзошгүй холбоодод зориулсан сайн зан төлөв буюу ёс зүйн гарын авлагыг вэб хуудсанд дээрээ байршуулсан байдаг. Энэхүү баримт бичиг нь ФАТФ-ын 8-р зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбоод болон тэдгээрийн менежерүүдэд тодорхой эрсдэлийн талаар анхааруулга өгөх, тэдгээрт хийж гүйцэтгэдэг хянан шалгах үйл ажиллагаагаа сайжруулах, хангалттай түвшний дотоод бодлого, горим журам болон хяналт бий болгоход нь туслалцаа үзүүлэх зорилго агуулсан. Уг удирдамж чиглэл нь ФАТФ-ын 8-р зөвлөмж болон ФАТФ-ын зүгээс авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг арга хэмжээний (салбарын тухай мэдлэг, ойлголт, хяналт ба хяналт-шинжилгээ, мэдээлэл олж авах болон үр дүнтэй хянан шалгалт хийх, АББ-уудын талаарх гадаадын хүсэлтэд хариу өгөх чадавхи) талаар тайлбар өгсөн. Түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх, түүний дотор хөрөнгө царцаах асуудлаархи үндэсний болон Европын эрх зүй, бодлогын зохицуулалт болон тоноглол хэрэгсэл, аюул заналын эрсдэлийн үнэлгээ; санхүүжилт, түүний дотор хандивтай холбоотой хууль эрх зүйн шаардлага; санхүүгийн зохистой менежментийн хүсэл эрмэлзэл буюу хүлээлт; менежерийг томилоход тавигдах шаардлага болон холбоодын тухай хууль эрх зүйн заалтуудын талаар тайлбарласан.

Францын санхүүгийн мэдээллийн алба (СМА) болох Тракфин нь жилийн үйл ажиллагааны тайлан, Сангийн яамны вэб хуудсанд байршуулсан ангиллын тохиолдол болон зарим анхаарал хандуулбал зохих шалгуур үзүүлэлтүүд, холбоодын гагцхүү бэлэн мөнгөөр санхүүжилт авдаг банкин дахь данс, холбооны банкин дахь дансыг дамжуулах данс хэлбэрээр ашиглах, холбоо бодитой үйл ажиллагаа явуулдаггүй, холбооны банкин дахь данснаас хувь хүний банкин дахь данс рүү гүйлгээ хийгддэг урсгалтай, холбооны эргэн тойрон "нууцлаг", нууцлаг орчинтой холбогдох харьцангуй бага санхүүгийн урсгалтай зэрэг холбоодыг терроризмыг санхүүжүүлэхэд зүй бусаар ашиглах асуудалд анхаарал хандуулсан индексийн талаар хэвлэн нийтэлсэн.

### Хайрцаг 10. Англи

Англи болон Уэльсийн Энэрлийн комисс нь буяны үйл ажиллагааны хэд хэдэн чухал салбарын хүрээнд залилан мэхлэлт, зүй бус үйлдэл, тэр дундаа террорист байгууллагуудын зүй бус үйлдэл зэрэг асуудлуурхи мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цөөн хүний бүрэлдэхүүнтэй сурталчилгааны баг байгуулсан. Багийн зорилго нь буяны байгууллагууд (АББ) зүй бусаар ашиглагдахаас өөрсдийгөө хамгаалах боломжийг олгохын тулд оролцогч талуудтай үр дүнтэй, нягт хамтын ажиллагаа өрнүүлэх явдал юм. Сурталчилгааны баг нь Сирид өндөр эрсдэлтэй нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг буяны байгууллагууд, гуравдагч талуудын зохион байгуулсан арга хэмжээний үеэр үг хэлэх, мөрдөж ажиллавал зохих удирдамж чиглэлийг сурталчлах болон асуудал өөрчлөгдөх хэрээр шинэ удирдамж чиглэл гаргах зэрэгт анхаарлаа төвлөрүүлж ажилладаг.

Сурталчилгаа баг нь мөн түнш байгууллагуудад хянан шалгалт болон хяналт-шинжилгээ хийх, үлс хооронд мөнгөн шилжүүлэг хийх, терроризмын эсрэг хууль эрх зүй болон шаардлага, тусламж, ажилтнууд болон сайн дурын ажилтнуудыг илгээх зэрэг асуудлаар "сэрэмжлүүлэг" өгдөг.

Үүн дээр нэмээд, Энэрлийн комисс нь Сирид аюулгүй байх асуудлаархи ном товхимол болон мэдээлэлийг өөрийн вэб хуудсанд байршуулдаг. Үүнд, өндөр эрсдэлтэй, хамгаалалтгүй, аюултай орчинд хүмүүнлэгийн тусламж үзүүлж байсан туршлагатай, Сири болон, эсхүл эргэн тойрны улс орнуудад тусламжийн үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй буяны байгууллагуудад хандив өргөх асуудлаарх зөвлөгөө орсон.



Энэрлийн комисс нь шүхэр байгууллагууд, салбарын манлайлагчидтай хамтран терроризм, залилан мэхлэлт, бусад хэлбэрийн зүй бус үйлдлээс өөрсдийгөө хамгаалах зорилго бүхий сайн засаглал, хариуцлагын стандартыг бий болгоход туслах цахим гарын авлагыг боловсруулсан. Уг гарын авлагад терроризмын эсрэг хууль тогтоомж хэрхэн буяны байгууллагуудад үйлчлэх, үндэсний болон олон улсын түвшний томилогдох түншүүдийн жагсаалт, хэт туйлшрал болон хэт нэг талыг баримтлах хүчирхийллийн үр нөлөөний талаарх асуудлыг тусгасан. Үүнд мөн, түншийн гэрээ хэлцэл, хяналтын жагсаалт болон кейс судалгааны маягт зэрэг практик үйл ажиллагааны жишээ болон арга хэрэгслийн талаар тусгаж өгчээ.

### Хайрцаг 11. Америкийн нэгдсэн улс

АНУ нь АНУ-ын ашгийн төлөө бус салбартай, түүний дотор буяны байгууллагууд, хандивлагчид, Мусульман- Америкийн нийгэмлэг, Сомали-Америкийн нийгэмлэг, Сири Америкийн нийгэмлэг гэх мэт тодорхой нийгэмлэгүүдтэй тогтвортой яриа хэлэлцээ хийдэг. АНУ улс орон даяар олон нийтийн манлайлагч, удирдагч нар болон гишүүдтэй тогтмол уулзан ярилцахын тулд олон нийтэд зориулсан сурталчилгааны арга хэмжээнд тогтмол оролцдог. АНУ нь мөн АНУ-ын Сангийн яам зэрэг байгууллагын вэб хуудсанд байршуулах зэргээр буяны салбарыг террорист зүй бус үйлдлээс хамгаалахтай холбоотой олон тооны зааварчилгааны материалаар хангадаг<sup>1</sup>.

Эдгээр хэвлэн нийтлэгдсэн материалуудын тоонд Гадаад дахь хөрөнгийг хянах алба (OFAC)-ны эрсдэлийн матриц, сайн дурын удирдамж, буяны үйл ажиллагааны талаарх түгээмэл асуулт, хариулт, буяны салбарыг зүй бусаар ашиглагдахаас хамгаалахтай холбоотой гэрчийн мэдүүлэг, буяны байгууллагуудын эсрэг авсан дотоодын хориг арга хэмжээ, болон ТС-ийн аюул занал болон эрсдэлийг бууруулах шилдэг практик үйл ажиллагааны талаарх олон улсад зориулж хэвлэгдсэн баримт материалүүд орсон байдаг. Эдгээр хэвлэлийг тоймлон судалж, АНУ-ын буяны салбартай зөвлөлдөх уулзалт хийх үндсэн дээр үе үе шинэчилдэг.

АНУ-ын Сангийн яамны нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн матриц<sup>2</sup> ба Терроризмын эсрэг санхүүжилтийн удирдамж<sup>3</sup> зэрэг АНУ-ын ашгийн төлөө бус салбарт зориулсан сайн дурын шинжтэй зааварчилгааг АНУ-ын буяны байгууллагуудад зориулан тэдний зарим үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тодорхойлох, өндөр эрсдэлтэй газар нутагт санхүүжилт хийхдээ эрсдэлд-суурилсан үр дүнтэй аргыг хэрэглэхэд нь туслах зорилгоор боловсруулсан.

Эрсдэлийн матриц ба удирдамжийг хянан шалгалт хийхдээ харгалзан үзэх ёстой эрсдэлийн талаархи ойлголт, эрсдэлийг бууруулах шилдэг практик дадал буюу туршлагын зарим жишээг бий болгох зорилгоор АББ-уудад зориулж боловсруулсан. Эдгээр удирдамж чиглэл өгсөн баримт бичиг нь нийцлийн зохистой хөтөлбөр боловсруулахдаа, нэн ялангуяа, өндөр эрсдэлтэй газар нутагт гадаад үйл ажиллагаа явуулдаг буяны байгууллагууд ашиглахад туслах зорилго агуулдаг. Матриц нь тодорхой нэг буяны байгууллага буюу түүний үйл ажиллагааг зүй бусаар ашиглах, эсхүл мөлжлөгийг илтгэдэг эрсдэлт хүчин зүйлсийн дэлгэрэнгүй жагсаалт биш бөгөөд буяны байгууллага эсхүл буцалтгүй тусламж хүлээн авагч хууль бус үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэхийг тодорхойлох зорилго агуулдаггүй. Уг удирдамж чиглэл нь террорист байгууллагуудын зүй бус үйлдэл, эсхүл мөлжлөгийн эрсдлээс илүүтэй хамгаалж болохуйц практик дадлыг бий болгоход анхаарвал зохих буяны салбарт зориулсан сайн дурын зөвлөмж юм.

#### Тэмдэглэл

1. [www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Pages/protecting-index.aspx](http://www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Pages/protecting-index.aspx)
2. [www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Documents/charity\\_risk\\_matrix.pdf](http://www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Documents/charity_risk_matrix.pdf)
3. [www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Pages/protecting-charities-intro.aspx](http://www.treasury.gov/resource-center/terrorist-illicit-finance/Pages/protecting-charities-intro.aspx)

## Хайрцаг 12. Канад

Канад улсад бүртгэлтэй буяны байгууллагуудын үндэсний зохицуулагч байгууллага болох Канадын Орлогын Агентлаг (CRA) буяны байгууллагуудад хууль эрх зүйн болон зохицуулалтын үүргээ биелүүлэхэд нь туслах зорилгоор өөрийн вэб хуудсанд мэдээлэл байршуулдаг. Энэ нь залилан мэхлэлт, мөнгө угаах, эсхүл терроризмд дэмжлэг үзүүлэх гэх мэт аливаа төрлийн бодит болон сэжигтэй зүй бус үйлдлээс өөрсдийгөө хамгаалах зорилгоор байгууллагын дотоод засаглал, хариуцлагын оновчтой горим журам боловсруулж хэрэгжүүлэх, санхүүгийн хяналт, эрсдэлийн менежментийн тогтолцоо бүрдүүлэх, үйл ажиллагаагаа ил тод тайлагнахыг буяны байгууллагуудад зөвлөдөг. Уг агентлаг нь террорист үйлдэлд өртөж болзошгүй эмзэг байдлыг олж тогтооход нь буяны байгууллагуудад туслах зорилгоор дараах агуулга бүхий хяналтын хуудсыг вэб хуудсандаа байршуулсан байдаг. Үүнд:

- Нэгдсэн үндэстний тухай хууль болон Эрүүгийн хуулийн дагуу Канадад жагсаалтад орсон терроризмтой холбоотой хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын талаар та мэдэх үү? Эрүүгийн хууль болон Буяны байгууллагуудыг бүртгэх тухай (аюулгүй байдлын тухай мэдээлэл) хуулийн терроризмын санхүүжилт, дэмжлэгийн тухай заалтууд болон хуулийн эдгээр заалтуудыг зөрчсөнөөс үүдэх үр дагаврын талаар та мэдэх үү?
- Танай байгууллагын удирдлагын зөвлөл, ажилтнууд, хандив цуглуулагчид болон сайн дурын ажилтнуудын тухай болон тэдгээрийн холбоо сүлбээний талаар та сайн мэдэх үү?
- Та Канадын орлогын агентлагийн [хангалттай данс бүртгэл хөтлөлт](#) and [бүртгэл, үйл ажиллагаа, зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд оролцох](#), [Канадаас өөр газар нутагт үйл ажиллагаа явуулах](#) болон [хилийн чанад дахь буяны үйл ажиллагааны](#) тухай зааварчилгаатай танилцсан уу?
- Танайд зүй зохистой, найдвартай, дотоод санхүүгийн болон бусад хяналт, баталгаажуулалтын хяналт шалгалт, жишээ нь, бэлэн мөнгө цуглуулах, түүнтэй харьцах, байршуулах, баримт олгох үйл ажиллагааны төлөөлөл болон эрх мэдэл хуваарилалтын зохистой хяналт бий юу?
- Боломжтой тохиолдолд, танай байгууллага ердийн банкны механизмыг ашиглан мөнгө шилжүүлдэг үү? Хэрэв тийм биш бол, танай байгууллагад нэр хүндтэй альтернатив систем ашиглаж буяны сангийн хөрөнгөө хамгаалах, хэрхэн, хэзээ ашигласныг харуулах эрүүл саруул нэмэлт хяналт болон аудитын баримт бий юу?
- Танай материаллаг бааз буюу байгууламж, жишээ нь танай оффис эсвэл уулзалтын өрөө, нэр, банкны данс, зээлийн карт, вэб хуудас, компьютерийн систем, утас, факсыг (юуны тухай ярьж, ямар материал тарааж байгаа, эсхүл орхигдуулж байгаа талаар) хэн, ямар зорилгоор ашигладаг талаар та мэдэх үү?
- Таны нийтэд зориулсан мэдэгдэлдээ дурдсан хүн, эсхүл шалтгааныг өөр хэн дэмжиж байгааг болон таны нэрийг дэмжигч хэмээн хэн ашиглаж буйг та олж тогтоохыг хичээдэг үү?
- Танд өгсөн хандив болон бусад дэмжлэг чухам хаанаас эх сурвалжтайг та мэдэх үү?
- Танай буяны байгууллагын мөнгө, нөөцийн үр шимээ өгч байгаа төсөл дээр хэн эцсийн хяналт тавьдаг, юүнд ашиглагдсан, төсөл дууссаны дараа мөнгө, нөөцийг юүнд ашигладаг талаар та мэдэх үү?
- Танай байгууллагын хийж гүйцэтгэж буй ажлыг түншүүд болон хамаарал бүхий этгээд бусад байгууллагуудад хүргэж буй эсэх талаар та мэдэх үү?
- Та Канад болон гадаадад байгаа төлөөлөгчид/гэрээт гүйцэтгэгчид/бусад түншүүдтэй ямар үйл ажиллагаа хамтран явуулах, тэдгээрийг хэрхэн хянах, тооцох талаар бичгээр үйлдсэн тодорхой гэрээ байгуулсан үү? Гэрээ хэрэгжиж байгаа эсэхийг шалгадаг үү?

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

### Хайрцаг 13. Норвеги

Норвегийн АББ-ууд өндөр эрсдэлтэй газар нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд санхүүжилтийнхээ тэн хагасыг Норвегийн Засгийн газраас авдаг. Үүнтэй холбоотойгоор, тэдэнд бүртгэлд хамрагдах, ашигласан санхүүжилтээ тайлагнах, орлого, зардлын тайлан үйлдэж тушаах, өөрсдийн үйл ажиллагааны үр шимийг хүртэгсэд болон хамаарал бүхий АББ-уудын талаар мэдлэг ойлголттой байх зэрэг хяналтын хэд хэдэн арга хэмжээ авах шаардлага тавигддаг. Хууран мэхлэлт, авилга болон терроризмын санхүүжилтийг олж илрүүлэхэд чиглэсэн эдгээр арга хэмжээ нь санхүүжилт авдаг гадаадын АББ-уудад мөн хамаардаг.

Норвегийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (Norad) болон Гадаад хэргийн яамны хилийн чанад дахь үйл ажиллагааны хяналтын нэгж (FSCU) террооризмыг санхүүжүүлэх зэрэг зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олж илрүүлэх зорилгоор олон улсын хөгжлийн тусламжийн ашиглалтад хяналт тавьдаг. Уг хяналтыг аудитын тайлан, төсөл, санхүүжилт авсан байгууллагад хяналт шалгалт хийх зэрэг олон янзын аргаар дамжуулан хэрэгжүүлдэг. Гадаад хэргийн яамны хилийн чанад дахь үйл ажиллагааны хяналтын нэгж болон Норвегийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага нь шаардлагатай үед хянан шалгалт хийж, санхүүгийн мэдээллийн нэгжтэй, зохимжтой гэж үзсэн тохиолдолд цагдаагийн албатай мэдээлэл солилцдог.

АББ-ууд мөн банкинд данс нээлгэхийн тулд бүртгүүлэх шаардлагатай байдаг. Түүнчлэн, Норвеги Улс татварын таатай нөхцөл зэрэг хөшүүрэг ашиглах замаар АББ-ууд сайн дураар бүртгүүлэх явдлыг хөхиүлэн дэмждэг.

### Хайрцаг 14. Исл оф Мэн

Исл оф Мэн өмнө нь ашгийн төлөө бус бүхий л салбарыг хамарсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санаачлагад нийцэж буй байдлын бүртгэл, хяналтын горим журмыг хэрэгжүүлэхээр хэд хэдэн удаагийн оролдлого хийж ирсэн. Салбартай зөвлөлдсөний үндсэн дээр ашгийн төлөө бус салбарыг бүхэлд нь биш, харин терроризмыг санхүүжүүлэх хамгийн өндөр эрсдэлтэйд тооцогдож буй АББ-уудыг дэг журамд хамруулах аргыг санал болгож чадсан.

Исл оф Мэн бүртгэл, хяналтын горим журамд хамруулах АББ-уудад тохирох тусгайлан нэрлэсэн ашгийн төлөө бус байгууллагын (SNPO) нэр томъёог боловсруулсан. Энэхүү нэр томъёонд хамааруулах шалгуур үзүүлэлтүүд нь ФАТФ-ын АББ-ын тодорхойлолт болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй холбоотой хэд хэдэн хүчин зүйлд үндэслэгдсэн<sup>1</sup>. Салбарын хамгийн их анхаарал татсан хэсгийг багасгаснаар, Исл оф Мэн нь бүртгэл, хяналтын дэглэмийн шаардлагыг хангахтай холбоотой бий болох заавал шаардлагагүй хүндрэл учруулахаас эрсдэл багатай АББ-уудыг хамгаалахын сацуу хүчин чармайлт болон нөөцөө үр ашигтай ашиглах боломж бүрдүүлж чадсан байна.

<sup>1</sup> Тусгайлан нэрлэсэн ашгийн төлөө бус байгууллагыг ("SNPO") дараахь байдлаар тодорхойлсон: "дангаараа буюу гол нь буяны, шашны, соёл, боловсрол, улс төр, нийгэм, ах дүүгийн найрамдлын зорилгоор хөрөнгө босгох, хуваарилан түгээх, олон нийтэд эсхүл олон нийтийн тодорхой хэсэгт ашиг тусаа өгөх зорилгоор байгуулагдсан (i) жилийн эсвэл тооцоолсон жилийн орлого 5 000 Паунд/GBP ба түүнээс дээш, (ii) аль нэг жилд, нэг буюу түүнээс дээш тооны өндөр эрсдэлтэй газар нутагт нэг буюу түүнээс дээш тооны эцсийн хүлээн авагчид өөрийн орлогын 30-аас доошгүй хувийг шилжүүлсэн буюу, эсхүл урьдчилсан байдлаар шилжүүлэхээр тооцсон нэгдмэл корпораци, эсхүл бусад хуулийн этгээд, итгэлцлийн ивээн тэтгэгч, нөхөрлөл, бусад холбоо, эсхүл байгууллага болон түүнтэй төстэй, эсхүл нэг ижил бүтэц, зохион байгуулалт"

ФАТФ-ийн АББ-ын тодорхойлолтод дурдсан "бусад сайн ажил үйлс" гэсэн ойлголтыг анхдагч хууль тогтоомжид бодитойгоор оруулан хэрэгжүүлэхэд хэтэрхий бүрхэг гэсэн үндэслэлээр үүнийг тодорхойлолтод оруулаагүй болно. Энэхүү эскиз нь уг бичвэрийг хийж байх үед хууль тогтоомжид хараахан тусгагдаагүй байсан тул эцсийн хувилбарт бага зэрэг өөрчлөгдсөн байдлаар орж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

### Хайрцаг 15. Канад

Канадад бүртгэлтэй олон буяны байгууллагууд ФАТФ-ын АББ-ын тодорхойлолтын хүрээнд багтдаг тул террорист зүй бус үйлдэлд өртөмтгий гэж үздэг. Эдгээр өвөрмөц эмзэг байдлыг харгалзан үзэх үндсэн дээр Канад дахь буяны байгууллагуудын үндэсний зохицуулагч болох Канадын Орлогын Агентлаг терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих, терроризмын эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор бүртгэгдсэн буяны байгууллагуудын асуудлаар мэргэшсэн тусгай хэлтэс байгуулсан. Уг хэлтсийн эрхлэх ажлын хүрээнд терроризмтой холбогдсон байгууллагууд татварын хөнгөлөлт эдэлдэг буяны байгууллага гэж бүртгэгдэхээс урьдчилан сэргийлэх, холбол сүлбээтэй бол, түүнийг олж илрүүлэх, бүртгэлийг хүчингүй болгох зэрэг үйл ажиллагаа багтдаг.

Тус хэлтэс нь өргөдөл гаргагч болон бүртгүүлсэн буяны байгууллагуудын үйл ажиллагааг шалгахдаа эрсдэлд-суурилсан аргыг ашигладаг бөгөөд үүндээ тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй газар нутаг, терроризм, террористуудыг санхүүжүүлэхтэй холбоотой байгууллагуудтай холбогдсон эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзан үздэг. Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг чиглэлээр сургалтанд хамрагдсан, мэргэшсэн мэдээллийн ахлах шинжээч, судлаач, аудиторүүд нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, аюулгүй байдлын түншүүдийн нууцын зэрэглэлтэй мэдээлэл, байгууллагуудын өөрсдийнх нь ирүүлсэн мэдээллийг ашиглан тойм судалгаа хийдэг. Хэрэв өргөдөл гаргагч буяны байгууллага нь терроризмтой холбоотой ямар нэгэн шалтгаанаар бүртгэлийн шаардлагыг хангаагүй бол түүний өргөдлийг хүлээн авахаас татгалздаг. Хэрвээ, аль хэдийн бүртгэгдсэн буяны байгууллага нь бүртгэлийн шаардлагыг хангаагүй тохиолдол гарвал, терроризмтой холбогдсон зэрэг шалтгаанаар уг хэлтэс соён гэгээрүүлэх захидал илгээх, нийцлийг хангах тухай гэрээ байгуулах, мөнгөн торгууль ногдуулах зэрэг олон янзын зохицуулалтыг арга хэмжээ авч хэрэгжүүлэх ба тохиолдол нэлээд ноцтой бол бүртгэлийг цуцлах боломжтой байдаг. Хэрэв энэхүү хэлтэс нь эдгээр зохицуулалтын үүргийг гүйцэтгэхдээ терроризмын мөрдөн шалгалттай холбоотой мэдээлэл олж авсан тохиолдолд, тухайн мэдээллийг үндэсний аюулгүй байдлын түншүүд болон хууль сахиулах байгууллагуудтай хуваалцах эрхтэй.

Терроризмтой холбогдсон байгууллагуудаас урьдчилан сэргийлэх, тасалдуулах зорилгоор өргөдөл гаргагч болон бүртгүүлсэн буяны байгууллагуудад хяналт тавих явдал нь Засгийн газарт терроризмыг дэмжихэд буяны зориулалтын хөрөнгө нөөцийг ашиглуулахаас урьдчилан сэргийлэхэд нь тус дөхөм үзүүлдэг байна.

## ҮР ДҮНТЭЙ ХЯНАН ШАЛГАЛТ БА МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ

### Хайрцаг 16. Португал

Португал улс нь Татварын алба болон Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ны хооронд мэдээлэл солилцох форум бүрдүүлдэг Байнгын харилцан ажиллагааны бүлгийг (PLG) бий болгох хууль тогтоомжтой болсон. Татварын алба нь татварын гэмт хэрэг, түүнтэй холбоотой мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд Байнгын харилцан ажиллагааны бүлгээр дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан эрх бүхий байгууллагуудтай өргөн хүрээг хамарсан мэдээлэл солилцох боломжтой байдаг. Үүнд АББ-уудыг террорист зорилгоор зүй бусаар ашиглаж болзошгүй АББ-уудын хүлээн авсан хандив, АББ-уудад хувь хүмүүсийн өгсөн хандив болон татвараас зайлсхийхийн тулд оффшор бүс дэх ашиг хүртэгсдэд санхүүгийн системээр дамжуулан хил дамнасан шилжүүлэг хийсэн тухай мэдүүлэг гаргасан тухай мэдээллийг хуваалцах асуудал багтана.

### Хайрцаг 17. Америкийн нэгдсэн улс

АНУ-ын Засгийн газар ашгийн төлөө бус салбар дахь террорист үйлдлийг олж илрүүлэх, саатуулах, таслан зогсоох зорилгоор байгууллагууд дундын гэж нэрлэгддэг арга ашигладаг. Тус бүр өөрийн эрх мэдлийн параметрийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн агентлаг хамтран ажиллаж, бэлэн байгаа өгөгдөл, аюул заналхийлэл, чиг хандлагад дүн шинжилгээ хийж, Засгийн газрын авч хэрэгжүүлбэл зохих хариу арга хэмжээг тодорхойлдог.

Холбооны түвшинд ТС-ийн гэмт хэргийг мөрдөн шалгах, ялах ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Засгийн газрын гол байгууллага болох Хууль зүйн яам (ХЗЯ (DOJ)) террористуудыг санхүүжүүлэгчдийг мөрдөн шалгах, татан буулгах, улмаар ирээдүйн дэмжигчдийг саатуулан зогсооход өөрийн бүрэн эрхийг ашигладаг. Энэхүү эрхэм зорилгодоо хүрэхийн тулд терроризмын үйл ажиллагааны санхүүгийн эх үндэс мөрдөн мөшгөх явдал чухал гэж үздэг бөгөөд ТС-ийн бүхий л үйл ажиллагааг олж илрүүлэн таслан зогсоох зорилгоор 2001 оны 9-р сарын 11-ний дараахан Холбооны мөрдөх товчооны дэргэд Терроризмын санхүүжилтын асуудал эрхэлсэн нэгж (ХМТ-ТСАЭН (FBI-TFOS)) байгуулсан. Энэхүү нэгж нь ХМТ-ны ТС-ийг ивээн тэтгэгчдийг мөрдөн шалгах ажиллагааг удирдан зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд ХМТ-ны терроризмтой тэмцэх (ТТ) мөрдөн шалгалтад санхүүгийн мөрдөн шалгах арга техник ашиглах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. ХМТ-ТСАЭН нь орон нутгийн түвшний терроризмын эсрэг хамтарсан ажлын хэсгээр дамжуулан холбооны, мужийн болон орон нутгийн хууль сахиулах байгууллагуудын терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хүчин чармайлтыг удирдан зохицуулдаг Үндэсний терроризмын эсрэг хамтарсан ажлын хэсэгтэй нягт хамтран ажилладаг. Түүнчлэн, ХМТ-ТСАЭН болон Хууль зүйн яамны бусад бүрэлдэхүүн хэсэг нь ТС-ийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад хангалттай нотлох баримт гаргаж өгсөн тохиолдолд, АНУ-ын Прокурорын газрууд ХЗЯ-ны Үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн болон татварын хэлтэстэй нягт хамтран ажиллах замаар террорист байгууллагуудад зүй бусаар ашиглагдсан буяны байгууллагуудын хэрэг зэрэг ТС-тэй холбоотой хэргүүдийг шийдэхдээ холбооны эрүүгийн хуулиудыг хөшүүрэг болгон ашигладаг.

Ашгийн төлөө бус салбарт тулгардаг ТС-ийн аюул заналыг олж илрүүлэх, арга хэмжээ авах чиглэлээр Хууль зүйн яам болон хууль сахиулах байгууллагуудтай нягт уялдаатай ажилладаг байгууллагуудад АББ-уудын зохицуулагч болохын хувьд Дотоод Орлогын алба (ДОА -IRS), мөн Сангийн яамны хэд хэдэн алба, үүний дотор Мэдээлэл, судалгааны алба (МСА-OIA), Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ буюу FinCEN

(АНУ-ын санхүүгийн мэдээллийн алба), Гадаад дахь активыг хянах алба (ГАХА -OFAC) болон бодлогын газар ордог. Түүнчлэн, ашгийн төлөө бус салбар дахь террорист заналхийллийг олж илрүүлэх, хариу арга хэмжээ авахын тулд Сангийн яамны хэд хэдэн газар хэлтсүүд энэ асуудлаар сурталчилгаа хийх болон олон улсын түвшинд хүрч ажилладаг.

АНУ-ын татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Сангийн яамны харьяа ДОО нь АНУ-ын Засгийн газрын терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилд, ялангуяа АНУ-ын татварын хуулийг зөрчсөн тохиолдлыг, мөнгө угаах болон бусад эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй ДОО-ны Эрүүгийн Мөрдөн шалгах хэлтэс, татварын хөнгөлөлт эдэлдэг байгууллагуудтай холбоотой ДОО-ны хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ДОО-ны Татварын хөнгөлөлт/төрийн байгууллагууд (TE/GE) –ийн хэлтсийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах үүрэг хүлээдэг. ТС-ийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд туслах эрх олгосон тохиолдолд, эдгээр ДОО-ны бүрэлдэхүүн хэсгүүд нь АНУ-ын Засгийн газрын терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх онцгой экспертиз болон эрх мэдлээр хангаж өгдөг. АББ-ууд татварын тухай хууль тогтоомжийг мөрдөж, татварын тайлан гаргах ёстой байдаг тул ДОО нь санхүүгийн тайлан гаргаж хүргүүлэх шаардлагыг зөрчсөн тохиолдлуудад дүн шинжилгээ хийдэг. Энэ нь, терроризмыг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйл ажиллагааны талаар гүн гүнзгий ойлголт өгч, улмаар мөрдөн шалгалт хийхэд хүргэдэг.

FinCEN нь АНУ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтын шаардлагыг тогтоодог. FinCEN нь санхүүгийн байгууллага, хүмүүсээс сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан болон бусад босгод-суурилсан мэдүүлэг авах буюу тодруулга хийх замаар санхүүгийн мэдээлэл цуглуулдаг. Энэхүү санхүүгийн мэдээллийг хууль сахиулах болон мэдээллийн байгууллагуудаас олж авсан мэдээлэл, терроризмыг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйл ажиллагаанд оролцсон хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг олж тогтооход тус дөхөм үзүүлдэг олон нийтэд нээлттэй мэдээлэлтэй хамтад нь ашиглаж болно. FinCEN-ийн мэдээлэл нь терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон этгээдүүдэд чиглэсэн эдийн засгийн хориг арга хэмжээг боловсруулахад хувь нэмэр оруулж, хууль сахиулах байгууллагын эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой байдаг. FinCEN нь үүргээ ноцтой зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст дахин гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхээр хангагдсан байдаг.

Мэдээлэл судалгааны алба нь АНУ-ын мэдээллийн байгууллагуудтай хамтран хууль бус санхүүжилтийн аюул занал, түүний дотор ашгийн төлөө бус салбарын хүрээн дэх терроризмын аюул заналыг олж илрүүлэх чиглэлээр хамтран ажилладаг бөгөөд эдгээр аюул заналд хариу арга хэмжээ авах, тухайлбал, захиргааны хориг арга хэмжээ авах асуудлаар байгууллага дундын өргөн хэлэлцүүлэг хийх санаачлага гаргадаг.

Гадаад дахь активыг хянах алба нь зорилтот гадаадын улс орон, дэглэм, террористууд, олон улсын хар тамхины худалдаачид, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа эрхэлж буй болон бусад аюул заналхийллийн эсрэг АНУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын зорилгод үндэслэн эдийн засаг, худалдааны хориг арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. ГАХА нь Ерөнхийлөгчийн үндэсний онцгой байдлын бүрэн эрхийн хүрээнд, мөн тодорхой хууль тогтоомжоор олгогдсон эрх мэдлийн дагуу АНУ-ын харьяалалд байгаа гүйлгээнд хяналт тавих, эд хөрөнгийг битүүмжлэх, үүнд террорист байгууллагуудыг дэмжиж хандив өргөсөн байгууллагуудад хориг арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Ихэнх хориг арга хэмжээ нь Нэгдсэн үндэстний байгууллага болон бусад олон улсын түвшний эрх мэдэлд үндэслэгддэг ба хамрах хүрээний хувьд олон талт бөгөөд холбоотон Засгийн газруудтай нягт хамтран ажиллах асуудлыг хамарсан байдаг.

**Хайрцаг 18. Канад**

Канад дахь бүртгэлтэй буяны байгууллагуудын үндэсний зохицуулагч байгууллага болох Канадын Орлогын Агентлаг (КОА-CRA) нь терроризмыг дэмжих үйл ажиллагаанд оролцдог буяны байгууллагатай холбоотой асуудлаар үндэсний аюулгүй байдал эрхэлсэн болон хууль сахиулах үүрэг бүхий түнш байгууллагуудтай мэдээлэл солилцох хууль ёсны эрх мэдэлтэй байдаг. Мэдээлэл солилцох үйл ажиллагаанд түлхэц үзүүлэх үүднээс КОА болон түүний түншүүдийн хооронд түр хугацаагаар томилогдон ажиллуулах хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хөтөлбөрийн хүрээнд КОА-ын ажилтнуудыг түнш агентлагуудад, түнш байгууллагуудын ажилтнуудыг КОА-т томилон ажиллуулдаг. Уг хөтөлбөрт хамрагдаж буй ажилтнуудыг хүлээн авч буй агентлагуудын бусад ажилтнуудын нэгэн адил түвшинд авч үзэн ажиллуулдаг бөгөөд тэдгээр нь ашгийн төлөө бус салбартай холбоотой эрсдэлийг тодорхойлоход шаардагдах өөрийн туршлага, мэргэшлээ томилогдон очиж буй байгууллагад ажиллахдаа ашигладаг. Хөтөлбөр нь цаашлаад терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд өөр бусдынхаа гүйцэтгэдэг үүргийн талаар мэдлэг ойлголттой болоход тус дөхөм үзүүлдэг. Энэ нь КОА болон түүний түнш агентлагуудад терроризмыг дэмжигч АББ-тай холбоотой нөхцөл байдлын талаар нэгнээ сэрэмжлүүлж, ашгийн төлөө бус салбарыг хамгаалах талаар зохих арга хэмжээ авах боломж олгодог.



## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНТЭЙ МЕХАНИЗМ

### Хайрцаг 19. Канад, Шинэ Зеланд, Англи

Канад, Шинэ Зеланд, Англи зэрэг хэд хэдэн улс орнууд АББ-уудын талаарх тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох зорилгоор цахим систем боловсруулсан.

Эдгээр улсууд олон нийтэд АББ-уудын статус, үйл ажиллагаа, санхүү, удирдах зөвлөлтэй холбоотой мэдээллийг хайх, нэвтрэх боломжийг олгодог цахим мэдээллийн санд нэвтрэх боломж олгодог. Эдгээр арга хэрэгслийн зарим нь хэрэглэгчдэд мэдээллийг график болон хүснэгт хэлбэрээр харах, АББ-уудын хооронд холболт хийх, тэдгээрийн үйл ажиллагаандаа мөрддөг баримт бичиг, дүрэм болон санхүүгийн тайланг хувилж авах боломж олгодог.

Эдгээр хэрэгслүүд нь ашгийн төлөө бус салбарт ил тод байдлыг хангаж, тэдэнд итгэх олон нийтийн итгэлийг олж авахад тус дөхөм үзүүлдэг. Эдгээр нь мөн, олон улсын хэмжээнд мэдээлэл хуваалцах хэрэгсэл болж өгдөг. Мэдээллийн сангууд олон нийтэд нээлттэй байдаг тул олон улсын түншүүд тэдгээрт хандаж, нутаг дэвсгэрээс нь гадуур үйл ажиллагаа эрхэлдэг АББ-уудын талаар мэдээлэл олж авах боломж олгодог.

### Хайрцаг 20.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267 болон 1373 дугаар тогтоолууд терроризмыг санхүүжүүлэхэд оролцсон АББ-ууд болон тэдгээрийн ажилтнуудыг олж илрүүлэх болон тэдгээрийн эсрэг хориг арга хэмжээ авахад чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд тус дөхөм үзүүлдэг. НҮБ-ын АЗ-ийн 1267 дугаар тогтоолоор Аль-Каида болон түүний хамсаатан бүлэглэлүүдийн эсрэг авах дэлхийн хэмжээний хориг арга хэмжээний дэглэмийг тодорхойлж өгсөн. НҮБ-ын АЗ-ийн 1373 дугаар тогтоол нь улс орнууд терроризмын аюул заналхийллийн эсрэг дотоодын болон харилцан уялдаатай хоёр болон олон талт хориг арга хэмжээ авах боломж олгодог.

НҮБ-ын 1267 дугаар тогтоолын жагсаалтад саяхан оруулсан бүлэглэлүүдэд НҮБ-аас 2015 оны 3-р сарын 13-нд нэрлэсэн Индонезийн HILAL AHMAR SOCIETY INDONESIA (HASI) байгууллага багтсан бөгөөд 2161 (2014) тоот тогтоолын 2 болон 4-р заалтад дурдсанаар уг байгууллага нь Жемаа Исламиахын "гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх, эсхүл үйлдэх үйл ажиллагааны санхүүжилт, төлөвлөлт, дэмжлэг үзүүлэхэд түүнтэй хамтарч, эсхүл түүний нэрийн өмнөөс, эсхүл түүний дэмжлэгтэйгээр оролцох", эсхүл "түүнд элсүүлж" болон "эс бөгөөс үйл ажиллагааг нь дэмжих үйлдэл хийх" замаар Аль-Каидатай холбогдсон.

Индонезийн Хилал Ахмар Нийгэмлэг (ХАН-HASI) нь Жемаа Исламиахын (ЖИ -JI) хүмүүнлэгийн жигүүр гэдэг нь илэрхий болсон. 2011 оноос эхлэн уг байгууллага Индонезид төрийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулсан. Бүхэлд нь авч үзвэл, түүний үйл ажиллагаа буяны салбарынх бус ба ЖИ зэрэг террорист бүлэглэлүүд хүчирхийллийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөрөнгө босгох, ашиглах зорилгоор буяны байгууллагыг ашиглах үйлдлээ үргэлжлүүлсээр байгаа бөгөөд террорист байгууллагынхаа ложистикийн хэрэгцээ шаардлагыг нуун халхлах боломж олгодог болохыг ЖИ-ийн жишээ илтгэн харуулдаг. ЖИ нь 2002 онд Бали аралд бөмбөг дэлбэлж 27 улс орны 200 гаруй хүний аминд хүрсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн.

[www.un.org/sc/committees/1267/NSQDe147E.shtml](http://www.un.org/sc/committees/1267/NSQDe147E.shtml)



## 2-Р ХАВСРАЛТ

### АББ-УУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИШЭЭ

1. Эдгээр нь зарим АББ-уудын зүгээс тухайлсан нөхцөл байдлаас хамааран авч хэрэгжүүлсэн ТС-ийн эрсдэлийг бууруулахад тус дөхөм үзүүлэх зорилго бүхий арга хэмжээний жишээнүүд юм. Практик дээр, тулгарсан тодорхой эрсдэлийг нэг мөр эсхүл хэсэгчлэн бууруулсан сайн жишээ болж чадах эсэхийг тохиолдол нэг бүрийн өвөрмөц онцлог болон нөхцөл байдал тодорхойлно. Тухайлбал, ТС-ийн түвшин болон төрөл, сайн үйлсийн санхүүжилтийн төрөл хэлбэр, эсхүл хуваарилсан хөрөнгө, газар зүйн нөхцөл байдал, бусад хяналтын болон хянан шалгалтын арга хэмжээ авдаг эсэх зэрэг нөхцөл байдал болон орчны төрлүүд уг тодорхойлолтод хамаарна.
2. Эдгээр жишээг бүхий л нөхцөл байдалд ашиглаж болох арга хэмжээний хяналтын жагсаалт, буюу “алтан стандарт” гэж үзэн ашиглаж болохгүй. “Бүгдэд таарч тохирох нэг л жор” арга нь 8-р зөвлөмжид дурдсанчлан, эрсдэлд-суурилсан аргыг зүй зохистойгоор хэрэгжүүлэх шаардлагад нийцэхгүй.
3. АББ-уудын гаргаж өгсөн дор дурдсан жишээнүүдийг дараах дөрвөн ангилалд хуваан авч үзсэн болно. Үүнд:

#### Хайрцаг 21. АББ-уудын сайн засаглал

АББ-уудын эрүүл дотоод засаглалын практик үйл ажиллагааг дараах дөрвөн ангилалд хуваан авч үзэж болно. Үүнд:

- 1) Байгууллагын шударга буюу нэгдмэл байдал;
- 2) Түншийн харилцаа;
- 3) Санхүүгийн хариуцлага ба ил тод байдал;
- 4) Хөтөлбөрийн төлөвлөлт ба хяналт-шинжилгээ.

## БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БУЮУ НЭГДМЭЛ БАЙДАЛ

### Хайрцаг 22.

Олон улсын АББ нь шударга буюу нэгдмэл байдлын үзэл баримтлалын талаар авч үздэг АББ-ын хариуцлагын тогтолцооны гол онцлог шинж чанаруудыг бий болгож өгсөн. Эдгээр онцлог шинж чанаруудыг дараах зурагт дүрслэн үзүүллээ. Үүнд:

#### АББ-ын дотоод засаглалын гол үзүүлэлтүүд

**Засаглалын ойлгомжтой бүтэц, тухайлбал, Удирдах байгууллагын үүрэг (Зөвлөл).**

- Байгууллагын нэр
- Зохион байгуулалтын бүтэц дэх бусад хэсэгтэй харилцдаг харилцааны тодорхойлолт (зөвлөлийн үүрэг менежментийн үүргээс тусдаа байх ёстой)
- Одоогийн УЗ-ийн гишүүдийн жагсаалт, тэдгээрийн ажил мэргэжил болон оршин суудаг хот суурин буюу хаяг
- (зохистой гэж үзсэн тохиолдолд, АББ-д хяналт тавьдаг эсхүл үр шимийг нь хүртдэг өмчлөгчийг олж тогтоох нь зүйтэй)

**Удирдах зөвлөлийг тодорхойлоход авч үзэх зүйлс**

- Гүйцэтгэдэг гол үүрэг болон эрх мэдэл
- Зөвлөлийн гишүүн нэг бүрийн үүрэг хариуцлага
- УЗ-ийн гишүүдийн тооны доод хязгаар
- Гишүүнчлэлийн асуудлыг зохицуулдаг дүрэм журам (үүний дотор, тавигдах шаардлага, түдгэлзүүлэх болон хасах) болон (үргэлжлэх хугацаа, дахин сонгогдох хязгаар)
- Сонгууль явуулах тухай ойлгомжтой горим журам
- УЗ наад зах нь хэдэн удаа хуралддаг болох, хурал зарладаг арга
- Хамтын шийдвэр гаргадаг болохыг тодорхой зааж өгсөн шийдвэр гаргах үйл ажиллагааг зохицуулдаг горим журам (хурал хүчинтэйд тооцогдох ирц, хэрхэн санал хураадаг болох, шийдвэрийн бүртгэл хөтлөлт)
- Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл буюу протокол
- Ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт (Зөвлөлийн хувьд болон байгууллагын хувьд)
- УЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал (УЗ-ийн гишүүд гаргасан зардлаа нөхөн авахаас өөр цалин урамшуулал авах ёсгүй)

<p><b>УЗ-ийн чадамжид дараах зүйлс орно</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ Гүйцэтгэх захирлын жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх</li> <li>■ Санхүүгийн (менежмент) гүйцэтгэл/жилийн санхүүгийн тайланг үнэлж дүгнэх</li> <li>■ Гүйцэтгэх захирлыг томилох үүрэг хариуцлага</li> <li>■ Аудитор татан оролцуулах буюу хөлслөх үүрэг хариуцлага</li> </ul>
---	---

### Санхүүгийн менежментийн гол үзүүлэлтүүд

<p><b>Нягтлан бодох бүртгэлийн суурь арга хэрэгсэл ашигладаг эсэх:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ Данс хөтлөлт (ерөнхий дэвтэр, ерөнхий журнал гэх мэт)</li> <li>■ Бэлэн мөнгөний орлогын баримт</li> <li>■ Бэлэн мөнгөний зарлагын баримт</li> <li>■ Банкин дахь дансны бүртгэл</li> </ul>
<p><b>Нягтлан бодох бүртгэлийн суурь практик үйл ажиллагаа:</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ Нягтлан бодох бүртгэл болон хяналтын хүлээн зөвшөөрөгдсөн буюу батлагдсан зарчмыг мөрдөхөд ашигладаг бичгээр үйлдсэн бодлого болон горим журам</li> <li>■ Ажил үүргийн хуваарь: санхүүжилт олгох зөвшөөрөл олгодог ажилтан (жишээлбэл, Гүйцэтгэх захирал) нь нягтлан бодогч болон бэлэн мөнгөний няраваас өөр хүн байх.</li> </ul>
<p><b>Санхүүгийн тайлагнал ба бүртгэл хөтлөлт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ Удирдах зөвлөлийн зөвшөөрсөнөөр жилийн аудит хийлгэх (аудитор нь тухайн байгууллагад ажилладаг хэн нэгэнтэй харилцаа холбоогүй байх ёстой)</li> </ul>
<p><b>Хууран мэхлэлт болон мөнгө угаахаас сэргийлэх практик үйл ажиллагаа</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ АББ-ын харьяал буюу улсаас гадуур шилжүүлсэн хөрөнгийн бүрэн, үнэн зөвд аудит хийлгэсэн тухай баримт байгаа эсэх</li> <li>■ Гүйлгээ хийх бүрт банкны бүртгэлтэй дансыг мөнгөн гүйлгээнд ашиглах (өдөр тутмын зардалд зориулж бага хэмжээний бэлэн мөнгөнөөс бусад гүйлгээ хийх тохиолдолд)</li> <li>■ Тэдний үйл ажиллагааны үр шимийг хүртэгсэд, хандивлагчид, түншлэгч ТББ-уудын өвөрмөц онцлог, итгэмжлэх, итгэл үнэмшлийг баталгаажуулах горим журам</li> <li>■ ТББ-ын нэр дээрх банкны дансны дугаарын жагсаалт болон хүмүүсийн тухай мэдээлэлд агуулсан баримт бичиг найдвартай бөгөөд нууцлалтай эсэх.</li> </ul>

**Дэвшилтэт систем  
(илүү хөгжсөн  
байгууллагуудын  
тухайд)**

- Хөрөнгө оруулалтын оновчтой бодлого
- Нөөц бий болгох төлөвлөгөө

### Хайрцаг 23.

АББ нь хөгжлийн зарчмын мэдэгдэл болон ёс зүйн стандартыг өөртөө багтаасан Ёс зүйн дүрмийг<sup>1</sup> боловсруулсан бөгөөд үүндээ байгууллага, түүний гишүүдийн баримталбал, сурталчилбал зохих ёс зүйн зарчмуудыг тусгаж өгсөн.

Байгууллагын үйл ажиллагаанд шударга байдлыг хангахтай холбоотой хэсгийг тайланд тодорхойлсон байдлаар дор толилуулав. Үүнд:

*Засаглал:*

- *Байгууллага нэг бүрийг хараат бус, идэвхтэй, мэдээллээр хангагдсан удирдах байгууллага (жишээлбэл, Удирдах зөвлөл) шударга бөгөөд хариуцлагатайгаар удирдана.*
- *Удирдах зөвлөлийн саналын эрхтэй бүх гишүүд байгууллагын өмнө хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг эс тооцвол цалин урамшуулалгүйгээр ажиллана.*
- *Байгууллага нэг бүр бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд тохирохуйц засаглалын тогтолцоотой байх ба түүнийгээ үе үе үнэлж дүгнэдэг байх ёстой. Энэхүү бүтэц нь байгууллагад цаг тухайд нь шийдвэр гаргах, үүргээ биелүүлэх боломж олгодог байх учиртай. Уг тогтолцоонд, засаглалын оновчтой бүтэц, үйл ажиллагааг багтаасан байх; удирдах ажилтнууд болон удирдах зөвлөлийн харилцан холбоо болон шийдвэр гаргах үйл явцыг оруулж өгсөн байх ёстой. .*
- *Байгууллагын удирдах зөвлөл нь байгууллагын жилийн төсөв, ач холбогдол бүхий бодлого, санхүүгийн ажил гүйлгээ, нөхөн олговрын практик, төлөвлөгөө, хөтөлбөрийг хянан баталж, олгогдсон эрх мэдлийн хүрээнд хийсэн ажил, үр дүнгийн төлөөх хариуцлагыг албан тушаалтан, хороо болон ажилтнууд хүлээдэг байх нөхцлийг бүрдүүлнэ.*
- *Байгууллага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үр дүнтэй удирдах бодлого баримталж ажиллана.*
- *Байгууллага нь ялгаварлан гадуурхалтыг хориглох, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, байгууллагын бүхий л түвшинд нийгмийн эмзэг бүлгийн оролцоог дэмжих бодлоготой байна. Энэ нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн тохиолдолд байгууллагын өөрийгөө тодорхойлох эрхийг үгүйсгэх үндэслэл болох ёсгүй.*
- *Удирдах зөвлөл нь байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг баримт бичиг, бодлого, алсын хараа, эрхэм зорилго, зорилтууд, тэргүүлэх чиглэл, нөөц баялгийн уялдаа холбоо, үр ашгийн талаар үе үе зөвлөлдөх, хамтарсан төлөвлөлт хийх замаар үйл ажиллагаагаа эргэн үнэлж дүгнэж байх шаардлагатай.*

**Байгууллагын шударга буюу нэгдмэл байдал:**

- *Байгууллагын ажил хэрэг шударга буюу нэгдмэл байдлаар, ил тод явагдана. Байгууллага нь өөрийн зорилго, хөтөлбөр, санхүү, үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө, засаглалын талаар холбогдох мэдээллийг олон нийтэд бүрэн, нээлттэй, үнэн зөвөөр мэдээлнэ. Үүнд үл хамаарах зүйл бол боловсон хүчний асуудал, хууль эрх зүйн асуудал, өмчлөх эрхийн мэдээлэл, хувийн нууцад хамаарах ёс зүй, хууль эрх зүйн шаардлага байна.*
- *Байгууллага нь нууцыг хадгалах, задруулах буюу нээлттэй болгохтой холбогдсон талуудын эрхийг хүндэтгэн гомдлыг цаг тухайд нь, хараат бус байдлаар шийдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ.*
- *Байгууллага нь холбооны холбогдох бүхий л хууль тогтоомж, түүнд үндэслэгдсэн эсхүл мөрдөгдөж буй мужийн, эсхүл хотын захиргааны хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Канад улсаас гадуур үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нэг бүр өөрийн үйл ажиллагааг зохицуулах гадаадын хууль, тогтоомжийн талаар мэддэг байх ёстой.*
- *Байгууллага нь хууль зөрчсөн болон санхүүгийн зохисгүй үйлдлийг үл хүлцэх бөгөөд оролцогч байх ёсгүй. Байгууллага нь удирдах зөвлөлийн ажилтан, эсвэл сайн дурын ажилтан ямар нэгэн байдлаар буруу зүйл хийсэн тохиолдолд зөрчлийг арилгах шуурхай бөгөөд хатуу чанга арга хэмжээ авна.*

**Хайрцаг 24.**

Нэгэн ТББ ил тод байдал болон сайн засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн хэд хэдэн шилдэг түршлага буюу практик дадлын цувралыг боловсруулсан. Эдгээр шилдэг дадал түршлага нь байгууллагын дотоод удирдамж буюу зааварчилгааг боловсруулахад чиглэл болгон ашиглахад зориулагдсан.

Байгууллагын шударга буюу нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн удирдамжийг доорхи зургаар үзүүлэв:

**Ерөнхий удирдамж чиглэл**

- Ёс зүйтэй зан төлөв, эрх тэгш байдлыг хангах бодлогыг багтаасан байна
- Удирдах зөвлөлийн гишүүдэд цалин урамшуулал олгохгүй

<p><b>Удирдах зөвлөлийн тодорхойлолт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ Гол үүрэг хариуцлага ба эрх мэдэл</li> <li>■ УЗ-ийн гишүүн нэг бүрийн үүрэг, хариуцлага</li> <li>■ Өөрийн үнэлгээ хийхэд тавигдах шаардлага</li> <li>■ Санхүүгийн дансд болон байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл авах УЗ-ийн эрх</li> <li>■ Ашиг сонирхлын зөрчлийн тухай заалт</li> </ul>
<p><b>Удирдлагын багийн тодорхойлолт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>■ Ажилд авах стандарт болон ажил үүргийн тодорхойлолт</li> <li>■ Мэргэжил дээшлүүлэх, тэгш боломж олгох болон хүртээмжтэй байдлыг хөхиүлэн дэмжих</li> <li>■ Байгууллагын ажилтнуудын менежментийг үнэлэхэд тавигдах шаардлага</li> <li>■ Ашиг сонирхлын зөрчлийн тухай заалт</li> </ul>

## ТҮНШИЙН ХАРИЛЦАА

### Хайрцаг 25.

Хараат бус хяналтын байгууллага өөрийн улсын АББ-уудад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хандивлагчдад хариуцлагатай шийдвэр гаргахад нь туслах зорилготой *Ил тод байдлын стандарт ба шилдэг дадал туршлагын талаар* илтгэл бэлтгэж гаргасан.

Ашгийн төлөө бус салбарын нийцлийг үнэлэхэд ашигладаг стандартууд нь блок хэлбэрээр бүтэцлэгдсэн бөгөөд эдгээрийн ихэнх нь терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой, үүний дотор түншийн харилцаанд анхаарал хандуулсан.

- АББ-ууд нь түнш байгууллагаа сонгоход ашигладаг баримтжуулсан горим журам, шалгуур үзүүлэлттэй байх ёстой. Энэхүү горим журмыг удирдах зөвлөл нь батлах ёстой. Шалгуур үзүүлэлтүүдэд түнш байгууллагыг тухайн байгууллагын эрхэм зорилготой холбоотой байх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлагатай байх, Засгийн газраас болон бусад улсын төрийн байгууллагуудаас санхүүжилт авч байсан, хууль тогтоомж мөрдөн ажилладаг, татварын үүргээ биелүүлдэг, санхүүгийн эрүүл бүтэцтэй байх зэрэг шаардлагыг багтааж болно.
- АББ-ууд нь түнш байгууллагуудтайгаа бичгээр гэрээ байгуулсан байна. Бичгээр үйлдсэн гэрээ болон харилцан ойлголцлын санамж бичгийг боловсруулж оролцогчид талууд гарын үсэг зурсан байна. Үүнд санхүүжүүлэгч байгууллага болон хувь хүн, байгууллага, сүлжээний аль нь байхаас үл хамаарч эцсийн хэрэглэгчийг оролцуулсан байх шаардлагатай. Ийм гэрээ нь хөрөнгийг юунд зарцуулах, хэрэглэгчийн зүгээс хариуцлага тооцох боломжтой байлгах үүднээс хэрхэн тайлагнах талаар тусгасан байна. Гэрээнд дотоодын буюу тухайн орон нутгийн ажилтнуудын менежмент хийхэд шаардлагатай гэж тодорхойлогдсон ёс зүйн хэм хэмжээний дагуу тавигдах шаардлагыг багтаасан байна.

### Хайрцаг 26.

Зөрчил, мөргөлдөөний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгэн байгууллага санхүүжилтийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хандивлагч болон түншүүдийг шалгах удирдамж боловсруулсан. Уг байгууллага түншүүд нь террорист байгууллагуудтай холбоогүй, хүний эрхийг зөрчсөн, буруутгагдсан гэж тогтоогдсон аливаа байгууллагатай хандив, гэрээ, түнш, үйлчилгээ авах зэргээр холбогдохгүй гэдгийг баталгаажуулдаг. Байгууллагын нягтлан бодогчид Интерпол, ФАТФ, АНУ-ын Сангийн яамны Гадаад дахь активыг хянах албаны тусгайлан тогтоосон улсад хориг арга хэмжээ авах жагсаалт шиг үүнтэй дүйцэхүйц бусад улс орны Сангийн яамны эрх бүхий байгууллагын нээлттэй эх сурвалж бүхий мэдээллийг ашиглан түнш байгууллагууд, чиг хандлагын талаархи суурь судалгааг хийдэг. Байгууллага нь мөн, бусад байгууллагын байр сууринаас хандивлагчийн болзошгүй зөрчлийн талаар олж мэдэхийн тулд бусад олон улсын АББ-уудтай хамтран ажилладаг.

## Хайрцаг 27.

Өндөр эрсдэлтэй бүс нутагт хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг АББ нь тусламжийн хуваарилалтыг хянах түнш байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулна. Хянан шалгалт дуусч, хамтрагчаа сонгосны дараа АББ нь түнш байгууллагатай бичгээр гэрээ байгуулна. Бичгээр үйлдсэн гэрээнд санхүүжилтийн хуваарилалт, төлбөрийн нөхцөл, тусламжийг хуваарилах ерөнхий нөхцөлтэй холбоотой түншүүдийн хүлээх үүрэг хариуцлагыг тусгахын сацуу терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, хөрөнгийг зүй бусаар ашиглахаас сэргийлэхтэй холбоотой дараахь заалтуудыг оруулна. Үүнд:

- Террорист бүлэглэлд ашиг тус хүргэх ажил гүйгээ хийхийг хориглосон бүх хууль тогтоомжийг дагаж мөрдөнө, террористуудыг дэмждэг хүмүүс болон байгууллагад ямар нэгэн дэмжлэг, туслалцаа үзүүлэхгүй гэсэн түнш байгууллагын стандарт баталгаа буюу тодорхойлолт (энэ заалт нь тухайн улс орны АББ-ын тухай хууль тогтоомжид үндэслэгдсэн байна);
- Түнш байгууллага болон түүний захирлууд нь аливаа эрхээ хасуулж буюу саатуулагдаж байгаагүй, шаардлага хангаагүй байх тохиолдол гаргаж байгаагүй, Холбооны яамд, эсхүл агентлагаас өөрийн хүсэлтээр, эсхүл талуудын шаардлагаар чөлөөлөгдөж буюу эрхээ түдгэлзүүлж байгаагүй гэсэн стандарт баталгаа буюу тодорхойлолт;
- Түншийг цэрэг армийнхан, эсхүл зэвсэглэсэн бүлэглэлүүдэд туслалцаа үзүүлэх, хуваарилалт хийх, харьцах, хөрөнгө олгохыг хориглосон тодорхой заалт;
- Гадаад дахь активыг хянах албанаас болон АНУ-ын Засгийн газар, Европын холбоо, эсхүл Нэгдсэн үндэстний байгууллагаас тусгайлан нэр заасан этгээдүүдийн жагсаалтад нэр дурдагдсан аливаа ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст ямар ч тохиолдолд санхүүжилт олгохгүй талаар түншлэгч байгууллага зөвшөөрсөн тухай тодорхой заалт;
- Террорист байгууллага зэрэг аливаа зэвсэгт бүлэглэлтэй холбогддог, эсхүл зувчуулсан тохиолдол гарсан тухай мэдээллийг тухайн нутаг дэвсгэр дэх түнш мэдээлдэг байхыг шаардсан заалт.

Боломжтой тохиолдолд, бичгээр үйлдсэн гэрээнд гарын үсэг зурж буйг олон нийт болон түншлэгч талууд гэрчилнэ. Энэ нь холбогдох байгууллага, хүмүүс гэрээний заалтуудын талаар мэдлэг ойлголттой болж авах, түүний хэрэгжилтийг бүх нийтээрээ баталгаажуулах нөхцлийг бүрдүүлнэ.



## САНХҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БА ИЛ ТОД БАЙДАЛ

### Хайрцаг 28.

Хараат бус хяналтын байгуулага өөрийн улсын АББ-уудад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хандивлагчдад хариуцлагатай шийдвэр гаргахад нь туслах зорилготой *Ил тод байдлын стандарт ба шилдэг дадал туршлагын талаар* илтгэл бэлтгэж гаргасан. Ашгийн төлөө бус салбарын нийцлийг үнэлэхэд ашигладаг стандартууд нь блок хэлбэрээр бүтэцлэгдсэн бөгөөд эдгээрийн ихэнх нь терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой, үүний дотор санхүүгийн хариуцлага болон ил тод байдалд анхаарал хандуулсан байна:

- АББ-ууд нь бараа материал худалдаж авах, эсхүл ханган нийлүүлэгчдийг сонгох, зардлыг батлах талаар баримтжуулсан бодлоготой байх ёстой. Наад зах нь, гурван ханган нийлүүлэгчээс үнийн санал авдаг, өндөр өртөгтэй бараа, үйлчилгээний захиалгын тухайд, хамгийн сайн бараа, үйлчилгээг олж авахын тулд тодорхой шалгуур хангасан санал авдаг байхыг зөвлөмж болгосон. Мөн ханган нийлүүлэгчид болон байгууллагын УЗ/ажилтан/ түншүүдийн хооронд гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс үйл ажиллагааны нийтлэг журм боловсруулж мөрдөхийг зөвлөмж болгосон. Эцэст нь, ханган нийлүүлэгчид байгууллагын тогтоосон үр ашиг, үр дүн, тогтвортой байдал болон чанарын шаардлагыг хангаж буй эсэхэд үе үе хяналт-шинжилгээ хийж байхыг зөвлөмж болгосон. Эдгээр бүхий л шалгуур үзүүлэлтүүд/горим журмыг байгууллагын УЗ баталдаг байх шаардлагатай. Уг бодлого нь ханган нийлүүлэлтийн хэмжээнээс хамаарч байгууллагын гаргах зардлыг хэн зөвшөөрөх эрх мэдэлтэй болохыг тодорхойлсон байх ёстой.
- Санхүүжилтийн эх үүсвэр, үүний дотор, төрийн болон хувийн хэвшлийн гол хувь нэмэр оруулагчдын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, оруулсан хувь нэмрийн хэмжээ зэрэг нь олон нийтэд нээлттэй байх ёстой.
- АББ-ууд нь ирэх оны жилийн төсвийг, үүнтэй холбоотой өмнөх төсвийн жилийн хувьсагч зэргийг өөртөө багтаасан Захирлын тайлан, хийсэн дүн шинжилгээний хамт бэлтгэх ёстой. Төсөв болон өр барагдуулах асуудлыг удирдах зөвлөл батлах ба энэ нь олон нийтэд нээлттэй байх ёстой.
- АББ-ууд нь төслийн талаархи нэмэлт мэдээлэл болон эцсийн тайланг бэлтгэж, хандивлагчдын хүртээл болгох ёстой.
- АББ нь авилгын эсрэг баримтжуулсан бодлоготой байх ёстой. Байгууллагууд үйл ажиллагаа явуулж буй тодорхой нөхцөл дөх авилгын эрсдэлийг (жишээ нь залилан мэхлэлт, хэт өндөр үнэ, цохилт, давхар төлбөр, хуримтлагдсан цалин хөлс эсвэл валютын ханшийн бүлхай) судалж, тодорхойлдог байх ёстой. АББ-ууд төслийн няхуур төлөвлөлт, ил тод санхүүгийн тайлагнал, төслийн тогтмол тайлагнал, бараа, бүтээгдэхүүний худалдан авалт болон ханган нийлүүлэгчдэд тавибал зохих стандарт, түүнчлэн давхар хяналт, хараат бус мэдээллийн эх үүсвэр ашигладаг байх зэргийг агуулсан шаардлага хангахуйц тогтолцоотой байх ёстой. Мэдээллийн урсгал, авах арга хэмжээ, ногдуулах шийтгэл зэрэг хөрөнгө мөнгийг зүй бусаар ашигласан болох нь илэрсэн тохиолдолд дагаж мөрдөх стандартчиллагдсан үйл явцтай байх шаардлагатай.

## Хайрцаг 29.

Өндөр эрсдэлтэй бүс нутагт хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг АББ нь хориглосон талуудад нөөцийн зориулалтыг өөрчлөн хуваарилах зэрэг хууран мэхлэх үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, олж илрүүлэх зорилгоор олон төрлийн дотоод хяналтын механизм ашигладаг.

Дотоод хяналт нь санхүүгийн хариуцлага болон ил тод байдлыг хангахад чиглэгддэг:

- Санхүү, худалдан авалт, хөрөнгө хадгалалтын гол үйл явц дахь үүрэг хариуцлагыг нэг ажилтанд даатгахаас илүүтэйгээр хэд хэдэн ажилтанд хуваан хариуцуулдаг. Жишээлбэл, бараа худалдан авахдаа худалдан авах ажиллагааны хүсэлт гаргах, үнийн санал авах, нийлүүлэгчийг сонгох, бараа хүлээн авах, төлбөр хийх зэрэг худалдан авалттай холбоотой асуудлыг өөр өөр ажилтанд хариуцуулдаг.
- Зөвшөөрөлгүй гүйлгээ хийгдэхээс зайлсхийхийн тулд санхүүгийн гүйлгээний аливаа үйл явцын хэд хэдэн үе шатанд түүнийг анхлан санаачлагч, батлах этгээд болон санхүүгийн хянагч гарын үсэг зурсан байхыг шаарддаг. Түүнчлэн, байгууллага нь, зөвшөөрөл авах шаардлагатай гол ажил гүйлгээ, ажил үүрэг, ямар түвшин хүртэлх ажил гүйлгээг хэн батлуулахаар оруулах, хэн батлах эрхтэй болохийг тодорхойлсон баримт бичигтэй.
- Хөрөнгө байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тогтмол шалгалт хийдэг. Эдгээр шалгалтанд бэлэн мөнгөний тогтмол болон гэнэтийн тооллого, тоног төхөөрөмжийн жилийн тооллого ордог.
- Санхүүгийн бүх гүйлгээг давхар шалгах эсвэл хянах систем ашиглана. Санхүүгийн ажил гүйлгээ нэг бүрийг анхлан санаачлагчаас өөр ажилтан баталдаг бөгөөд тусдаа ажилтан санхүүгийн хяналт тавьдаг. Түүнчлэн, чек ашигладаг тохиолдолд болон банкны шилжүүлэгт хоёр гарын үсэг шаарддаг.
- Төсвийн зардлын гүйцэтгэлийн тайланг сар бүр үйлдэж удирдах ажилтнуудад танилцуулдаг.
- Санхүү, худалдан авалт, захиргаа болон хөрөнгийн менежментийн хүрээний туслах ажил үүргийг хийж гүйцэтгэхэд ашиглах гарын авлага, горим журмыг байгууллагын орон нутагт хэрэгжүүлж бүхий хөтөлбөрүүд мөрдөж ажиллах шаардлагатай байдаг байна.

## Хайрцаг 30.

Олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг АББ нь НҮБ-ын харьяа байгууллагууд болон бусад хүмүүнлэгийн байгууллагуудтай хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр үе үе гэрээ байгуулан ажилладаг бөгөөд хөрөнгө зарцуулахад хариуцлага, ил тод байдлыг хангахад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Эдгээр нь дараах арга хэмжээнээс бүрддэг. Үүнд:

- Хөтөлбөрийн загвар, төсөв, хэрэгжих боломж, цаашид хэрэгжүүлэх боломжтой төслүүдтэй холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх
- Худалдан авах ажиллагааны үйл явцын гэрээний шаардлагыг хангах, хөтөлбөрийн үр нөлөөний талаар болон дагалдах баримт бичиг бүхий төсвийн хуваарилалтыг тогтмол тайлагнах
- Үйл ажиллагааны үр шимийг хүртэгсдэд үйлчилгээ эсхүл хүмүүнлэгийн тусламж хүргэхтэй холбоотой бүх хөрөнгийг хянан мөшгөдөг байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд санхүүгийн гүйлгээг аль болох томоохон санхүүгийн байгууллагуудаар дамжуулан хийх
- Түнш байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг шалгаж, тайлагнасан зардлууд нь зөвшөөрөгдсөн зардлуудтай тохирч байгааг баталгаажуулах.
- Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг дагаж мөрдөх, жил бүр хараат бус аудит хийлгэх.

## Хайрцаг 31.

Өндөр эрсдэлтэй газар нутагт буюу энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АББ санхүүгийн хариуцлагаа өндөржүүлж, ил тод байдлыг хангахын тулд дараах арга хэмжээ авдаг. Үүнд:

- Гагцхүү гүйцэтгэлийн чухал үе шатуудад тусгасны дагуу шилжүүлэг хийх
- Санхүүгийн тайлагналын хүлээлт ойлгомжтой буюу тодорхой байх
- Зардлыг нотлох эх баримт бичгийн хуулбарыг асуух буюу шаардах
- Түншүүдээс байгууллагынхаа санхүүжилтэнд зориулж тусдаа банкны данс ба эсхүл тооцооны дэвтэр ашиглах хүсэлт гаргах
- Төслийн төсвөөс зөрүүтэй байх тохиолдол гарвал, түншүүд зөвшөөрөл авахыг шаарддаг байх

- Гэрээний нөхцлийг биелүүлээгүй тухайгаа өөрөө тайлагнадаг эерэг үүрэг хүлээх
- Хилийн чанад дахь ажилтнууддаа зориулсан санхүүгийн ойлгомжтой гарын авлага, бүртгэл хөтлөх удирдамж болон үйл ажиллагааны гарын авлагатай байх
- Хилийн чанад дахь ажилтнууддаа санхүүгийн менежментийн дадал олгох сургалт явуулдаг байх
- Төслийн дансанд бодогдсон хүүг төслийн үйл ажиллагаанд эргүүлэн хөрөнгө оруулахыг шаарддаг байх
- Санхүүгийн бүртгэл хөтлөх шаардлага ойлгомжтой буюу тодорхой байх
- Аудитын эрхийг баталгаажуулж, хэрэгжүүлдэг байх

АББ нь төсөл нэг бүрийг санхүүжүүлэхээр зөвшөөрөгдсөн зардлын төрлүүдийг тогтоодог.

Аливаа бусад зардлын нөхөн төлбөрийг хийдэггүй. Энэ нь түншүүдтэй үүсч болзошгүй үл ойлголцлын магадлалыг бууруулдаг бөгөөд санхүүжилтийг зүй бусаар зарцуулах эрсдэлийг мөн бууруулдаг байна.

## ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ БА ХЯНАЛТ

### Хайрцаг 32.

Хараат бус хяналтын байгууллага өөрийн улсын АББ-үүдэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хандивлагчдад хариуцлагатай шийдвэр гаргахад нь туслах зорилготой *Ил тод байдлын стандарт ба шилдэг дадал туршлагын талаар* илтгэл бэлтгэж гаргасан. Ашгийн төлөө бус салбарын нийцлийг үнэлэхэд ашигладаг стандартууд нь блок хэлбэрээр бүтэцлэгдсэн бөгөөд эдгээрийн ихэнх нь терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой, үүний дотор хөтөлбөрийн төлөвлөлт болон хяналт-шинжилгээнд анхаарал хандуулсан байна:

- АББ нь төслийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тухай баримтжуулсан бодлоготой байх ёстой. Үүнд хэрэгжүүлэгч түнш байгууллага (ууд) -ын тодорхойлолт ба санхүүгийн тайлагнал, аудит, газар дээр нь хийсэн хяналт шалгалт, хараат бус болон дотоод үнэлгээний давтамж, хамрах хүрээ зэрэг шаардлагыг багтаасан байх ёстой. Үүнд, мөн шаардлага хангасан тайлагналд үндэслэн мөчлөгийн дагуу төлбөр гүйцэтгэх, тайлагнах шаардлагыг хангаагүй тохиолдолд төлбөр хийхээс татгалзах боломжтой байх талаар тусгасан байх ёстой. Байгууллага нь өөрийн бодлогодоо түнш байгууллагууд, үр шим хүртэгсэд төслийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ хийх үйл явцад хэрхэн оролцохыг тодорхойлж, бодлогоо удирдах зөвлөлөөр батлуулдаг байх талаар тусгайлан заах шаардлагатай.
- АББ нь олон жил дамжин хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги ба, эсхүл жилийн төлөвлөгөө боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулдаг байх ёстой. Жилийн төлөвлөгөөнд зорилго, үзүүлэлтүүд, хийх ажлын цагийн хуваарь болон төслийн хэрэгжилтийг хариуцах газрыг тодорхой зааж өгөх ёстой. Түүнчлэн, төлөвлөгөөнд байгууллагын бүх салбар нэгж, үүний дотор хөрөнгө босгох зэрэг үйл ажиллагааг багтаасан байх ёстой. Төлөвлөгөө боловсруулахад хөтөлбөрийн үр шимийг хүртэгсэд, сайн дурынхан болон байгууллагын ажилтнууд гэх мэт янз бүрийн оролцогч талуудыг хамруулах нь зүйтэй байдаг. Төлөвлөгөөг боловсруулах, хэлэлцэх, батлахад Удирдах зөвлөл мөн оролцдог байх ёстой.
- АББ-үүд байгууллагын олсон ололт амжилт, ашиг тус, үр нөлөөнд хоёр жил тутам үнэлгээ хийдэг, энэ талаар УЗ-өөр батлуулсан бодлоготой байх ёстой.

### Хайрцаг 33.

Өндөр эрсдэлтэй газар нутагт буюу энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АББ санхүүжилт болон үйлчилгээ зориулалтын дагуу гэдгийг баталгаажуулах зорилгоор дараах дотоод хяналтын дэс дараатай арга хэмжээ авна. Үүнд:

- Тухайн газар нутгийн буюу орон нутгийн түнш байгууллагууд болон олон нийтийн төлөөлийн оролцоотой зөвлөлдөх уулзалт зохион

байгуулах замаар үйл ажиллагааны үр шимийг хүртэгсдийг тодорхойлох.

- Боломжит үр шимийг хүртэгсэд болон орон нутгийн түншүүдийн “хориотой талуудтай”<sup>1</sup> холбогдсон эсэхийг шалгаж баталгаажуулах
- Төсвийн зардлын гүйцэтгэлийн тайланг сар бүр тогтмол, цаг тухайд нь тайлагнах, байгууллагын дээд удирдлагад зориулан бэлтгэж хянуулдаг байх
- Түгээлт буюу хангамжийг баталгаажуулах үйл явц, тухайлбал, үр шим хүртэгсдийг баталгаажуулах (үүний дотор, хангамж хүлээн авсныг баталгаажуулах үр шим хүртэгсдийн гарын үсэг эсвэл хурууны хээ болон хүлээн авсан бараа, огноо зэрэг орно), түгээлт буюу хуваарилалтад хяналт тавих (зорилтот бүлгүүдэд суурилсан хяналтын дэлгэц ажиллуулах, эсхүл түгээлтийг шууд хянах боломжгүй тохиолдолд, орон нутгийн түншүүдээр гэрэл зураг, эсхүл видео түгээлгэх) болон түгээлт буюу хуваарилалтын дараа хяналт тавих (үр шим хүртэгсдэд зочилж уулзах болон үр шим хүртэгсдээс түүвэр судалгаа авах).
- Хөрөнгө байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тогтмол шалгалт хийх Эдгээр шалгалтад бэлэн мөнгөний тогтмол болон гэнэтийн тооллого, тоног төхөөрөмжийн жилийн тооллого орно.
- Санхүүгийн гүйлгээний аливаа үйл явцын хэд хэдэн үе шатанд түүнийг анхлан санаачлагч, батлах албан тушаалтан болон санхүүгийн хянагч гарын үсэг зурдаг байх шаардлага.

1 Энэхүү АББ-ын бодлогын дагуу хориотой талуудыг терроризмыг дэмжиж байгаа гэж үздэг талууд болон, эсхүл хориглосон талуудын жагсаалтад орсон талуудын аль нэг, эсхүл өндөр эрсдэлтэй улс орон дахь зэвсэгт бүлэглэлүүдтэй тэмцэлддэг, эсхүл идэвхитэй дэмждэг бусад талуудыг хамтатган авч үзэж тодорхойлдог. Мөн уг бодлогоор эдгээр хүмүүс, аж ахуйн нэгж, байгууллагууд хориглосон талуудын жагсаалтад багтсан эсэхээс үл хамаарч аль нэг талд хээл хахууль өгөх, өндөр эрсдэлтэй орны улс төрийн эрх бүхий байгууллагад төлбөр төлөхийг хориглоно. Үүнтэй холбоотойгоор, өндөр эрсдэлтэй улс орнууд дахь улс төрийн эрх мэдэлтнүүдийг хориглосон талууд гэж үзнэ.

#### Хайрцаг 34.

Хэрэгжүүлэгч түнш байгууллагаар дамжуулан хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын АББ нь хориг арга хэмжээ авсан, эсхүл тухайлсан газар нутгийг хяналтандаа авсан нэр бүхий байгууллага, эсхүл хувь хүмүүс бүхий зөрчил мөргөлдөөнтэй газар нутагт ажиллахдаа дараахь арга хэмжээг авна. Үүнд:

- Соёлын чадамжийг баталгаажуулж, хүмүүнлэгийн тусламжийг зориулалтыг нь өөрчлөх боломжийг багасгах зорилгоор, аюулгүйгээр түгээх буюу хуваарилан хүргэхэд туслах ажилд олон нийтийн манлайлагчид болон оролцогч талуудыг татан оролцуулна.
- Зориулалтыг өөрчилсөн тохиолдол илэрвэл, тусламжийн хуваарилалтыг идэвхтэй хянаж, зогсооно.
- Хориглосон буюу нэр бүхий байгууллага, хувь хүмүүс нутаг дэвсгэрийн хяналтыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд нөөцийн зориулалтыг өөрчлөх эрсдэлийг бууруулах зорилгоор хил залгаа болон мөргөлдөөний бүсэд ойрхон газарт тусламж үзүүлнэ.

Эдгээр арга хэмжээг дараах тохиолдолд хэрэглэсэн:

Нэр бүхий байгууллага, хөтөлбөрийн үр шимийг хүртэгч хүн амд тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий хэрэгжүүлэгч дотоодын түншээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж буй хотыг хяналтандаа авав. Нэр бүхий байгууллага уг хуваарилагдсан тусламжийн хөрөнгийг өөрсдийнх гэж “шинэ нэр” өгч ашиглахыг оролдсон. Хэрэгжүүлэгч түнш байгууллага тусламжийн хуваарилалтыг зогсоохоо нэр бүхий байгууллагад мэдэгдээд, маргаантай газраас гарч явсан. Хэрэгжүүлэгч түнш байгууллага АББ-тай тохирсон нөхцлийн дагуу түгээх боломжтой болох хүртэл нөөцөө төвлөрсөн агуулахад шилжүүлсэн. Эцэстээ, хэрэгжүүлэгч түнш байгууллага тухайн нэр бүхий байгууллагын хяналтанд байдаггүй, үр шим хүртэгч хүн ам бүхий ойр орчмын газруудад тусламжаа хуваарилах боломжтой болсон байна.

### 3-Р ХАВСРАЛТ

## ТӨЛӨӨЛЛИЙН БОЛОН ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

1. Олон орны ашгийн төлөө бус салбар нь уг салбарын байгууллагуудад зориулж дотоод хяналт, эрсдэлийг бууруулах арга хэмжээ зэргийг багтаасан үйл ажиллагаагаа хариуцлагатай, ил тод байлгахад нь туслах стандарт болон санаачилгууд боловсруулдаг төлөөллийн болон өөрийгөө зохицуулах байгууллагуудтай байдаг.
2. Нэг ертөнц итгэлцэл<sup>25</sup> хэмээх засаглал болон хариуцлагын асуудлаар дэлхийд тэргүүлэгч буяны бөгөөд судалгааны байгууллага нь дэлхий дахины иргэний нийгмийн өөрийгөө зохицуулах санаачлагын буюу байгууллагуудын тооллого хийх төсөл хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд, эдүгээ идэвхтэй байгаа 309 санаачлагыг судалж, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшин дэх тэдгээрийн хэв маяг буюу төлөвийн талаархи ойлголтыг гаргаж ирсэн.
3. Нэг ертөнц итгэлцэл байгууллагын вэб хуудаснаас авсан дараах жагсаалтад аттестатчилал явуулдаг санаачлага гаргасан 83 иргэний нийгмийн байгууллагуудын жишээг харуулсан болно.
4. Энэхүү жагсаалт нь иж бүрэн биш бөгөөд зөвхөн ашгийн төлөө бус салбарын санаачлагын жишээг үүнд багтаасан. ФАТФ уг жагсаалтад орсон зүйл нэг бүрийг баталгаажуулах боломжгүй болно.

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Шилдэг нь байх болно	Европын чанарын удирдлагын сан	Европ
EFA Аттестатчилал	Европын хөрөнгө босгох холбоо	Европ
СОА Стандартын 8 дахь удаагийн хэвлэл	Аттестатчилалын зөвлөл	Олон улсын түвшинд
Гадаад тусламжийн аттестатчилал	Гадаад тусламжийн зэрэглэл ХХК	Олон улсын түвшинд
Даян дэлхийн хариуцлагын тайлан	Нэг ертөнц итгэлцэл	Олон улсын түвшинд

<sup>25</sup> Нэг ертөнц итгэлцэл нь дэлхийн засаглал дахь бодлого, шийдвэр гаргах үйл явцыг одоо болон ирээдүйн хүмүүсийн өмнө илүү хариуцлагатай болгож, олон улсын хуулиудыг боловсронгуй бөгөөд бүгдэд тэгш үйлчилдэг болгох зорилгоор судалгаа шинжилгээ хийдэг, шинэчлэл хийх талаар зөвлөмж боловсруулж, сурталчлах үйл ажиллагаа явуулдаг бие даасан, хараат бус буяны байгууллага юм.



Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
НАР 2007 Хүмүүнлэгийн хариуцлага ба чанарын удирдлага	Олон улсын хүмүүнлэгийн хариуцлагын түншлэл	Олон улсын түвшинд
ISO 14000: Хүрээлэн буй орчны менежментийн систем	Олон улсын стандартчиллын байгууллага	Олон улсын түвшинд
ISO 9000: Чанарын удирдлагын стандарт	Олон улсын стандартчиллын байгууллага	Олон улсын түвшинд
ТББ-ын жишиг тогтоох аттестатчилал	Societe Generale de тандалт	Олон улсын түвшинд
Хөрөнгө босгох практик үйл ажиллагааны зарчим ба стандарт	Австралийн хөрөнгө босгох институт	Австрали
ACFID Ёс зүйн дүрэм	Австралийн олон улсын хөгжлийн зөвлөл	Австрали
Австрийн хандивын чанар	Österreichischen Spendengütesiegels (Австрийн хандивлагчдын шошго)	Австри
Guia de Gestão Responsável para OSC (Иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай менежментийн удирдамж)	Parceiros Voluntarios (Сайн дурын түншүүд)	Бразил
ТББ-уудын засаглал ба мэргэжлийн практик үйл ажиллагааны дүрэм, Камбож дахь ТББ-уудын ёс зүйн зарчим, минимум стандарт ба сайн дурын аттестатчиллын арга ухаан	Камбожийн хамтын ажиллагааны хороо	Камбож
Ёс зүйн дүрэм ба үйл ажиллагааны стандарт	Канадын олон улсын хамтын ажиллагааны зөвлөл	Канад
Байгууллагын шударга байдал ба хариуцлагын стандарт	Канадын Христийн буяны зөвлөл	Канад

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Charte de Déontologie des organisations sociales et humanitaires faisant appel a la generosite du public (Олон нийтээс санхүүжилт хүсч буй хүмүүнлэгийн болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудын ёс зүйн дүрэм)	Дүрмийн хороо	Франц
Label "Gouvernance et Gestion Responsable" des associations et des fondations ("Засаглал ба хариуцлагатай менежмент" Сангууд болон холбоодын шошго)	Францын стандартчилал ба аттестатчиллын холбоо	Франц
Ёс зүйн дүрэм	Иргэдийг өмгөөлөгч! Хөтөлбөр /Иргэний санаачлагын төв	Грузин
DZI Spenden-Siegels (DZI Хандивын баталгаа)	Deutsches Zentralinstitut für soziale Fragen (Германы нийгмийн асуудлын төв институт)	Герман
Ил тод байдлын санаачлага Zivilgesellschaft	Транспэрэнси Интернэшнл Deutschland e. V	Герман
Итгэлцлийн худалдааны тэмдэг	Унгарын иргэний нийгмийн хөгжлийн сан	Унгар
Сайн үйлсийн судалгааны санаачлага	Копал түншүүд	Энэтхэг
Энэтхэгт өг итгэл найдварын нэгдэл	Энэтхэгт өг	Энэтхэг
Засаглал ба нийтэд ил болгох хэм хэмжээ болон сайн жишээ туршлага	Итгэл найдварын нэгдэл	Энэтхэг

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Омега зэрэглэл	Энэтхэгийн ТББ-уудын нэгдсэн холбоо	Энэтхэг
Индонезийн ТББ-уудын аттестатчилал	Сатунама	Индонез
Carta della donazione (Хандивын тунхаг бичиг)	Istituto Italiano della Donazione (Италийн хандивын хүрээлэн)	Итали
ТББ-ыг шилдэг түншүүд	Боловсролын хөгжлийн академи – Йорданы иргэний нийгмийн хөтөлбөр	Йордан
ХДХВ, ДОХ-той тэмцэх үндэсний ёс зүйн дүрэм	ДОХ-той тэмцэх үндэсний зөвлөл	Кени
Indicadores de Institucionalidad y Transparencia (Засаглал ба ил тод байдлын үзүүлэлтүүд)	Centro Mexicano para la Filantropia (Мексикийн сайн санааны үйлсийн төв)	Мексик
Жижиг буюны байгууллагуудыг гэрчилгээжүүлэх нь	Centraal Bureau Fondsenwerving (Хөрөнгө босгох төв товчоо)	Нидерланд
Татгалзах зүйлгүйн гэрчилгээ	Centraal Bureau Fondsenwerving (Хөрөнгө босгох төв товчоо)	Нидерланд
Зөвшөөрлийн баталгаа	Centraal Bureau Fondsenwerving (Хөрөнгө босгох төв товчоо)	Нидерланд
АББ-ын аттестатчилалын загвар	Пакистаны энэрлийн төв	Пакистан

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Палестины ТББ-уудын сайн засаглалын гэрчилгээ – Назаха төсөл	АМАН Эвсэл	Палестины газар нутаг
Sistema de Evaluación de Desarrollo Organizacional-SEDO (Байгууллагын хөгжлийн системийн үнэлгээ)	Colegio de Organizaciones para el Desarrollo Social (Нийгмийн хөгжлийн төлөөх байгууллагуудын сургууль)	Парагвай
ТББ-ын аттестатчилал	Филиппины ТББ-ын аттестатчилалын зөвлөл	Филиппин
ИНБ-ын зэрэглэл тогтоох байгууллага	Humaneasy Зөвлөгөө өгөх байгууллага	Португал
Хариуцлагын стандарт	Хариуцлагын сэрэмжлүүлэг- Сьерра-Леон	Сьерра-Леон
Словенийн ТББ-ын чанарын тогтолцоо	Pravno-informacijski center nevladnih organizacij (Словенийн ТББ-уудын эрх зүйн мэдээллийн төв)	Словени
Norma ONG con Calidad (ТББ-уудын чанарын хэм хэмжээ)	Instituto para la Calidad ONG (ТББ-уудын чанарын хүрээлэн)	Испани
Ил тод байдал ба сайн практик үйл ажиллагааны зарчмууд	Lealtad сан	Испани
Хариуцлага, ил тод байдлын тайлан ба Ёс зүйтэй хөрөнгө босгох хэм хэмжээ	Stiftelsen för Insamlingskontroll (Шведийн хөрөнгө босголтын хяналтын сан)	Швед
Label de qualité ZEWO (ZEWO Зөвшөөрлийн баталгаа)	Stiftung ZEWO (ZEWO сан)	Швейцар

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Швейцарын АББ-ын код	Konferenz der Präsidentinnen und Präsidenten grosser Hilfswerke (Томоохон хүмүүнлэгийн болон тусламжийн байгууллагуудын Ерөнхийлөгчдийн бага хурал)	Швейцар
ТББ-ын Чанарын баталгаажуулалтын механизм (QuAM)	Уугуул иргэдийн сайн дурын холбоодын хөгжлийн сүлжээ	Уганда
Хариуцлагын тогтолцоо	Гамшгийн онцгой байдлын хороо	Англи
Зөвшөөрөл авсан үйлчилгээ үзүүлэгчийн стандарт	Чиглүүлэх болон нөхөрлүүлэх сан	Англи
Сайн дурынханд хөрөнгө оруулах стандарт	Сайн дурынханд хөрөнгө оруулах байгууллага	Англи
Хүмүүст хөрөнгө оруулах стандарт	Хүмүүст хөрөнгө оруулагчид	Англи
Мэдээллийн зөвлөгөө болон зааварчилгаа өгөх үйлчилгээний матриц чанарын стандарт	ENTO Ltd.	Англи
Шинэ энэрлийн капитал Бүяны үйл ажиллагааны зэрэглэлийн мэдээллийн сан	Шинэ энэрлийн капитал	Англи
ТББ-ын Индекс хариуцлагын үйлчилгээ	ТББ-ын Индекс	Англи
Жижиг байгууллагуудын чанарын тэмдгийн чанарын баталгаажуулалтын практик үйл ажиллагааны систем (PQASSO)	Бүяны байгууллагуудад үнэлгээ хийх үйлчилгээ	Англи
Чанарын магадлан итгэмжлэл	Олон нийтийн сангийн сүлжээ	Англи

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Чанарын гүйцэтгэлийн тэмдэг	Үйл ажиллагаа 4 Нөлөөлөл	Англи
ТНА's Тусламжийн утасны чанарын стандарт	Тусламжийн утасны холбоо	Англи
Пенсильвани мужийн шилдгийн төлөө стандарт: Ашгийн төлөө бус салбарын ёс зүй ба хариуцлагын дүрэм	Пенсильвани мужийн АББ-уудын холбоо	АНУ
5 Од зэрэглэлийн систем	Санваартны хяналт	АНУ
Америкийн хамгийн шилдэг нь	Америкийн хараат бус буяны байгууллагууд	АНУ
Буяны байгууллагын навигаторын зэрэглэл	Буяны байгууллагуудын навигатор	АНУ
Буяны байгууллагуудын зэрэглэл тогтоох заавар	Америкийн энэрлийн хүрээлэн	АНУ
Хүүхэд ивээн тэтгэх магадлан итгэмжлэлийн төсөл	InterAction – Америкийн олон улсын сайн дурын үйл ажиллагааны зөвлөл	АНУ
Ёс зүйн зарчим ба стандартын дүрэм	Хөрөнгө босгох мэргэжилтнүүдийн холбоо	АНУ
Даян дэлхийн нөлөөллийн гишүүнчлэлийн шалгуур	Даян дэлхийн нөлөөлөл (хуучнаар Олон улсын үйлчилгээний агентлаг)	АНУ
ЕСFA Стандарт ба шилдэг дадал туршлага	Санхүүгийн хариуцлагын протестант шашинтнуудын зөвлөл	АНУ
Зөвшөөрөл өг	Зөвшөөрөл өг (Ариун тунгалаг сан)	АНУ

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
InterAction PVO (хувийн сайн дурын байгууллага) стандарт: Өөрийгөө гэрчилгээжүүлэхийн сайн тал	InterAction – Америкийн олон улсын сайн дурын үйл ажиллагааны зөвлөл	АНУ
Ашгийн төлөө бус байгууллагуудын төгс байдлын суурь стандартын зарчмуудын олон улсын тунхаглал	Ашгийн төлөө бус салбарын үнэлгээ ба нөөцийн төв (NPERCI)	АНУ
Луизиана мужийн төгс байдлын аттестатчилал	Луизиана мужийн АББ-уудын холбоо	АНУ
Охайо мужийн стандарт: Удирдах зарчим	Охайо мужийн АББ-уудын холбоо	АНУ
Оклахома мужийн төгс байдлын стандарт	АББ-уудын төв	АНУ
Чанарын хяналт, магадлан итгэмжлэл ба аттестатчилалын хөтөлбөр	Эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн хамтарсан комисс	АНУ
Гялалзсан гэрэл ба хандивлагчдын сэрэмжлүүлэг	Санваартны хяналт	АНУ
Ухаалаг өглөг өгөгчдийн сүлжээний хариуцлагын ид шид	Бүяны байгууллагуудын хяналтын зөвлөл (Миннесота)	АНУ
Бүяны байгууллагын хариуцлагын стандарт	Илүү сайн бизнесийн товчоо Ухаалгаар өгөх нэгдэл	АНУ
Төгс байдлын стандарт	Сүмийн менежментийн үндэсний манлайллын дугуй ширээний уулзалт	АНУ
Төгс байдлын стандарт	Колорадо мужийн АББ-ын төгс байдлын төв	АНУ
Төгс байдлын стандарт	Делавер мужийн Ашгийн төлөө бус байгууллагуудын хообоод	АНУ

Хүснэгт 1. Аттестатчилал явуулах санаачлага гаргасан иргэний нийгмийн байгууллагын жишээ <sup>1</sup>		
Хөтөлбөрийн нэр	Аттестатчиллын байгууллага	Байршил
Төгс байдлын стандарт: Ашгийн төлөө бус салбарын Ёс зүй ба хариуцлагын дүрэм	Мэрилэнд мужийн ашгийн төлөө бус байгууллагуудын холбоо /Төгс байдлын стандарт хүрээлэн/	АНУ
Юта мужийн Ашгийн төлөө бус байгууллагуудын Ёс зүйн дүрэм	Юта мужийн ашгийн төлөө бус байгууллагуудын холбоо	АНУ
Ил тод байдлын зэрэглэл	Санваартны хяналт	АНУ

1. Дараах вэб хуудсанд байршуулсан: [www.oneworldtrust.org/csoproject/cso/initiatives/results/?type=Certification+scheme](http://www.oneworldtrust.org/csoproject/cso/initiatives/results/?type=Certification+scheme)

р



## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ БА НОМ ЗҮЙ

- КОУХАЗ (CCIC (nd)), *Ёс зүйн дүрэм*, [www.ccic.ca/about/ethics\\_e.php](http://www.ccic.ca/about/ethics_e.php), КОУХАЗ CCIC, Оттава, Канад, (2015 оны 5-р сарын 19-ний өдөр хандалт хийсэн)
- ФАТФ (2014a), *Ашгийн төлөө бус байгууллагуудыг тороорист зорилгоор зүй бусаар ашиглах эрсдэл*, ФАТФ, Парис, Франц, [www.fatf-gafi.org/topics/methodsandtrends](http://www.fatf-gafi.org/topics/methodsandtrends)
- ФАТФ (2014b), *Банкны салбарт зориулсан Эрсдэлд-суурилсан аргын тухай зааварчилгаа*, ФАТФ, Парис, Франц, [www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations](http://www.fatf-gafi.org/topics/fatfrecommendations)
- ФАТФ (2013), *Мөнгө угаах, террористыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ*, ФАТФ, Парис, Франц, [www.fatf-gafi.org/topics/methodsandtrends](http://www.fatf-gafi.org/topics/methodsandtrends)
- ФАТФ (2013), *Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон санхүүгийн хүртээмжийн тухай шинэчилсэн зааварчилгаа*, ФАТФ, Парис, Франц, [www.fatf-gafi.org/topics/financialinclusion](http://www.fatf-gafi.org/topics/financialinclusion)
- ФАТФ (2012), *ФАТФ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон дэлгэрүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт*, FATF, Paris, France, [www.fatf-gafi.org/recommendations](http://www.fatf-gafi.org/recommendations)
- ФАТФ (2008), *ФАТФ-ын Террорист санхүүжилтийн ангиллын тайлан*, ФАТФ, Парис, Франц, [www.fatf-gafi.org/topics/methodsandtrends](http://www.fatf-gafi.org/topics/methodsandtrends)
- Транспэрэнси Интернэшнл (2015), *Европын эдийн засгийн бүс болон Норвегийн тусламж дахь авилгын эрсдэлд анхаарал хандуулах нь*, Транспэрэнси интернэшнл, Берлин, Герман, [www.transparency.org/whatwedo/publication/handbook\\_of\\_good\\_practices\\_preventing\\_corruption\\_in\\_humanitarian\\_operations](http://www.transparency.org/whatwedo/publication/handbook_of_good_practices_preventing_corruption_in_humanitarian_operations), (2015 оны 5-р сарын 19-ний өдөр хандалт хийсэн)